



**ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГА  
ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨР**

**УЛААБААТАР ХОТ БОЛОН СОНГОСОН АЙМГИЙН ТӨВ,  
СУМДЫН АЛБАН БУС ХЭВШИЛ ДЭХ ХҮҮХДИЙН  
ХӨДӨЛМӨРИЙН СУУРЬ СУДАЛГАА**

**"МЭ КОНСАЛТИНГ" ХХК  
2006**

## ГАРЧИГ

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	3
НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР.....	5
СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ.....	6
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНДЭСЛЭЛ.....	10
ҮНДЭСЛЭЛ.....	10
ӨМНӨ ХИЙГДСЭН СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ .....	10
ЗОРИЛГО .....	11
ХАМРАХ ХҮРЭЭ.....	11
ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ.....	11
ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	12
ТУРШИЛТЫН СУДАЛГАА.....	12
ҮНДСЭН СУДАЛГАА .....	15
ТАЙЛАН БОЛОВСРУУЛАЛТ .....	18
СУДАЛГААНЫ ТООН МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ .....	19
СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ.....	19
ГУРАВДУГААР БҮЛЭГ. УЛААНБААТАР ХОТЫН АЛБАН БУС ХЭВШИЛД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮД .....	20
УЛААНБААТАР ХОТЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД .....	20
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ТОО .....	21
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН НАС, ХҮЙС.....	21
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН АМЬДРАЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	22
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭЦЭГ ЭХ.....	24
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН АЖИЛ ОЛГОГЧ.....	26
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ХӨДӨЛМӨРЛӨЖ ЭХЭЛСЭН/ҮРГЭЛЖЛҮҮЛЭН.....	27
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ШАЛТААН .....	27
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН АЖЛЫН ТӨРӨЛ.....	28
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН АЖЛЫН БАЙР.....	32
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС, ОРЛОГО, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ.....	38
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН БОЛОВСРОЛ .....	40
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНД.....	43
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЧӨЛӨӨТ ЦАГ .....	44
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГОСОН АЙМГИЙН ТӨВ, СУМДЫН АЛБАН БУС ХЭВШИЛ ДЭХ ХҮҮХДҮЙН ХӨДӨЛМӨР .....	45
СОНГОСОН АЙМГИЙН ТӨВ, СУМДЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД .....	45
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ТОО .....	48
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН НАС, ХҮЙС.....	49
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭЦЭГ ЭХ.....	51
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ХӨДӨЛМӨРЛӨЖ ЭХЭЛСЭН/ҮРГЭЛЖЛҮҮЛЭН.....	53
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН АЖЛЫН ТӨРӨЛ.....	54
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН АЖЛЫН БАЙР.....	55
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ .....	56
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН БОЛОВСРОЛ .....	56
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНД.....	58
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЧӨЛӨӨТ ЦАГ .....	58
ТАВДУГААР БҮЛЭГ. ЗӨВЛӨМЖ .....	59
ХАВСРАЛТУУД .....	60

## ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн төрөл .....	13
Хүснэгт 2 Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан хороодын жагсаалт .....	14
Хүснэгт 3 Судалгаанд хамрагдсан аймгийн төв, сумдын сонгогдсон багууд .....	14
Хүснэгт 4 Судалгаанд хамрагдсан хороодод эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн бүртгэл .....	15
Хүснэгт 5 Судалгаанд хамрагдсан аймгийн төв, сумдын сонгосон багуудад эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл.....	16
Хүснэгт 6 Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан хэсгүүдэд оршин сууж буй өрхийн бүртгэл. 17	
Хүснэгт 7 Судалгаанд хамрагдсан аймгийн төв, сумдын сонгогдсон хэсгүүдийн өрхийн бүртгэл ...	17
Хүснэгт 8 Улаанбаатар хотын нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтүүд .....	20
Хүснэгт 9 Дотоодын нийт бүтээгдэхүүн (тэрбум төгрөг) .....	20
Хүснэгт 10 Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн тоо (Улаанбаатар хотын төвийн зургаан дүүрэг ба Налайх дүүрэг) .....	21
Хүснэгт 11 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нас, хүйс .....	21
Хүснэгт 12 Хүүхдүүдийн өрхийн гишүүдийн тоо .....	22
Хүснэгт 13 Хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн өрхийн сууцны төрөл .....	22
Хүснэгт 14 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хэрэглэл (давхардсан тоогоор).....	23
Хүснэгт 15 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг, эхийн нас (хувь) .....	24
Хүснэгт 16 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг эхийн боловсролын түвшин (хувь).....	24
Хүснэгт 17 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувь) ....	25
Хүснэгт 18 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг, эхийн хөдөлмөр эрхлэж буй салбар (хувь)....	25
Хүснэгт 19 Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэхэд нөлөөлсөн нэгдүгээр хүчин зүйлс (хувиар) .....	27
Хүснэгт 20 Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэхэд нөлөөлсөн хоёрдугаар хүчин зүйлс (хувиар) .....	27
Хүснэгт 21 Хүүхдүүдэд хөдөлмөр эрхлэх санал тавьсан хүн (хувиар).....	28
Хүснэгт 22 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн үндсэн ажлын төрөл.....	29
Хүснэгт 23 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нэмэлт ажлын төрөл .....	29
Хүснэгт 24 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн үндсэн ажлын төрөл (хувиар) .....	29
Хүснэгт 25 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нэмэлт (давхар) ажлын төрөл (хувиар) .....	30
Хүснэгт 26 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын төрөл (насны бүлэг, үндсэн ажлын төрлөөр) .....	30
Хүснэгт 27 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны байршил (хувиар).....	32
Хүснэгт 28 Хүйтний улиралд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны байршил (хувиар) .....	33
Хүснэгт 29 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны нөхцөл.....	34
Хүснэгт 30 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өртдөг дарамтын хэлбэр (хүйсээр) .....	35
Хүснэгт 31 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өртдөг дарамтын хэлбэр (насны бүлгээр).....	35
Хүснэгт 32 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн дарамт (ажлын удирдлагаар) .....	35
Хүснэгт 33 Хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн ажлын удирдлага, хяналт (хувиар) .....	35
Хүснэгт 34 Хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн ажлын төрөл (ажлын удирдлагаар).....	36
Хүснэгт 35 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хоногт ажилладаг хугацаа (хүйсээр) .....	36
Хүснэгт 36 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хоногт ажилладаг хугацаа (насны бүлгээр).....	36
Хүснэгт 37 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн долоо хоногт ажилладаг өдөр (боловсролын үйлчилгээнд хамрагдсан байдлаар).....	37
Хүснэгт 38 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн долоо хоногт ажилладаг өдөр (насны бүлгээр) ....	37
Хүснэгт 39 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажилдаа хамт явдаг хүн .....	37
Хүснэгт 40 Нэг жилээс богино хугацаагаар хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн тоо (насны бүлгээр) .....	38
Хүснэгт 41 Хөлстэйгээр хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн сарын хөлс.....	39
Хүснэгт 42 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн орлого, хөлсөө авдаг байдал (хувиар) .....	39
Хүснэгт 43 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн орлогын зарцуулалт (дундаж, хувиар) .....	40
Хүснэгт 44 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн уншиж, бичих чадвар (хувиар).....	40
Хүснэгт 45 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн боловсролын түвшин (насаар).....	40
Хүснэгт 46 Хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн сургуульд хамрагдсан байдал (хувиар) .....	41
Хүснэгт 47 Сургууль завсардсан хүүхдүүдийн сургууль завсардахад нөлөөлсөн нэгдүгээр хүчин зүйл (хувиар) .....	41
Хүснэгт 48 Сургууль завсардсан хүүхдүүдийн сургууль завсардахад нөлөөлсөн хоёрдугаар хүчин зүйл (хувиар) .....	42
Хүснэгт 49 Сургуульд огт суралцаагүй хүүхдүүдийн суралцаагүй шалтгаан (давхардсан тоогоор) 42	

Хүснэгт 50 Хүүхдүүдийн эрхлэж буй хөдөлмөртэйгээ холбоотой авсан гэмтлийн төрөл (насны бүлгээр) .....	44
Хүснэгт 51 Хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрүүлдэг газар (насны бүлгээр) .....	44
Хүснэгт 52 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн тоо (сумаар).....	48
Хүснэгт 53 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн хүйс (сумаар) .....	49
Хүснэгт 54 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн хүйс, насны бүлгээр (сумаар) .....	49
Хүснэгт 55 Хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдийн өрхийн сууцны байдал (хувь, сумаар) .....	50
Хүснэгт 56 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн амьдардаг орчин (хувь, сумаар).....	50
Хүснэгт 57 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн халуун хоол өдөр болгон иддэг байдал(хувь, сумаар) .....	50
Хүснэгт 58 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өрхийн ундны усны эх үүсвэр (хувь, сумаар).....	51
Хүснэгт 59 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцгийн боловсролын түвшин (хувь, сумаар).....	51
Хүснэгт 60 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эхийн боловсролын түвшин (хувь, сумаар).....	51
Хүснэгт 61 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн чадвартай эцгийн хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувь, сумаар).....	52
Хүснэгт 62 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн чадвартай эхийн хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувь, сумаар) .....	52
Хүснэгт 63 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэхэд нөлөөлсөн гол хүчин зүйлс (хувь, сумаар) .....	53
Хүснэгт 64 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн үндсэн ажлын төрөл (хувь, сумаар).....	54
Хүснэгт 65 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны байршил (хувь, сумаар).....	55
Хүснэгт 66 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны нөхцөл (тухайн суманд хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдийн дүнд эзлэх хувиар, давхардсан тоогоор) .....	56
Хүснэгт 67 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн боловсролын түвшин (хүүхдийн тоо, сумаар).....	57
Хүснэгт 68 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн боловсрол эзэмшиж буй байдал (сумаар).....	57
Зураг 1 Хороо/багийн түүврийн хүрээ .....	13
Зураг 2 Судалгаанд хамрагдах хүүхэд, эцэг эх, ажил олгогчийг сонгох түүвэрлэлтийн хүрээ .....	15
Зураг 3 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нас, хүйсийн харьцаа .....	21
Зураг 4 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдтэй өрхийн ундны усны эх үүсвэр (хувь) .....	23
Зураг 5 Хөдөлмөр эрхлэж буй хүүхэдтэй өрхийн дундаж мөнгөн орлогын бүтэц (хувь) .....	23
Зураг 6 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн сургуульд хамрагдсан байдал .....	41

## НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР<sup>1</sup>

**Албан бус хэвшил:** Дангаар болон хэсэг бүлгээрээ эрхлэж буй аж ахуйн нэгж хэлбэрээр бүртгүүлэлгүйгээр хувиараа хөдөлмөр эрхлэлтээс бүрддэг жижиг бизнесийг хамруулна.

**Ажил:** Цалин хөлс, ашиг орлого олох эдийн засгийн үйл ажиллагааг хэлнэ. Үүнд: Цалин хөлстэй ажил эрхлэлт, фермийн болон бизнесийн үйл ажиллагаа, өрхийн эдийн засгийн үйл ажиллагаанд хөлсгүй ажил эрхлэх (мал маллах, хариулах, өсгөх, мал аж ахуйн бүтээгдэхүүн бэлтгэх, боловсруулах гэх мэт мал ахуйн холбогдолтой), дадлага туршлага болох зорилгоор дадлага хийх, өрхийн хэрэгцээнд зориулан үр тариа, хүнсний ногоо тарьж ургуулах арчлах зэрэг орно. Түүнчлэн тухайн хүн түр зуурын хугацаагаар амралтаа авсан, түр чөлөөтэй, өвчтэй байсан, ажил хаялт зарласан зэрэг шалтгаанаар түр чөлөөтэй байгаа боловч ажлын байрыг эзэмшиж байгаа бол ажил эрхлэлтэнд хамруулна.

**Ажил олгогч:** Өөрийн ажил мэргэжлээс үл хамааран нэг болон түүнээс олон ажилчидтай аж ахуйн нэгж, хамтарсан үйлдвэрийг удирдаж байгаа хүнийг хэлнэ.

**Ажиллагч:** Улсын болон хувийн ажил олгогчдод ажиллаж байгаа цалин хөлс, урамшуулал, гарын мөнгө болон биет хэлбэрээр хөлс авч байгаа хүнийг хэлнэ.

**Ажилгүйчүүд:** Ажиллах хүчинд хамаарах тухайн хугацаанд ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа болон ажил эрхлэхэд бэлэн байсан, ажил хөдөлмөр идэвхтэй хайсан хүнийг хэлнэ. Ажил хөдөлмөр эрхлэдэггүй ч ажил эрхлэх боломжтой байгаа, ажилд орох өргөдлөө өгсөн болон ярилцлаганд орохоор хүлээж байгаа хүнийг мөн ажилгүйчүүд гэж тодорхойлно.

**Бичиг үсгийн мэдлэг:** Тухайн хүн энгийн өгүүлбэрийг уншиж бичиж чаддаг бол бичиг үсэг мэддэг гэнэ. Харин зөвхөн өөрсдийн нэр юм уу, тоог уншиж бичиж чаддаг, уншиж чаддаг хирнээ бичиж чаддаггүй бол бичиг үсэг мэддэг гэж үзэхгүй.

**Гэрлэлтийн байдал:** Тухайн хүний гэр бүлийн одоогийн байдлыг илэрхийлнэ. Хуулийн дагуу бүртгүүлүүлээгүй ч уламжлалын дагуу болон албадлагаар гэрлэсэн бол түүнийг гэрлэсэн гэж үзнэ.

**Давхар ажил:** Тухайн хугацаанд үндсэн ажлаас бусад ажлыг хэлнэ.

**Өрх:** Байнга хамтран амьдарч, орлогоо нэгтгэн хоол хүнсээ бэлтгэж, нэг тогооноос хоол иддэг нэг буюу хэд хэдэн хүмүүсийг хэлнэ. Эдгээр хүмүүс нь хамаатан садан болон ажил олгогчтойгоо хамтран амьдардаг, цусан төрлийн хамааралгүй, гэрийн үйлчлэгч, бусад хөлсний ажилчид ч байж болно.

**Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч:** Тухайн өрхийн болон ядаж тухайн өрхийн ганц гишүүн байдаг аж ахуйн нэгжид мөнгөн болон биет хэлбэрээр ямар нэгэн цалин хөлсгүйгээр ажиллаж байгаа хүнийг хэлнэ.

**Сургуульд хамрагдалт:** ЕБС, техникийн болон дунд сургууль, коллеж, их, дээд сургуульд сурдаг бол сургуульд хамрагддаг гэж үзнэ.

**Хувиараа хөдөлмөр эрхлэгч:** Бусад ажилчдын оролцоогүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, хамтарсан үйлдвэрийг удирдаж байгаа хүнийг хувиараа хөдөлмөр эрхлэгч гэнэ.

**Цалин хөлс:** Мөнгөн болон биет хэлбэрээр авч байгаа хөлс, урамшуулал, гарын мөнгө, ашиг орлогын хувь, илүү цаг ажилласны мөнгө, ажил олгогчоос хангаж байгаа хоол хүнс, байрыг цалин хөлсөнд хамруулна.

**Үндсэн ажил:** тухайн хугацаанд (сүүлийн долоо хоног, сүүлийн 12 сард) нэгээс олон ажил цалинтай болон хувиараа эрхлэж байгаа бол нийгмийн болон хууль зүйн тал, цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас нь хамааруулан үндсэн ажлыг тодорхойлно. Тухайн хүн зөвхөн нэг л ажил эрхлэдэг бол тус ажлыг үндсэн ажилд тооцно.

**Шилжигч өрх:** Өрхийн тэргүүн нь судалгааны мэдээлэл цуглуулахаас өмнөх сарын дотор өөр аймаг, улсаас шилжин суурьшсан өрх<sup>2</sup>.

**Эдийн засгийн үйл ажиллагааны салбар:** Тухайн хүний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон үйлдвэрийн газрын үйлдвэрлэдэг үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээний төрлөөр тодорхойлогдоно.

<sup>1</sup> ҮСГ, "Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан", Улаанбаатар, 2004

<sup>2</sup> ХАССТ, "Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн", Улаанбаатар, 2004

## **СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ**

**Судалгааны багийнхан судалгааны явцад цуглуулсан мэдээлэл дээр дүн шинжилгээ хийсний эцэст Улаанбаатар хот болон сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд болон тэдний эрхлэж буй хөдөлмөрийн төрөл, нөхцөл байдлын талаар дараах дүгнэлтүүдийг гаргаж байна:**

### **УЛААНБААТАР ХОТЫН АЛБАН БУС ХЭВШИЛ ДЭХ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР**

#### **Хүүхдүүдийн тархаалт, суурьшил:**

- Улаанбаатар хотод албан бус хэвшилд 7-17 насны 4900 орчим хүүхэд хөдөлмөр эрхлэж байна;
- Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдийн 75 орчим хувь нь Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд оршин суудаг байна;
- Улаанбаатар хотын захын хороод, тухайлбал шинээр үүсэж буй гэр хорооллуудад албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн төвлөрөл харьцангуй өндөр байна;

#### **Хүүхдүүдийн өрхийн амьжиргаа:**

- Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 91 хувь нь гэр хороололд амьдарч байна;
- Хүүхдүүдийн өрхийн 90 орчим хувь цахилгаан эрчим хүч хэрэглэдэг байна;
- Хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдийн дундаж өрх сарын орлогынхоо талаас илүүг хүнсэндээ зарцуулдаг байна;
- Хүүхдийн өрхийн орлогын талаас илүү нь тогтвортой бус (тогтмол бус бизнесийн үйл ажиллагааны орлого, бусад мөнгөн эх үүсвэр гэх мэт) эх үүсвэрээс бүрддэг байна;
- Хүүхдүүдийн 31 орчим хувь нь бүрэн бус гэр бүлд өсөж байна;
- Хүүхдүүдийн 99 орчим хувь нь өөрийн гэрт амьдардаг байна;
- Хүүхдүүдийн 45 орчим хувь нь өдөр болгон халуун хоол идэж чаддаггүй байна;

#### **Хүүхдүүдийн эцэг эх:**

- Эцгүүдийн 53 хувь, эхчүүдийн 83 хувь нь 30-45 насныхан байна;
- Эцгүүдийн 40 гаруй хувь, эхчүүдийн 46 орчим хувь нь бүрэн бус ба түүнээс доош түвшний боловсролтой байна;
- Эцгүүдийн 60 орчим хувь, эхчүүдийн 40 орчим хувь нь хөдөлмөр эрхлэдэггүй байна;
- Эцэг эхийн 37 орчим хувь нь өөрийнхөө хүүхдийн хөдөлмөр эрхлэж буйд сэтгэл ханамжтай байдаг байна;
- Эцэг эхийн 75 орчим хувь нь өрхийн амьжиргаа дээшилсэн тохиолдолд хүүхдээ хөдөлмөр эрхлүүлэхийг болиулах санаатай байна;
- Эцэг эхчүүдийн 90-ээд хувь нь хүүхэд ажил хийх нь хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн гэж үзэж байна;

#### **Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн талаар:**

- Хүүхдийн 63 орчим хувь нь хөвгүүд байгаа бөгөөд тэд хөдөлмөрийн харилцаанд охидоос харьцангуй эрт ордог байна;
- Хүүхдүүдийн 80-аад хувийг 13-16 насны хүүхдүүд эзэлж байна;
- Хүүхдүүдийн 14 орчим хувь нь чөлөөт цагийнхаа тодорхой хугацааг загалмайтны шашны сүмд өнгөрүүлдэг байна;

#### **Хүүхдүүдийн хөдөлмөрийн талаар:**

- Хүүхдүүдийн 44 хувь нь бие даан, 27 хувь нь аж ахуйн нэгж болон хувиараа хөдөлмөр эрхлэгчийн аж ахуйд хөдөлмөр эрхлэдэг байна, 29 орчим хувь нь өрхийн бизнест хөлсгүйгээр оролцдог байна;
- Хүүхдүүдийн 68 орчим хувь нь "өрхийн орлогод нэмэр болох" зорилгоор хөдөлмөр эрхлэдэг байна;
- Хөдөлмөр эрхлэж буй хүүхэд эрхлэх ажлаа сонгохдоо юуны өмнө эдийн засгийн ашиг, ажлын үнэлгээ, олж болох орлогыг анхаарч сонголт хийдэг;
- Хүүхдүүдийн 20 орчим хувь нэмэлт (давхар) ажил хийдэг;
- Хүүхдүүд дараах ажлын байранд хөдөлмөр эрхлэдэг байна: 48 орчим хувь нь хүнсний болон барааны зах дээр, 29 орчим хувь нь гудамж, талбайд, 15 орчим хувь нь дэлгүүр, ТҮЦ-нд, 8 орчим хувь нь хогийн цэг, ажил олгогчийн гэрт ажилладаг байна;
- Хүүхдүүд дараах төрлийн хөдөлмөрийг голчлон эрхлэдэг байна: жижиглэн худалдаа эрхлэх; сонин, сэтгүүл зарах; банз зөөх, өрөх; ачаа зөөх, нийтийн тээвэрт (микро автобус) мөнгө хураагч хийх; цэвэрлэгээ хийх; автомашин угаах;
- Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 67 гаруй хувь нь өдөрт 5-8 цаг ажилладаг;
- Хүүхдүүдийн 51 орчим хувь нь хүйтний болон дулааны улиралд гадаа хөдөлмөр эрхлэдэг бөгөөд тэдний дийлэнх олон нь хүйтний улиралд ажлын байрандаа даарч хөрдөг байна;
- Хүүхдүүдийн 80 орчим хувь нь хэт их тоосжилт, чийгтэй ажлын байранд хөдөлмөр эрхлэж байна;

#### **Хүүхдүүдийн боловсрол:**

- Хүүхдүүдийн 40-өөд хувь нь сургуулиас гадуур байна;
- Хүүхдүүдийн 13 орчим хувь нь уншиж, бичих чадваргүй байна;
- Сургуульд суралцахтай холбоотой шууд (унааны зардал, хувцас, хичээлийн хэрэгсэл, сурах бичиг гэх мэт) болон шууд бус (албан болон албан бус байдлаар сургуулийн удирдлага, багш нарын "ангийн тохижилт", "бэлэг авах", "ангийн сан бүрдүүлэх" гэх мэтээр цуглуулж буй хуримтлал) зардлууд хүүхдийн сургууль завсардахад нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг болдог байна;

#### **Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эрүүл мэнд:**

- Хүүхдүүд хөдөлмөр эрхлэхтэй холбоотойгоор голдуу амьсгалын зам, шээс ялгаруулах тогтолцоо, мэдрэлийн тогтолцоо, арьсны өвчин, харшил, гэдэсний халдварт өвчнөөр өвчилдөг байна;
- Хүүхдүүдийн 16 орчим хувь нь хөдөлмөр эрхлэх явцдаа эрхлэж буй ажилтайгаа холбоотойгоор гэмтэж, бэртсэн байна.

## **СОНГОСОН АЙМГИЙН ТӨВ, СУМДЫН АЛБАН БУС ХЭВШИЛ ДЭХ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР**

### **Хүүхдүүдийн тархаалт, суурьшил:**

- Өвөрхангай аймгийн төв Арвайхээр суманд 210 орчим хүүхэд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байна;
- Өвөрхангай аймгийн Хархорин суманд 60 гаруй хүүхэд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байна;
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд албан бус хэвшилд 7-17 насны хүүхэд энэхүү судалгаанд хамрагдсан төрлийн хөдөлмөр эрхлэдэггүй байна;
- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 30 гаруй хүүхэд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэдэг байна;
- Сэлэнгэ аймгийн Мандал суманд 50 орчим хүүхэд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэдэг байна;
- Дархан хотод 440 орчим хүүхэд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэдэг байна;
- Дорнод аймгийн Чойбалсан хотод 720 орчим хүүхэд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэдэг байна;
- Дорноговь аймгийн Сайншанд суманд 110 орчим хүүхэд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэдэг байна;
- Дорноговь аймгийн Замын-Үүд суманд 15 орчим хүүхэд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэдэг байна;

### **Хүүхдүүдийн өрхийн амьжиргаа:**

- Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн дундаж өрх сарын орлогынхоо талаас илүү хувийг хүнсний бараа худалдан авахад зарцуулдаг байна;
- Хүүхдүүдийн 34 орчим хувь нь бүрэн бус гэр бүлд өсөж байна;

### **Хүүхдүүдийн эцэг эх:**

- Эцгүүдийн 30 орчим хувь, эхчүүдийн 40 гаруй хувь нь бүрэн бус ба түүнээс доош түвшний боловсролтой хүмүүс байна;
- Эцгүүдийн 34 орчим хувь, эхчүүдийн 37 орчим хувь нь хөдөлмөр эрхлэдэггүй байна;
- Эцэг эх/асран хамгаалагчийн 64 гаруй хувь нь өөрийнхөө хүүхдийн хөдөлмөр эрхлэж буйд сэтгэл ханамжтай байдаг байна;

### **Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн талаар:**

- Хүүхдүүдийн 52 орчим хувь нь хөвгүүд, 48 хувь нь охид байгаа бөгөөд хүүхдүүдийн хүйсийн харьцаа сумдад ялгаатай байна;
- Хүүхдүүдийн 73 орчим хувийг 15-17 насны хүүхдүүд эзэлж байна;

### **Хүүхдийн хөдөлмөрийн талаар:**

- Хүүхдүүдийн 50 орчим хувь нь “өрхийн орлогод нэмэр болох” зорилгоор хөдөлмөр эрхлэдэг байна;
- Хүүхдүүдийн 50 гаруй хувь нь өрхийн бизнест хөлсгүйгээр оролцдог байна;
- Хүүхдүүд дараах ажлын байранд хөдөлмөр эрхлэдэг байна: 64 орчим хувь нь хүнсний болон барааны зах дээр; 7 орчим хувь нь гудамж, талбайд; 5 орчим хувь нь хогийн цэг дээр; 10 орчим хувь нь ажил олгогчийн гэрт (хөдөө орон нутагт ажлын байр ба ажил олгогчийн гэр нэг доор байх явдал түгээмэл байдаг) 14 хувь нь эдийн засгийн бусад салбаруудад;



- Хүүхдүүд дараах төрлийн хөдөлмөрийг голчлон эрхлэдэг байна: жижиглэн худалдаа эрхлэх; банз, ачаа зөөх; барилга (модоор) барих; цэвэрлэгээ хийх;
- Хүүхдүүдийн 58 хувь нь жилийн дөрвөн улиралд гадаа хөдөлмөр эрхлэдэг бөгөөд тэдний дийлэнх олон нь хүйтний улиралд ажлын байрандаа даарч хөрдөг байна;
- Хүүхдүүдийн 57 орчим хувь нь хэт их тоосжилт, чийгтэй ажлын байранд, 82 орчим хувь нь хэт их халуун, хүйтэн, их дуу чимээтэй, доргилттой ажлын байранд хөдөлмөр эрхлэдэг байна;

**Хүүхдүүдийн боловсрол:**

- Хүүхдүүдийн 32 гаруй хувь нь сургуулиас гадуур байна;
- Чойбалсан хотод (Дорнод аймгийн Хэрлэн сум) албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн 65 орчим хувь нь сургууль завсардсан, сургуульд огт сураагүй хүүхдүүд байна;
- Хөдөө орон нутагт суурь боловсрол эзэмшсэн хүүхдүүд цаашид үргэлжлүүлэн суралцах нөхцөл боломж хязгаарлагдмал нь суурь боловсрол эзэмшсэн хүүхдүүд хөдөлмөрийн харилцаанд (тэд гол төлөв мэргэжлийн үр чадвар шаардагдахгүй, үнэлгээ багатай ажил хийдэг) ороход тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна;
- Орлого бага, эмзэг давхаргынханд хүүхэд нь сургуульд суралцахтай холбоотой шууд (унааны зардал, хувцас, хичээлийн хэрэглэл, сурах бичиг гэх мэт) зардлууд хүүхдийн сургууль завсардахад нөлөөлдөг байна;

**Хүүхдүүдийн эрүүл мэнд:**

- Хүүхдүүдийн 17 орчим хувь нь хөдөлмөр эрхлэх явцдаа эрхлэж буй ажилтайгаа холбоотойгоор гэмтэж бэртсэн байна.

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНДЭСЛЭЛ**

### **ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улс 1990-ээд оноос эхлэн зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин нийгмийн тогтолцооны шилжилтийн туршид хүүхдийн хөдөлмөртэй холбоотой асуудлууд нийгмийн өмнө тулгарсан бэрхшээлүүдийн нэг болсон.

Монгол улсын Засгийн газар Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182-р Конвенцид 2001 онд, ажил эрхлэх насны доод хязгаарын тухай 138-р Конвенцэд 2002 онд тус тус нэгдэн орсон билээ.

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, тэдний хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах чиглэлийн үйл ажиллагааг ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр орон нутгийн удирдлага, ТББ-уудтай хамтран хэрэгжүүлэхэд Улаанбаатар хот болон сонгогдсон хот суурин газруудын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн тоо, тэдний хөдөлмөрийн нөхцөл байдлыг тодруулан хүүхэд хөдөлмөрийн харилцаанд ороход нөлөөлж буй хүчин зүйлс, шалтгааныг тодорхойлох асуудал чухал байсан тул энэхүү судалгааг ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр санхүүжүүлэн гүйцэтгүүлсэн билээ.

### **ӨМНӨ ХИЙГДСЭН СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ**

2002 онд МУИС-ын Хүн ам зүйн сургалт, судалгааны төв "Зах дээр хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нөхцөл байдал" судалгааг гүйцэтгэжээ. Улаанбаатар хотод байрлах 11 захад 1000 гаруй хүүхэд хөдөлмөр эрхлэж байсан бөгөөд тэдний 64 хувь нь хөвгүүд гэж нь тус судалгаагаар тогтоогджээ. Хүүхдүүд гол төлөв ачаа зөөх, машин харах, машин угаах, хүнсний хаягдал цуглуулж зарах, ногоо ялгах, цэвэрлэгээ хийх зэрэг ажил хийдэг байв. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 84 хувь нь 16-аас доош насных байсан бөгөөд нийт хүүхдүүдийн 60 орчим хувь нь сургууль завсардсан байв<sup>3</sup>.

ҮСГ 2002-2003 онд "Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа" хийсэн байна. Тус судалгаагаар 5-17 насны 68 580 хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон буюу ажил эрхлэж байсан. Нийт ажил эрхлэж буй хүүхдийн 90.0 хувь нь хөдөө орон нутагт оршин сууж байв<sup>4</sup>.

ҮСГ-ын 2002-2003 онд хийсэн "Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан"-д дурьдсанаар 5-17 насны 73 484 хүүхэд эдийн засгийн идэвхтэй байснаас 68 580 нь хөдөлмөр эрхлэж, 4 904 нь ажил хайж байжээ. Нийт хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 90.8 хувь нь хөдөө аж ахуй болон түүний холбогдолтой ажил эрхлэж байсан бөгөөд тэдний 61.1 хувь нь хөвгүүд байв.

61 677 хүүхэд өрхийн бизнест хөлсгүй оролцож байсан бөгөөд нийт хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 89.9 хувь хөдөө орон нутагт төвлөрч байв. Хөдөлмөрийн хөлстэй ажил хийж буй хүүхдүүдийн 38.4 хувь нь 5 000 хүртэлх, 47.8 хувь нь 5 001-20 000, харин үлдсэн 18.8 хувь нь сарын 20 000 төгрөгөөс дээш орлоготойгоор ажиллаж байна<sup>5</sup>.

<sup>3</sup> ХАССТ, "Зах дээр хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нөхцөл байдал", Улаанбаатар, 2002

<sup>4</sup> ҮСГ, "Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа", Улаанбаатар, 2004

<sup>5</sup> ҮСГ, "Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан", Улаанбаатар, 2004

## **ЗОРИЛГО**

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь Улаанбаатар хот болон сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн тоо, тэдний эрхлэж буй хөдөлмөрийн шинж байдал, боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгааг цогц байдлаар судлан судалгааны үндсэн дээр бодлогын зөвлөмж боловсруулахад оршино. Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно:

- Хүүхдүүдийн тоо, нас, хүйсийн бүтцийг тодорхойлох;
- Хүүхдүүдийн амьдралын нөхцлийг тодорхойлох;
- Хүүхдүүдийн эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, боловсролын түвшинг тодорхойлох;
- Хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэж эхлэх/үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлэж байгаад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох;
- Хүүхдүүдийн ажлын төрөл, ажлын байр, ажлын нөхцөл байдал, хөдөлмөрийн хөлс, орлогыг тодорхойлох;
- Боловсролын үйлчилгээнд хүүхдийн хамрагдаж буй байдал, сургууль завсардалтанд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох;
- Хүүхдүүдийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох;
- Хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрүүлдэг байдлыг тодорхойлох;
- Судалгааны үр дүнг үндэслэн хүүхдийн хөдөлмөрийг бууруулах бодлогын зөвлөмж боловсруулах.

## **ХАМРАХ ХҮРЭЭ**

Энэхүү судалгаанд Улаанбаатар хот болон Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Алтанбулаг, Мандал, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хархорин, Дорнод аймгийн Хэрлэн, Чойбалсан, Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд, Дархан-Уул аймгийн Дархан зэрэг сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй 5-17 насны хүүхдүүд, тэдний эцэг эх/асран хамгаалагч, ажил олгогч нар хамрагдсан болно.

## **ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ**

Энэхүү тайлан нь дараах бүлгүүдээс бүтсэн болно:

- Судалгааны үр дүнгийн хураангуй хэсгээр эхлэх ба энд судалгааны гол үр дүнг танилцуулсан болно;
- Нэгдүгээр бүлэгт судалгааны үндэслэл, зорилго, хамрах хүрээг тодорхойлсон;
- Хоёрдугаар бүлэгт судалгааны арга зүй, аргачлалын талаар танилцуулсан;
- Гуравдугаар бүлэгт Улаанбаатар хотын албан бус хэвшил дэх хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нөхцөл байдал, тэдний эрхлэж буй хөдөлмөрийн талаар танилцуулсан;
- Дөрөвдүгээр бүлэгт сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшил дэх хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нөхцөл байдал, тэдний эрхлэж буй хөдөлмөрийн талаар танилцуулсан;
- Тавдугаар бүлэгт судалгааны үр дүнд боловсруулсан санал зөвлөмжийг дэвшүүлсэн болно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ**

Энэхүү судалгаа нь туршилт судалгааны, үндсэн судалгааны үеүүдээс болон тайлан боловсруулах гэсэн гурван үеэс бүрдсэн. Туршилт судалгааны явцад үндсэн судалгааг гүйцэтгэх аргачлал, ашиглагдах хэрэгслүүдийг боловсруулсан болно.

Үндсэн судалгааны явцад Улаанбаатар хот болон сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд, тэдний эцэг эх, ажил олгогчдоос туршилтын судалгаагаар боловсруулсан хэрэгслүүдийг ашиглан урьдчилан бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу мэдээлэл цуглуулсан.

Тайлан боловсруулах үед үндсэн судалгааны явцад цуглуулсан мэдээллийг тоон хэлбэрт хөрвүүлэн судалгааны тайлан боловсруулахад ашигласан.

### **ТУРШИЛТЫН СУДАЛГАА**

#### **Нэгдүгээр үе шат**

Улаанбаатар хот болон сонгосон аймгийн төв, сумдад албан ба албан бус хэвшилд эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн бүртгэл хийх аргачлал, бүртгэлд ашиглагдах хэрэгслүүдийг боловсруулах нь туршилт судалгааны нэгдүгээр үе шатын үндсэн зорилт байсан.

2005 оны наймдугаар сард Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нэг бүрчлэн бүртгэж тэдний эрхлэж буй үйл ажиллагаа, бизнесийн төрөл, тэдгээрт хүүхэд ажиллаж буй эсэхийг тодруулан жагсаалтыг боловсруулсан. Цуглуулсан мэдээллийг үндэслэн эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг бүртгэх аргачлалыг нарийвчилж цаашид судалгаанд ашиглах эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэх бүртгэлийн маягтын хувилбарыг боловсруулсан болно.

Туршилтын судалгааны нэгдүгээр үе шатанд Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дээр хүүхдийн хөдөлмөр төвлөрсөн газар, хороодын талаарх суурь мэдээллийг цуглуулсан.

#### **Хоёрдугаар үе шат**

Туршилт судалгааны хоёрдугаар үе шатанд дараах зорилтыг дэвшүүлсэн:

- Судалгаанд ашиглагдах санал асуулгын асуумжийг боловсруулж шаардагдах нэмэлт, өөрчлөлтийг оруулах;
- Мэдээллийн нууцлалын асуудал хариулагчийн хувьд хэр чухал байгааг мэдэж тэдний шаардлагад нийцүүлэн асуумжид өөрчлөлт оруулах;
- Судалгаанд хамрагдах хөдөлмөрийн төрлийг нарийвчлан тодруулах;
- Үндсэн судалгаанд хамрагдах хороод/багууд, хэсгүүдийг тодорхойлох.

Туршилт судалгааны хоёрдугаар үе шатанд 2005 оны 8-р сард 2-3 хүний бүрэлдэхүүнтэй баг Улаанбаатар хотын “Нарантуул”, “Хархорин” захууд, “Барс” бөөний худалдааны төв зэрэг газруудад хөдөлмөр эрхлэж байгаа нийт 20 хүүхэд, тэдний эцэг эх, ажил олгогчдыг санамсаргүй түүврээр сонгон судалгааны санал асуулгын асуумжийн эхний хувилбаруудыг ашиглан судалгаанд хамруулсан. Судалгааны мэдээлэл цуглуулах туршлагад үндэслэн санал асуулгын асуумжийн


загваруудад шаардагдах өөрчлөлтүүдийг оруулан асуумжуудын эцсийн хувилбаруудыг боловсруулсан.

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн төрлийн жагсаалтыг мөн энэ үе шатанд боловсруулсан.

**Хүснэгт 1 Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн төрөл**

#	Хөдөлмөрийн төрөл	#	Хөдөлмөрийн төрөл
1.	Жижиг худалдаа	14.	Гутал засах
2.	Мах эвдэх	15.	Авто, дугуй засвар
3.	Ачаа зөөх	16.	Тоосго үйлдвэрлэх
4.	Банз өрөх	17.	Загас барьж зарах
5.	Хог түүх (шил, лааз гэх мэт)	18.	Аргал, мод самар, жимс түүх
6.	Мод хөрөөдөх, хагалах	19.	Цэвэрлэгээ хийх (зах, лангуу)
7.	Вагон түрэх	20.	Ногоо, жимс ялгах
8.	Машин угаах	21.	Нийтийн хоолны газар ажиллах
9.	Машин манах	22.	Сонин сэтгүүл, борлуулах
10.	"Цагаан утас" ажиллуулах	23.	Кондуктор (микро автобус)
11.	Гутал тослох	24.	Архи зарах
12.	Гуйлга гуйх	25.	Тамхи зарах
13.	Барилгын ажил	26.	Бусад:.....

**Зураг 1 Хороо/багийн түүврийн хүрээ**



Улаанбаатар хотын төвийн зургаан дүүрэг болон Налайх дүүргийн 115 хороодыг албан бус хэвшлийн төвлөрөлөөр төвлөрөлийг хорооны байршил, хорооны нутаг дэвсгэр дээр хүнсний болон барааны зах, бөөний худалдааны төв, хогийн цэг зэрэг албан бус хэвшлийн төвлөрөл өндөртэй газар байгаа зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэж хоёр түвшинд хуваасан. Хороод албан бус хэвшлийн төвлөрлөөр доорх байдлаар хуваагдсан:

- "Их төвлөрөлтэй" - 68 хороо;
- "Бага төвлөрөлтэй" - 47 хороо.

Улаанбаатар хотын албан бус хэвшлийн "Их төвлөрөлтэй" дөрвөн хороог "магадлал нэгээр" шууд (тус хороодын нутаг дэвсгэр дээр албан бус хэвшлийн төвлөрөл ихтэй худалдааны захууд, бөөний төв, хогийн цэг байрладаг), "Их төвлөрөлтэй" бусад хороодоос 12 хороог санамсаргүй шууд түүврийн аргаар, "Бага төвлөрөлтэй" хороодоос 10 хороог санамсаргүй шууд түүврийн аргаар тус тус сонгон нийт 26 хороодыг сонгосон.

**Хүснэгт 2 Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан хороодын жагсаалт**

#	Дүүрг	Хорооны дугаар	Төвлөрөл	Үндэслэл	Сонгосон аргачлал
1.	Баянгол	3	Их	"Барс" бөөний худалдааны төв, Төмөр замын өртөө	"Магадлал нэгээр" албан бус хэвшлийн төвлөрөлт "ихтэй" 68 хороодоос шууд
2.	Сонгинохайрхан	4		"Улаанчулуут"-ын хогийн цэг	
3.	Баянзүрх	14		"Нарантуул" зах	
4.	Баянгол	20		"Хархорин" зах	
5.	Сүхбаатар	9	Их		Албан бус хэвшлийн төвлөрөлт "их" гэж тодорхойлсон 64 хороодоос санамсаргүй шууд түүврийн аргаар сонгосон
6.	Чингэлтэй	2			
7.	Сүхбаатар	5			
8.	Хан-Уул	6			
9.	Сонгинохайрхан	14			
10.	Чингэлтэй	11			
11.	Баянзүрх	5			
12.	Сонгинохайрхан	15			
13.	Налайх	3			
14.	Баянзүрх	8			
15.	Сүхбаатар	13			
16.	Чингэлтэй	4			
17.	Сүхбаатар	4	Бага		Албан бус хэвшлийн төвлөрөлт "бага" 47 хороодоос санамсаргүй шууд түүврийн аргаар сонгосон
18.	Баянгол	16			
19.	Баянгол	12			
20.	Налайх	2			
21.	Баянзүрх	7			
22.	Чингэлтэй	14			
23.	Хан-Уул	8			
24.	Сонгинохайрхан	10			
25.	Чингэлтэй	18			
26.	Баянзүрх	16			

Судалгаанд хамрагдсан аймгийн төвийн багуудыг албан бус хэвшлийн төвлөрөлөөр нь "төвлөрөл ихтэй"), "төвлөрөл багатай" гэж хоёр ангилан судалгаанд хамрагдах хоёр баг болон тухайн багуудын хэсгүүдийг дараах байдлаар сонгосон:

- "Магадлал нэгээр" албан бус хэвшлийн төвлөрөлт "ихтэй" (хүнсний, барааны зах байрладаг) багийг шууд сонгон тус багаас санамсаргүй шууд түүврийн аргаар судалгаанд хамрагдах хоёр хэсгийг сонгосон;
- "Төвлөрөл багатай" багуудаас санамсаргүй түүврийн аргаар судалгаанд хамрагдах багийг сонгож тус багаас мөн санамсаргүй түүврийн аргаар судалгаанд хамрагдах хоёр хэсгийг сонгосон болно.

Судалгаанд хамрагдах сумын төвийн багуудаас албан бус хэвшлийн "төвлөрөл ихтэй" нэг багийг (хүнсний, барааны зах байрладаг) сонгон тус багаас санамсаргүй шууд түүврийн аргаар хоёр хэсгийг сонгосон.


**Хүснэгт 3 Судалгаанд хамрагдсан аймгийн төв, сумдын сонгогдсон багууд**

Аймаг	Сум	Сонгогдох багийн тоог тодруулах үндэслэл	Сонгогдсон баг	
Өвөрхангай	Арвайхээр	Аймгийн төв	2-р баг	5-р баг
	Хархорин	Сумын төв	3-р баг (Эрдэнэтолгой)	
Сэлэнгэ	Сүхбаатар	Аймгийн төв	1-р баг	2-р баг
	Алтанбулаг	Сумын төв	2-р баг (Суварга)	
	Мандал	Сумын төв	3-р баг (Баянсуудал)	
Дархан-Уул	Дархан	Аймгийн төв	1-р баг	7-р баг
Дорнод	Хэрлэн	Сумын төв	6-р баг	10-р баг
	Чойбалсан	Хилийн боомт	"Хавирга" хилийн боомт байрлах баг	
Дорноговь	Сайншанд	Аймгийн төв	1-р баг	2-р баг
	Замын-Үүд	Сумын төв	1-р баг	

Судалгаанд хамрагдсан хороо/багийн нутаг дэвсгэрт эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэлийг гүйцэтгэх, тухайн ажлын байранд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийг түүвэрлэх аргачлалыг боловсруулсан болно.

Мөн сонгосон хороо/багийн судалгаанд хамрагдах хэсгүүд, тухайн хэсэгт оршин сууж буй өрхийн бүртгэл хийх аргачлал, бүртгэгдсэн өрхүүдээс хөдөлмөр эрхлэж буй хүүхэдтэй өрхийг түүвэрлэх аргачлалыг боловсруулсан.

Зураг 2 Судалгаанд хамрагдах хүүхэд, эцэг эх, ажил олгогчийг сонгох түүвэрлэлтийн хүрээ



## ҮНДСЭН СУДАЛГАА

### Нэгдүгээр үе шат

Судалгааны багийнхан 2005 оны 9-11-р саруудад Улаанбаатар хот болон судалгаанд хамрагдах аймгийн төв, сумдын сонгогдсон хороод/багуудын нутаг дэвсгэр дээр эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нэг бүрчлэн бүртгэсэн. Тус бүртгэлд аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйл ажиллагааны салбар, тус нэгжид хөдөлмөр эрхлэж буй хүүхэд байгаа эсэх бүртгэгдсэн.

### Хүснэгт 4 Судалгаанд хамрагдсан хороодод эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн бүртгэл

#	Дүүрэг	Хорооны дугаар	Эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тоо	Хөдөлмөр эрхлэдэг хүүхдийн тоо	Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо
•	Баянгол	3	1104	3	3
•	Сонгинохайрхан	4	47	6	3
•	Баянзүрх	14	11801	4	2
•	Баянгол	20	2318	19	3
•	Сүхбаатар	9	199	-	-
•	Чингэлтэй	2	1195	8	1
•	Сүхбаатар	5	266	1	-
•	Хан-Уул	6	72	1	1
•	Сонгинохайрхан	14	123	9	-
•	Чингэлтэй	11	487	8	-
•	Баянзүрх	5	269	18	2
•	Сонгинохайрхан	15	152	4	2
•	Налайх	3	223	3	-
•	Баянзүрх	8	201	4	1
•	Сүхбаатар	13	41	6	2
•	Чингэлтэй	4	413	-	-
•	Сүхбаатар	4	160	-	-
•	Баянгол	16	155	1	-
•	Баянгол	12	154	-	-
•	Налайх	2	416	1	-
•	Баянзүрх	7	219	2	1
•	Чингэлтэй	14	72	-	-
•	Хан-Уул	8	34	-	-
•	Сонгинохайрхан	10	203	6	1
•	Чингэлтэй	18	88	-	-
•	Баянзүрх	16	133	-	-
<b>Нийт</b>			<b>20 545</b>	<b>104</b>	<b>22</b>

**Хүснэгт 5 Судалгаанд хамрагдсан аймгийн төв, сумдын сонгосон багуудад эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл**

#	Аймаг	Сум	Баг	Эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо	Хөдөлмөр эрхлэдэг хүүхдийн тоо	Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо
1.	Өвөрхангай	Арвайхээр	2-р баг	24	4	1
			5-р баг	434	1	1
		Хархорин	3-р баг	209	2	-
2.	Сэлэнгэ	Сүхбаатар	1-р баг	14	-	-
			2-р баг	373	-	-
		Алтанбулаг	2-р баг	50	-	-
		Мандал	3-р баг	215	-	-
3.	Дархан-Уул	Дархан	7-р баг	836	-	-
			1-р баг	18	1	-
4.	Дорнод	Хэрлэн	6-р баг	732	14	2
			10-р баг	63	2	1
			Чойбалсан <sup>6</sup>	Хавирга	5	-
		Сайншанд	1-р баг	96	7	-
2-р баг	160		12	1		
5.	Дорноговь	Замын-Үүд	1-р баг	81	3	2

Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн жагсаалтанд бүртгэгдсэн хүүхэд хөдөлмөрлөж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг системчилсэн тойргийн сонголтоор сонгож тухайн ажлын байранд хөдөлмөр эрхлэж буй хүүхэд, ажил олгогчийг судалгаанд хамруулсан. Тэднээс мэдээлэл цуглуулахад судалгааны санал асуулгын асуумжуудыг ашигласан болно. Тогтвортой ажлын байранд хөдөлмөр эрхлэдэг нийт 30 хүүхэд, 31 ажил олгогч энэхүү судалгаанд хамрагдсан болно.

**Хоёрдугаар үе шат**

Үндсэн судалгааны хоёрдугаар үе шатанд Улаанбаатар хотын сонгосон хороодын Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч, судалгаанд хамрагдах аймгийн төв, сумдын нийгмийн ажилтан, багийн дарга нараас тухайн хороо/багийн бүтэц (хэсгийн тоо, байршил), хүн ам, өрхийн талаар үндсэн статистик мэдээллийг цуглуулсан.

Сонгосон хороо/багийг "гэр", "орон сууц", "холимог" ("гэр" ба "орон сууц") гэсэн үндсэн гурван ангилалд хувааж дараах байдлаар санамсаргүй шууд түүврийн аргаар хэсгүүдийг сонгосон:

- "гэр" хороо/багаас хоёр хэсгийг (хоёр "гэр" хэсэг);
- "орон сууц"-ны хороо/багаас нэг хэсгийг ("орон сууц"-ын хэсэг);
- "холимог" хороо/багаас хоёр хэсгийг (нэг "гэр", нэг "орон сууц").

Судалгаанд хамрагдахаар сонгогдсон хэсгүүдэд оршин сууж буй өрхүүдийн бүртгэлийг судалгааны багийнхан 2005 оны 9-11-р саруудад хороодын нийгмийн ажилтан, багийн дарга, сонгогдсон хэсгийн дарга нартай хамтран хийж гүйцэтгэсэн. Тус бүртгэлээр 7-17 насны албан бус хэвшилд тогтворгүй ажлын байранд хөдөлмөр эрхлэж буй хүүхэд өрхөд байгаа эсэх, хэрэв тогтворгүй ажлын байранд хөдөлмөр эрхлэдэг хүүхэд байвал тухайн өрхийн хөдөлмөр эрхлэдэг хүүхдийн тоо, хөдөлмөрийн төрөл зэрэг мэдээллийг тусгайлан бэлтгэсэн маягтын дагуу цуглуулсан.

<sup>6</sup> Судалгааны Ажлын даалгаварт Дорнод аймгийн Чойбалсан сумын Хавиргын боомт байрладаг багийг судалгаанд хамрагдах талаар заасан байсан боловч 2005 оны 9-р сарын байдлаар тус боомтод эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа эрхлэх аж ахуй, иргэд болон хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд байгаагүй тул Дорнод аймгийн Чойбалсан сумын Хавиргын боомт байрлах багийг судалгаанд Захиалагчтай зөвшилцсөний үндсэн дээр хамруулаагүй болно. 2005 оны 8-р сараас төмөр экспортлоход Засгийн газар хориг тавьсан нь тус боомтоор өнгөрч буй барааны хэмжээ, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эдийн засгийн идэвх эрс буурахад нөлөөлсөн байна.



**Хүснэгт 6 Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан хэсгүүдэд оршин сууж буй өрхийн бүртгэл**

#	Дүүрэг	Хорооны дугаар	Хэсгийн тодорхойлолт	Хэсэгт оршин сууж буй өрхийн тоо	Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн тоо	Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо
1.	Баянгол	3	"Мабелийн задгай"	31	6	4
			21-24, 35-37-р байр	133	7	4
2.	Сонгинохайрхан	4	5-р хэсэг	57	1	1
			2-р хэсэг	231	-	-
3.	Баянзүрх	14	4-р хэсэг	182	9	5
			"Ахмадын хороолол"	24	-	-
4.	Баянгол	20	Гэр хороолол	102	-	-
			Орон сууц	118	-	-
5.	Сүхбаатар	9	"Алтайн 11-р гудамж"	60	-	-
			46-р байр	31	-	-
6.	Чингэлтэй	2	4-р хэсэг	87	-	-
7.	Сүхбаатар	5	39-р байр	127	-	-
8.	Хан-Уул	6	4-р хэсэг	87	-	-
			1-р хэсэг	179	-	-
9.	Сонгинохайрхан	14	14-р байр	108	-	-
			"Дэнжийн задгай"	45	-	-
10.	Чингэлтэй	11	1-р хэсэг	127	2	2
			8-р хэсэг	140	1	1
11.	Баянзүрх	5	204-р байр	100	-	-
			"МОНЕЛ"-ийн 2-р хэсэг	137	30	8
12.	Сонгинохайрхан	15	20-р байр (1-5 орц)	180	-	-
			Хилчний гудамж "А" хэсэг	127	-	-
13.	Налайх	3	"Замчны" 2-р хэсэг	108	21	-
			"Нарангын" 5-р хэсэг	104	31	-
14.	Баянзүрх	8	7-р хэсэг	194	-	-
			"Холбоо" толгой 5-р хэсэг	194	15	3
15.	Сүхбаатар	13	1-р хэсэг	91	4	4
			9-р хэсэг	153	5	2
16.	Чингэлтэй	4	2-р хэсэг	168	-	-
17.	Сүхбаатар	4	18, 20, 22, 24, 28-р байр	322	-	-
			1-р хэсэг	91	-	-
18.	Баянгол	16	10-р хэсэг	112	-	-
			19, 21-р байр	239	-	-
19.	Баянгол	12	1-р хэсэг	87	5	2
20.	Налайх	2	37А/Б-р байр	223	3	3
21.	Баянзүрх	7	8-р хэсэг	90	-	-
			2-р хэсэг	182	2	1
22.	Чингэлтэй	14	4-р хэсэг	85	0	-
			10-р хэсэг	114	6	3
23.	Хан-Уул	8	2-р хэсэг	148	34	8
			8-р хэсэг	73	1	1
24.	Сонгинохайрхан	10	"Доод Салхит"	82	2	2
			"Дээд Салхит"	152	0	-
25.	Чингэлтэй	18	"Сүүний 16", "Хайрцагны 24" айл	40	0	-
			"Дандарын 1, 2-р гудамж"	50	1	1

**Хүснэгт 7 Судалгаанд хамрагдсан аймгийн төв, сумдын сонгогдсон хэсгүүдийн өрхийн бүртгэл**

#	Аймаг	Сум	Баг	Хэсгийн дугаар	Хэсэгт оршин сууж буй өрхийн тоо	Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн тоо	Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо
1	Өвөрхангай	Арвайхээр	5-р баг	"Сахиул"	112	4	2
				"Өнөр"	43	2	1
			2-р баг	2-р хэсэг	238	7	-
				3-р хэсэг	171	10	5
2	Сэлэнгэ	Сүхбаатар	3-р баг	"Арцаг"	110	12	5
				"Соёр"	152	7	3
			2-р баг	2-р хэсэг	197	-	-
				3-р хэсэг	182	-	-
3	Дархан-Уул	Дархан	1- баг	2-р хэсэг	73	-	-
				2-р хэсэг	62	-	-
			7-р баг	3-р хэсэг	49	13	6
				7-р хэсэг	93	3	2
4	Дорнод	Хэрлэн	3-р баг	"Сансар"	70	2	2
				"Гандангийн"	99	16	4
			6-баг	"Алтан гадас"	182	4	3
				"Хангамж"	67	6	6
5	Дорноговь	Сайншанд	1- баг	"Барилгачид"	55	4	-
				"Пионерын задгай"	173	7	-
			2-р баг	"Ивээл"	113	31	8
				"Өнөр"	80	0	-
6	Завхан	Хайрхон	10-р баг	"Ялалт"	151	17	6
				"Хирс"	54	2	2
			Чойбалсан	Хавирга	-	-	-
				1- баг	"Аюушын"	91	-
7	Дорнод	Сайншанд	1- баг	"Дампилын"	52	-	-
				10-р хэсэг	42	3	1
			2-р баг	12-р хэсэг	86	5	2
				3-р хэсэг	64	-	-
8	Дорнод	Замын Үүд	1-р баг	6-р хэсэг	64	2	2

Албан бус хэвшилд тогтворгүй ажлын байранд хөдөлмөр эрхлэдэг хүүхэдтэй бүртгэгдсэн өрхүүдийг системчилсэн тойргийн сонголтын аргыг ашиглан сонгож хөдөлмөр эрхлэж буй хүүхэд, эцэг эх/асран хамгаалагчийг судалгаанд хамруулсан. Сонголт хийхдээ нэг өрхөөс нэг хүүхдийг сонгох зарчмыг баримталсан бөгөөд нэг хэсгээс дээд тал нь найман өрхийг судалгаанд хамруулсан болно. Судалгааны мэдээллийг санал асуулгын асуумж ашиглан сурвалжлагын аргаар цуглуулсан.

## Мэдээлэл цуглуулсан аргачлал

Энэхүү судалгаанд дараах хэрэглэгдэхүүнүүдийг ашигласан:

- Судалгаанд сонгогдсон хороо/ багийн нутаг дэвсгэр дээр эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн бүртгэлийн маягт<sup>7</sup>;
- Сонгогдсон хэсгийн өрхийн бүртгэлийн маягт<sup>8</sup>;
- Судалгаанд хамрагдсан хөдөлмөр эрхлэж буй хүүхдээс мэдээлэл цуглуулах санал асуулгын асуумж<sup>9</sup>;
- Эцэг эх/асран хамгаалагчаас мэдээлэл цуглуулах санал асуулгын асуумж<sup>10</sup>;
- Ажил олгогчоос мэдээлэл цуглуулах санал асуулгын асуумж<sup>11</sup>;
- Хүүхэд, эцэг эх/асран хамгаалагч, ажил олгогчтой ганцаарчилсан ярилцлага хийх төлөвлөгөө.

## ТАЙЛАН БОЛОВСРУУЛАЛТ

### Тархаалт

Судалгааны түүвэрлэлтээр мэдээлэл цуглуулах явцад Улаанбаатар хотын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэдэг 77 хүүхэд (тогтвортой ажлын байранд хөдөлмөр эрхлэдэг 22; тогтворгүй ажлын байранд хөдөлмөр эрхлэдэг 55); 57 эцэг эх/асран хамгаалагч; 21 ажил олгогч тус тус хамрагдсан болно.

Судалгаанд хамрагдсан аймгийн төв, сумдаас нийт 68 хүүхэд (тогтвортой ажлын байранд хөдөлмөр эрхлэдэг 8; тогтворгүй ажлын байранд хөдөлмөр эрхлэдэг 60), 55 эцэг эх/асран хамгаалагч, 9 ажил олгогч судалгаанд хамрагдсан болно.

### Тархаалтын томъёо

Тэмдэглэгээ:

s = Давхарга дахь дагавар  
i = Хороод дахь дагавар  
j = Аж ахуйн нэгж байгууллага дахь дагавар  
k = ААН-ийн хүрээнд хөдөлмөр эрхлэдэг хүүхэд дэх дагавар  
l = Хэсгийн төрөл дэх дагавар(2 төрөл: орон сууц ба гэр)  
r = Хэсэг дэх дагавар  
t = Орон нутгийн хүрээнд хөдөлмөр эрхлэдэг хүүхэдтэй өрх дэх дагавар  
N = Хороодын тоо  
M = Хэсгүүдийн тоо  
E = Аж ахуйн нэгж байгууллагуудын тоо  
W = Хөдөлмөр эрхлэдэг хүүхдийн тоо  
n = Судалгаанд хамрагдсан хороодын тоо  
m = Судалгаанд хамрагдсан хэсгүүдийн тоо  
e = Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагуудын тоо  
w = Судалгаанд хамрагдсан хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн тоо  
H = Хөдөлмөр эрхлэдэг хүүхэдтэй өрхийн тоо  
h = Судалгаанд хамрагдсан хөдөлмөр эрхлэдэг хүүхэдтэй өрхийн тоо  
y = Судалгааны хувьсах хэмжигдэхүүний үнэ

Нэгдсэн тархаалт хийх:

$$\hat{Y}_s = \frac{N_s}{n_s} \left[ \sum_{i=1}^{n_s} \frac{E_{si}}{e_{si}} \sum_{j=1}^{e_{sj}} \frac{W_{sij}}{w_{sij}} \sum_{k=1}^{w_{sijk}} y_{sijk} + \sum_{l=1}^2 \frac{M_{sl}}{m_{sl}} \sum_{r=1}^{h_{slr}} \frac{H_{slr}}{h_{slr}} \sum_{t=1}^{w_{slrt}} \frac{W_{slrt}}{w_{slrt}} y_{slrt} \right]$$

<sup>7</sup> Эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа эрхлэж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн бүртгэлийн маягтыг Хавсралт 1-д хавсаргав.

<sup>8</sup> Сонгогдсон хэсгийн өрхийн бүртгэлийн маягтыг Хавсралт 2-д хавсаргав.

<sup>9</sup> Хөдөлмөр эрхлэж буй хүүхдээс мэдээлэл цуглуулах санал асуулгын асуумжийн загварыг Хавсралт 3-д хавсаргав.

<sup>10</sup> Эцэг эх/асран хамгаалагчаас мэдээлэл цуглуулах санал асуулгын асуумжийн загварыг Хавсралт 4-д хавсаргав.

<sup>11</sup> Ажил олгогчоос мэдээлэл цуглуулах санал асуулгын асуумжийн загварыг Хавсралт 5-д хавсаргав.

Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхлэдэг хүүхдийн жин доорх байдлаар томъёологдоно:

$$\frac{N_s}{n_s} \times \frac{E_{si}}{e_{si}} \times \frac{W_{sij}}{w_{sij}}$$

Тогтвортой ажлын байргүйгээр хөдөлмөр эрхлэдэг хүүхдийн жин доорх байдлаар томъёологдоно:

$$\frac{N_s}{n_s} \times \frac{M_{sl}}{m_{sl}} \times \frac{H_{slr}}{h_{slr}} \times \frac{W_{slr}}{w_{slr}}$$

### **СУДАЛГААНЫ ТООН МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ**

Санал асуулгын асуумжуудаар цуглуулсан мэдээллийг SPSS программ хангамжийг ашиглан тоон хэлбэрт хөрвүүлэн судалгааны тархаалт, дүн шинжилгээ хийхэд ашиглах мэдээллийн санг бүрдүүлсэн. Мэдээллийн сан нь үндсэн гурван бүлгээс бүрдсэн. Үүнд:

- Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдээс санал асуулгын асуумжаар цуглуулсан мэдээллийн сан;
- Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн эцэг эх/асран хамгаалагчаас цуглуулсан мэдээллийн сан;
- Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн ажил олгогчоос цуглуулсан мэдээллийн сан.

### **СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ**

Судалгааны мэдээллийг ЕБС-ийн хичээл эхэлсэн үед цуглуулсан нь тогтмол бус, зөвхөн амралтаараа эсвэл хичээлийн бус цагаар хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн судалгаанд хамрагдах магадлалыг тодорхой хэмжээнд бууруулсан нь энэхүү судалгааны үр дүнд нөлөөлсөн байх талтай юм.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. УЛААНБААТАР ХОТЫН АЛБАН БУС ХЭВШИЛД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮД

### УЛААНБААТАР ХОТЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот засаг захиргааны хувьд есөн дүүрэг, 121 хороодод хуваагдаж байна. 2005 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотод 215.7 мянган өрхийн 952.4 мянган хүн оршин сууж байна.

#### Хүснэгт 8 Улаанбаатар хотын нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтүүд<sup>12</sup>

Үзүүлэлтүүд	2005
Суурин хүн ам (мян. хүн)	952.4
Өрхийн тоо (мян. өрх)	215.7
Нэг өрхөд ногдох хүн	4.2
Ажиллагчдын тоо (мян. хүн)	333.7
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо	5428
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо	12476
Хан-уул	1065
Багануур	173
Баянзүрх	1782
Налайх	246
Баянгол	2435
Сүхбаатар	3248
Чингэлтэй	1769
Багахангай	20
Сонгинохайрхан	1738

Улаанбаатар хот нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг хирнээ хүн амын нягтралаараа хамгийн өндөрт орж байна. 2005 оны байдлаар Улаанбаатар хотод нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 205.4 хүн ногдож байгаа нь 2004 оныхоос 3.9 хувиар, 2000 оныхоос 20 гаруй хувиар нэмэгджээ.

Нэг өрхөд ногдох хүний тоо улсын дунджаар 4.2 хүн ногдож байхад Улаанбаатар хотод 4.4 хүн ногдож байна. 2005 оны байдлаар Улаанбаатар хотын хүн амыг насны бүлгээр авч үзэхэд 25.9 хувийг 15 хүртэл насны хүүхэд, 70.0 хувийг 15-64 насны хүн ам, 4.1 хувийг 65 ба түүнээс дээш насныхан эзэлж байна. Хүн амын хүйсийн харьцаа нь 100 эмэгтэйд 93.7 эрэгтэй ногдож, хүн ам зүйн ачаалал<sup>13</sup> 45.7 байна.

Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг харуулдаг ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин 2004 оны байдлаар Улаанбаатар хотод 2003 оныхоос 4 хувиар өссөн байна. 2004 онд Улаанбаатар хотод 110.2 мянган хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа бөгөөд тэднээс зөвхөн 5.4 мянган ажилгүйчүүд хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй байв<sup>14</sup>.

2005 оны эцсийн байдлаар 25.1 мянган хуулийн этгээд болох аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэний 12.5 мянга буюу 50.0 хувь нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хот нь Монгол улсын ДНБ-ийн талаас илүүг бүрдүүлдэг бөгөөд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээгээр тэргүүлдэг байна.

#### Хүснэгт 9 Дотоодын нийт бүтээгдэхүүн (тэрбум төгрөг)<sup>15</sup>

	2001	2002	2003	2004	2005*
ДНБ (оны үнээр)	1115.6	1240.8	1461.2	1910.9	2266.5
Улаанбаатар хот	633.3	717.4	848.7	1028.5	1227.5
Улаанбаатар хотын нэг хүн амд ногдох ДНБ (оны үнээр, мян. төгрөг)	791.1	864.9	975.5	1129.0	1289.0

\*ҮСГ-ын урьдчилсан тооцоогоор

<sup>12</sup> ҮСГ, "Монгол Улсын статистикийн эмхтгэл 2005", Улаанбаатар, 2006

<sup>13</sup> Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлэгч хүний тоо

<sup>14</sup> ҮСГ, "Монгол Улсын статистикийн эмхтгэл 2005", Улаанбаатар, 2006

<sup>15</sup> ҮСГ-ын тооцоогоор, 2005

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ТОО

Судалгааны явцад цуглуулсан мэдээллийг үндэслэн тархаалтын аргачлалыг ашиглан тооцоолоход 2005 оны дөрөвдүгээр улирлын байдлаар Улаанбаатар хотын (төвийн зургаан дүүрэг ба Налайх) албан бус хэвшилд 7-17 насны<sup>16</sup> 4900 орчим хүүхэд хөдөлмөр эрхлэж байна.

**Хүснэгт 10 Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн тоо (Улаанбаатар хотын төвийн зургаан дүүрэг ба Налайх дүүрэг)**

Дүүрэг	7-17 насны хүүхдийн тоо <sup>17</sup>	Дүнд эзлэх хувийн жин	Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй 7-17 насны хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувийн жин
Хан-уул	21341	9.6	118	2.4
Сонгинохайрхан	49188	22.2	1017	20.8
Баянгол	40800	18.3	252	5.2
Чингэлтэй	31656	14.2	258	5.3
Сүхбаатар	28279	12.7	328	6.7
Баянзүрх	43965	19.7	2669	54.6
Налайх	7429	3.3	248	5.1
<b>Нийт</b>	<b>222658</b>	<b>100.0</b>	<b>4890</b>	<b>100.0</b>

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 75.4 хувь нь Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд оршин суудаг байна. Эдгээр дүүрэгт оршин сууж буй хүн ам, гэр хороололд оршин суудаг өрхийн тоо олон, хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд гол төлөв тус дүүргүүдийн нутаг дэвсгэрт ирж суурьшдаг зэрэг хүчин зүйлс эдгээр дүүргүүдийн эзлэх хувь өндөр байгаад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.


## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДИЙН НАС, ХҮЙС

Улаанбаатар хотын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн 63 хувь буюу 3097 нь хөвгүүд (тэдний 77 гаруй хувь нь 13-16 насны) байна.

**Хүснэгт 11 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нас, хүйс**

Нас <sup>18</sup>	Нийт хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь	Хөвгүүд		Охид	
			Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
7-10	190	3.9	183	5.9	7	0.4
11-14	2419	49.5	1841	59.5	578	32.2
15-17	2281	46.7	1073	34.6	1208	67.4
<b>Нийт</b>	<b>4890</b>	<b>100.0</b>	<b>3097</b>	<b>100.0</b>	<b>1793</b>	<b>100.0</b>

**Зураг 3 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нас, хүйсийн харьцаа**



Хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдүүдийн дунд хөвгүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр, тэд охидоос эрт хөдөлмөрийн харилцаанд орж байгаад дараах хүчин зүйс нөлөөлдөг байна:

- Хөвгүүдийн сургууль завсардалт харьцангуй өндөр (хөдөлмөр эрхлэж буй хөвгүүдийн 40 орчим хувь; охидын 17 орчим хувь нь сургууль завсардсан/сургуульд огт сураагүй байна);

<sup>16</sup> Судалгааны мэдээлэл цуглуулах үеийн бүтэн насаар

<sup>17</sup> УСГ, 2005

<sup>18</sup> Судалгааны түүвэрлэлтийг системчилсэн тойргийн түүвэрлэлтийн аргаар гүйцэтгэсэн нь түүвэрлэлтэнд 7-8 насны хүүхэд хамрагдаагүйд нөлөөлсөн болно.

- Өрхийн орлого нэмэгдүүлэх шаардлага гарсан тохиолдолд өрхөд буй эрэгтэй хүүхэд хөдөлмөр эрхлэх магадлал харьцангуй өндөр байдаг байна. Иргэдийн дунд "Эрэгтэй хүүхдүүд гэр бүлээ, эцэг эхээ дэмжих, тэжээх хэрэгтэй, үүрэгтэй" хэмээх хандлага эцэг эх, хүүхдийн дунд өргөн тархсан нь судалгааны мэдээлэл цуглуулах явцад ажиглагдаж байсан;
- Албан бус хэвшилд хүүхэд хийж болох ажлын төрөл нь ихэнх тохиолдолд биеийн хүч шаардсан байдаг (хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 49 % нь хүнд ачаа өргөх, зөөх ажил эрхлэдэг) тул хөвгүүдэд илүү "тохиромжтой" ажлын төрөл болох нь харагдсан байна.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН АМЬДРАЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### Өрхийн бүтэц

Хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдүүдийн 99 хувь нь өөрийн гэрт; нэг хүрэхгүй хувь нь өрхөөс гадуур амьдардаг байна. Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 69 хувь нь эцэг эхийн хамт (бүтэн өрхөд); 31 хувь нь эцэг эхийнхээ аль нэгтэй (бүрэн бус өрхөд) амьдарч байна

Хүүхдүүдийн өрхийн гишүүдийн тоог Хүснэгт 12-т үзүүлэв.

#### Хүснэгт 12 Хүүхдүүдийн өрхийн гишүүдийн тоо

Өрхийн ам бүл	Давтамж	Дүнд эзлэх хувь
2	32	0.6
3	94	1.9
4	1185	24.2
5	893	18.3
6	1007	20.6
7	823	16.8
8	324	6.6
9	283	5.8
10	249	5.1
<b>Нийт</b>	<b>4890</b>	<b>100.0</b>

### Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өрхийн амьжиргаа

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 91 хувь нь гэр хороололд гэр болон сууцны тусдаа байшинд амьдардаг байна.

#### Хүснэгт 13 Хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн өрхийн сууцны төрөл

Сууцны төрөл	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь
Орон сууц	339	6.9
Сууцны тусдаа байшин <sup>19</sup>	1800	36.8
Нийтийн байр	23	0.4
Гэр	2580	52.8
Орцны жижүүрийн байр	63	1.3
Урц, овоохой <sup>20</sup>	57	1.2
Вагончик <sup>21</sup>	28	0.6
<b>Нийт</b>	<b>4890</b>	<b>100.0</b>

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн өрхийг сууцны өмчийн хэлбэрээр нь авч үзвэл: нэг хүрэхгүй хувь нь төрийн өмчийн, 88 хувь нь хувийн өмчийн, 11 хувь нь түрээсийн (сарын түрээс 5000-15000 төгрөг) байна.

Гэр хороололд өөрийн эзэмшлийн газар дээр оршин суудаг нийт өрхүүдийн 49 хувь нь судалгааны мэдээлэл цуглуулах үед өөрийн эзэмшлийн хашааны газраа хувьчилж авсан байв.

Гэрт амьдардаг өрхүүдийн 51 хувь нь дан бүрээстэй, 49 хувь нь давхар бүрээстэй; 61 хувь нь шалтай, 39 хувь нь шалгүй байна. Энэ нь тус өрхүүдийн амьжиргааны түвшин нэн ядуу байдалтай байгааг харуулж байгаа юм.

<sup>19</sup> Төвлөрсөн халаалтын, халуун хүйтэн усны, бохирын шугамд холбогдоогүй гэр хороололд байршилтай

<sup>20</sup> Гол төлөв хогийн цэг дээр


<sup>21</sup> Удаан хугацаагаар амьдрахад зориулагдаагүй

Нийт өрхийн 8 хувь нь төвлөрсөн халаалттай (орон сууц, нийтийн байр, орцны жижүүрийн байр) байсан бөгөөд галладаг өрхийн 90 гаруй хувь нь нүүрс мод, 67 хувь нь зөвхөн нүүрсийг түлшиндээ хүйтний улиралд хэрэглэж байна. Галладаг өрхийн 17 хувь нь түлшиндээ хог (автомашин дугуй, цаас) тогтмол ашигладаг байна.

Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдтэй өрхийн 90 хувь нь төвийн цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон, 10 хувь нь цахилгаан эрчим хүч ашигладаггүй байна. Цахилгаанд холбогдоогүй өрхүүд гол төлөв Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд шинээр үүссэн гэр хороололд оршин суудаг ажээ.

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхэдтэй өрхийн 6 орчим хувь нь төвлөрсөн халуун, хүйтэн устай, 3 хувь нь төвлөрсөн шугамын хүйтэн устай байна. Өрхийн 76 хувь нь худаг, 5 хувь нь гол, булгаас ундны усаа хангаж байна.

**Зураг 4 Хөдөлмөр эрхлэж буй хүүхэдтэй өрхийн ундны усны эх үүсвэр (хувь)**



Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өрхийн 90 хувь нь цахилгаан гэрэлтэй, 80 хувь нь зурагттай, 28 хувь нь хөргөгчтэй, 41 хувь нь цахилгаан плиткатай харин 6 хувь нь ямар нэгэн цахилгаан хэрэгсэл ашигладаггүй байна.

Хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн 47 хувь нь өөрийн гэсэн ортой; 64 хувь нь хөнжилтэй; 58 хувь нь гудастай; 51 хувь нь дэртэй; 33 хувь нь өөрийн гэсэн ор, хөнжил, гудас, дэргүй байна.


**Хүснэгт 14 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хэрэглэл (давхардсан тоогоор)**

Хэрэглэл	Нийт		Насны бүлэг					
	Тоо	Дүнд эзлэх хувь	7-10		11-14		15-17	
			Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Ор	2308	47.2	4	2.1	1289	53.3	1015	44.5
Хөнжил	3111	63.6	4	2.1	1801	74.4	1306	57.2
Гудас	2838	58.0	4	2.1	1536	63.5	1298	57.0
Дэр	2501	51.2	4	2.1	1401	58.0	1096	48.0
Бүгд байхгүй	1626	33.2	187	98.4	506	21.0	933	41.0

**Хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн өрхийн орлого, зарлага**

Хөдөлмөр эрхлэж буй хүүхэдтэй өрхийн дундаж мөнгөн орлого дараах байдлаар бүрддэг байна: 39 хувь нь тогтмол бус бизнесийн үйл ажиллагааны орлогоос, 32 хувь нь хөдөлмөрийн хөлснөөс<sup>22</sup>, 10 хувь нь тэтгэвэр, тэтгэмжээс, 19 хувь нь бусад мөнгөн эх үүсвэрээс.

**Зураг 5 Хөдөлмөр эрхлэж буй хүүхэдтэй өрхийн дундаж мөнгөн орлогын бүтэц (хувь)**



<sup>22</sup> Цалин болон цалинтай адилтгах орлого

Нийт өрхийн орлогын талаас илүү хувь нь тогтвортой бус (тогтмол бус бизнесийн үйл ажиллагааны орлого, бусад мөнгөн эх үүсвэр гэх мэт) эх үүсвэртэй байдаг нь өрхийн санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг. Өрхийн санхүүгийн тогтворгүй байдал нь хүүхэд өрхийн мөнгөн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хөдөлмөр эрхлэж эхлэхэд нөлөөлдөг гол хүчин зүйлийн нэг болж байгаа нь судалгааны явцад ажиглагдсан.

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэдэг хүүхэдтэй нийт өрхийн 60 орчим хувь нь төрийн халамжийн тогтолцооны хүрээнд ямар нэгэн тэтгэлэг, тэтгэмж авдаг байна.

Хөдөлмөр эрхлэж буй хүүхэдтэй өрхийн мөнгөн зарлагыг сүүлийн<sup>23</sup> сарын байдлаар авч үзэхэд нийт зарлагын 49 хувийг хүнсний бараа худалдан авахад (улсын дундаж:40,3 хувь<sup>24</sup>); 17 хувийг хүнсний бус бараа худалдан авахад (улсын дундаж: 26,0 хувь); 21 хувийг боловсролын үйлчилгээнд (сургалтын төлбөр, хичээлийн хэрэгсэл); 4 хувийг нь өр, зээлийн эргэн төлөлт, үйлчилгээнд; 7 хувийг татварт<sup>25</sup>; 2 хувийг эрүүл мэндийн үйлчилгээнд (эмчилгээ, эм) тус тус зарцуулсан байна.

### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДИЙН ЭЦЭГ ЭХ**

Улаанбаатар хотын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцгүүдийн 53 хувь нь 30-45 насны, эхчүүдийн 83 хувь нь 30-45 насныхан байна.

**Хүснэгт 15 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг, эхийн нас (хувь)**

Насны бүлэг	Эцэг	Эх
30-40	41.2	38.5
41-45	11.8	44.2
46-50	23.5	13.5
51-55	14.7	3.8
56 ба түүнээс дээш	8.8	-
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

### **Эцэг эхийн боловсролын түвшин**

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг эхийн боловсролын түвшинг<sup>26</sup> авч үзэхэд эцгүүдийн 62 орчим хувь нь бүрэн бус дунд болон түүнээс доош түвшний боловсролтой; эхчүүдийн 50 хувь нь бүрэн бус дунд болон түүнээс доош боловсролтой байна.

**Хүснэгт 16 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг эхийн боловсролын түвшин (хувь)**

Эцэг эхийн боловсролын түвшин	Эцэг	Эх
Дээд	2.9	0.0
Тусгай мэргэжлийн дунд	5.9	13.5
Техник мэргэжлийн анхан шатны	5.9	1.9
Бүрэн дунд	23.5	34.6
Бүрэн бус дунд	47.1	38.5
Бага	11.8	11.5
Боловсролгүй	2.9	0.0
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг эхийн боловсролын түвшин харьцангуй доогуур байгаа нь тэдний хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг хязгаарладаг (эцгүүдийн 60 орчим хувь; эхчүүдийн 40 орчим хувь нь хөдөлмөр эрхлэдэггүй) гол хүчин зүйл болдог бөгөөд энэхүү хязгаарлагдмал өрсөлдөх чадвар нь тухайн өрхийн орлогын түвшин доогуур, санхүүгийн тогтворгүй байдлыг үүсгэдэг байна. Энэхүү хүчин зүйлүүд эцсийн дүндээ хүүхдийн хөдөлмөрөөс олж буй орлого өрхийн санхүүгийн байдалд нөлөөлөх нөхцөл байдлыг үүсгэх талтай юм.

<sup>23</sup> Судалгааны мэдээллийг 9-өөс 10-р саруудад цуглуулсан нь боловсролын үйлчилгээнд зориулж буй зардлын эзлэх хувийн жин харьцангуй өндөр байгаад нөлөөлсөн байж болзошгүй

<sup>24</sup> УСГ, "Монгол Улсын статистикийн эмхтгэл 2005"; Улаанбаатар, 2006

<sup>25</sup> Судалгаанд хамрагдсан иргэд "татвар" гэдгийг ХАОАТ-аас гадна захын удирдлагын хураадаг хураамжийг "татвар" гэж тодорхойлсон байх магадлалтай

<sup>26</sup> Бүрэн дүүргэсэн түвшингөөр



### Эцэг эхийн хөдөлмөр эрхлэлт

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй эцэгтэй хүүхдүүдийн эцгүүдийн 60 орчим хувь нь хөдөлмөр эрхлэдэггүй, эхтэй хүүхдүүдийн эхчүүдийн 40 орчим хувь нь мөн ямар нэгэн хөдөлмөр эрхлэдэггүй байна.

Хүүхдүүдийн эцэг эх нь ажил хийхгүй байгаа нь өрхийн орлогын түвшин доогуур байгаад нөлөөлж буй нэгэн хүчин зүйл болж байгаа бөгөөд энэхүү байдал нь хүүхэд хөдөлмөр эрхлэхэд хүргэх нэг шалтгаан болдог нь нийт хүүхдүүдийн 68 хувь нь “өрхийн орлогод нэмэр болох зорилгоор” хөдөлмөр эрхлэж эхэлсэн/үргэлжүүлэн хөдөлмөрлөж байгаагаас харагдаж байгаа юм.

#### Хүснэгт 17 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувь)

Эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийн байдал	Эцэг	Эх
Хөдөлмөрийн гэрээгээр	1.8	14.0
Иргэний гэрээгээр	8.8	3.5
Ажил олгогч	1.8	1.8
Хувиараа хөдөлмөр эрхлэдэг	28.1	38.6
Бусад	-	1.8
Хөдөлмөр эрхлэдэггүй	59.5	40.3
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Нийт эцгүүдийн 28 гаруй хувь, эхчүүдийн 39 орчим хувь албан бус хэвшилд хувиараа хөдөлмөр эрхлэдэг байна.

Хүүхэд нь хөдөлмөр эрхлэж буй өрхийн ажил хийдэг эцгүүдийн 32 хувь нь тээвэр, агуулахын аж ахуй, холбоо, 26 хувь нь бөөний, жижиглэн худалдаа, гэр ахуйн бараа засварлах үйлчилгээний салбарт ажиллаж байхад эхчүүдийн 52 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа эрхлэдэг байна.

#### Хүснэгт 18 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг, эхийн хөдөлмөр эрхлэж буй салбар (хувь)

Салбар	Эцэг	Эх
Боловсруулах аж үйлдвэр	15.8	12.9
Цахилгаан, дулаан, усан хангамж	5.3	-
Барилга	5.3	3.2
Бөөний, жижиглэн худалдаа	26.3	51.6
Зочид буудал, зоогийн газар	5.3	12.9
Тээвэр, холбоо	31.6	-
Нийгмийн бие хүнд үйлчлэх	10.4	16.2
Төрийн удирдлага, батлан хамгаалах	-	3.2
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг эх/асран хамгаалагчдын 37 хувь нь хүүхдийнхээ хөдөлмөр эрхлэж буйд дараах шалтгааны улмаас сэтгэл ханамжтай байдаг байна:

- Өрхийн орлогод нэмэр болдог;
- Сургалтын зардлаа (хувцас, хичээлийн хэрэгсэл худалдан авах зардал, сургуулиас албан болон албан бус хэлбэрээр цуглуулах мөнгөн болон мөнгөн бус хураамж, хуримтлал гэх мэт) өөрөө олдог.

Эцэг эх/асран хамгаалагчдын 63 орчим хувь нь хүүхдийнхээ хөдөлмөр эрхлэж буй байдалд сэтгэл дундуур байдаг байна. Учир нь хүүхэд хөдөлмөр эрхлэх нь тэдний боловсрол эзэмших боломжийг хязгаарлахаас гадна эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлдөг гэж үзэж байлаа.

Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нийт эцэг, эхийн 75 хувь нь “өрхийн орлого хангалттай болбол хүүхэд хөдөлмөр эрхлэхээ болино” гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд өрхийн амьжиргааны түвшин, өрхийн санхүүгийн тогтвортой байдал хүүхэд хөдөлмөр эрхлэж байгаад нөлөөлж буй гол хүчин зүйл болж байна.

Сургуульд суралцдаггүй хүүхдүүдийн эцэг, эхээс хүүхэддээ ямар боловсрол эзэмшүүлэх талаар тодруулахад тэдний 18 хувь нь ямар нэг мэргэжил эзэмшүүлэх, 11 хувь нь бүрэн бус дунд боловсролтой болгох, 5 хувь нь бүрэн дунд боловсролтой болгох сонирхолтой байдгаа

илэрхийлсэн байна. Эцэг эхчүүдийн 67 хувь нь өөрийн хүүхэддээ боловсрол эзэмшүүлэх талаар ямар нэгэн тодорхой саналгүй байлаа.

### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДИЙН АЖИЛ ОЛГОГЧ**

Хүүхэд хөдөлмөрлүүлж буй ажил олгогчдын үйл ажиллагааг эдийн засгийн салбараар нь авч үзвэл: 19 хувь нь үйлдвэрлэлийн салбарт; 43 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа; 14 хувь нь зочид буудал, зоогийн газар; 10 хувь нь тээвэр, холбоо; 14 хувь нь бусад салбарт ажилладаг байна.

Ажил олгогчдын 33 хувь нь хүүхдүүдэд ажлын хөлснөөс гадна ямар нэгэн тусламж дэмжлэгийг үзүүлдэг бөгөөд тэдний 5 хувь нь хоол/унааны мөнгө, 14 хувь нь хувцас зэргийг өгч байжээ.

Ажил олгогчид хүүхдүүдэд тохирсон хөдөлмөрийн хөлсөө хугацаанд нь өгөхгүй “унжих”, удаах явдал төдийлөн өргөнөөр дэлгэрээгүй боловч хөдөлмөрийн хөлс олгох хугацаа уртсахын зэрэгцээ ажил олгогчид хөлсөө удаах магадлал нэмэгддэг хандлага байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Хүүхдүүд хөлсөө өдөрт нь авах сонирхолтой байдаг нь хүүхдэд 15-30 хоногийн хугацаанд өөрийн болон өрхийнхөө хэрэгцээнд зарцуулах мөнгөн хуримтлал төдийлөн байдаггүй байдал нөлөөлдөг байна.

Хөлстэйгээр хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажил олгогчдын 10 хувьд хүүхдийн хөдөлмөр хямд тул тэдэнд эдийн засгийн давуу тал үүсэх боломжийг нэмэгдүүлдэг, 5 хувь нь “хүүхэд хэл ам таталдаггүй” гэж үзэж байсан нь анхаарал татаж байгаа юм.

Хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлүүлэх нь хууль бус үйлдэл гэдгийг ажил олгогч нарын 90 хувь нь мэддэг боловч тэд хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлүүлдэг/шаардлага гарвал эрхлүүлэхээс татгалзахгүй байна.

Хөлстэйгээр хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажил олгогчдын 81 хувь нь хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийг сургуульд нь явахад чөлөө олгож сургуульд суралцах боломжийг нь хязгаарладаггүй боловч сургуульд суралцдаггүй хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах талаар ажил олгогчид ямар нэгэн идэвх санаачлага гаргадаггүй байна.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРЛӨЖ ЭХЭЛСЭН/ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ШАЛТААН

Улаанбаатар хотод албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэж эхлэхэд нөлөөлсөн хүчин зүйлсийг Хүснэгт 19-т үзүүлэв. Дийлэнх олонх тохиолдолд хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэж эхлэх/үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлэж байгаад нэгээс олон хүчин зүйл нөлөөлдөг байна.

**Хүснэгт 19 Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэхэд нөлөөлсөн нэгдүгээв хүчин зүйлс<sup>27</sup> (хувиар)**

Насны бүлэг	Хүйс	Эцэг эх өртэй байсан	Эцэг эх өвчтэй байсан тул орлого олох шаардлагатай байсан	Өрхийн орлогод нэмэр болох шаардлагатай	Өрхөд өөр орлого олох хүн байхгүй	Ажлын дадлаг туршлагатай болохын тулд	Биеэ даахын тулд	Санхүүгийн бус шалтгаанаар	Нийт
7-10	Хөвгүүд	-	24.6	75.4	-	-	-	-	100.0
	Охид	-	-	-	100.0	-	-	-	100.0
	<b>Нийт</b>	-	23.7	72.6	3.7	-	-	-	100.0
11-14	Хөвгүүд	-	-	71.5	-	-	-	28.5	100.0
	Охид	-	11.1	77.2	-	11.8	-	-	100.0
	<b>Нийт</b>	-	2.6	72.9	-	2.8	-	21.7	100.0
15-17	Хөвгүүд	< 1.0	11.6	66.4	-	1.7	15.2	5.1	100.0
	Охид	-	5.3	58.7	-	5.1	1.9	29.0	100.0
	<b>Нийт</b>	-	8.2	62.3	-	3.5	8.2	17.8	100.0
Бүгд	Хөвгүүд	-	5.5	70.0	-	0.6	5.3	18.7	100.0
	Охид	-	7.1	64.5	< 1.0	7.2	1.3	19.5	100.0
	<b>Нийт</b>	-	6.1	67.9	< 1.0	3.0	3.8	19.0	100.0

**Хүснэгт 20 Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэхэд нөлөөлсөн хоёрдугаар хүчин зүйлс<sup>28</sup> (хувиар)**

Насны бүлэг	Хүйс	Эцэг эх өртэй байсан	Эцэг эх өвчтэй байсан тул орлого олох шаардлагатай байсан	Өрхийн орлогод нэмэр болох шаардлагатай	Өрхөд өөр орлого олох хүн байхгүй	Ажлын дадлаг туршлагатай болохын тулд	Биеэ даахын тулд	Сургуульд суралцах зардал олохын тулд	Эцэг эхийн шалтгаанаар	Санхүүгийн бус шалтгаанаар	Нийт
7-10	Хөвгүүд	-	-	-	73.4	2.2	-	-	24.5	-	100.0
	<b>Нийт</b>	-	-	-	73.4	2.2	-	-	24.5	-	100.0
11-14	Хөвгүүд	-	34.2	-	-	-	-	26.9	-	38.8	100.0
	Охид	< 1.0	-	15.6	< 1.0	-	14.1	55.2	14.4	-	100.0
	<b>Нийт</b>	< 1.0	23.9	4.7	< 1.0	-	4.3	35.5	4.3	27.1	100.0
15-17	Хөвгүүд	-	-	< 1.0	25.9	-	39.6	17.7	< 1.0	16.2	100.0
	Охид	-	4.7	6.6	4.7	-	18.8	63.8	-	1.5	100.0
	<b>Нийт</b>	-	2.2	3.2	15.9	-	29.7	39.5	< 1.0	9.2	100.0
Бүгд	Хөвгүүд	-	16.9	< 1.0	17.8	< 1.0	16.2	20.5	2.6	25.7	100.0
	Охид	< 1.0	3.0	9.9	-	-	17.1	60.6	5.3	< 1.0	100.0
	<b>Нийт</b>	< 1.0	11.8	3.7	11.3	< 1.0	16.5	35.3	3.6	16.6	100.0

Нийт хүүхдийн 68 орчим хувь нь “өрхийн орлогод нэмэр болох” нь тэдний хөдөлмөр эрхлэж байгаа гол шалтгаан гэж тодруулжээ.

Хүүхдүүдийн 30-аад хувьд нь сургуульд суралцахтай холбоотой зардлаа олох нь хөдөлмөр эрхлэж эхлэх/үргэлжлүүлэн хөдөлмөрлөж байгаад нь нөлөөлсөн хүчин зүйл болсон байна. Тэд өөрийн олсон орлогынхоо

тодорхой хувийг сургуульд сурахад гарч буй зардалдаа зарцуулдаг байна. Үүнээс үзэхэд хэдийгээр Монгол Улсад суурь боловсрол эзэмших нь үнэ төлбөргүй байдаг боловч өрхийн орлого бага, эмзэг давхаргынханд хүүхэд нь сургуульд суралцахад гарч буй шууд (унааны зардал, хувцас, хичээлийн хэрэгсэл, сурах бичиг гэх мэт) болон шууд бус (албан болон албан бус байдлаар

Манайх ам бүл тавуулаа. Консулын гудамжинд амьдардаг. Ээж аав хоёр маань хоёулаа ажилгүй. Манайх гэрээрээ хоол хийж зах дээр зардаг. Би айлын том нь болохоор ээждээ хоол зарахад нь тусалдаг. Ээж минь миний тусалж байгаад маш их баярладаг. Хааяа хоол зарагдахгүй бол хичээлээ таслах хоцрох үе гардаг. Манай хичээл үдээс хойш ордог болохоор үдээс өмнө хоолоо зардаг. Хоол сайн зарагдвал ээж маань надад мөнгө өгдөг. Нарантуул зах мягмар гаригт амардаг болохоор би энэ өдөр гэр орноо цэвэрлэж, хичээл номоо давтдаг.

**М....., 11 настай, Баянзүрх дүүрэг**

<sup>27</sup> Давхардсан тоогоор

<sup>28</sup> Давхардсан тоогоор

сургуулийн удирдлага, багш нарын “ангийн тохижилт”, “бэлэг авах”, “ангийн сан бүрдүүлэх” гэх мэтийн зорилгоор цуглуулж буй хуримтлал) зардлууд хүндээр<sup>29</sup> тусдаг байна.

Хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдээс одоо эрхлэж байгаа ажлыг нь хэн санал болгож, ажилд зуучилсан талаар асуухад нийт хүүхдийн 48 хувь нь өөрийнхөө хүсэлтээр, 25 хувь нь эхийн, 13 хувь нь найз нөхдийн, 5 хувь нь ажил зуучлагч нар санал тавьсанаар хөдөлмөр<sup>30</sup> эрхлэж эхэлсэн байна.

#### Хүснэгт 21 Хүүхдүүдэд хөдөлмөр эрхлэх санал тавьсан хүн (хувиар)

Насын бүлэг	Хүйс	Эцэг	Эх	Хамаатан, садан	Зуучлагч	Өөрөө	Найз нөхөд	Ах, эгч	Багш	Нийт
7-10	Хөвгүүд	24.5	2.2	-	-	-	73.4	-	-	100.0
	Охид	-	-	-	-	100.0	-	-	-	100.0
	<b>Нийт</b>	23.6	2.1	-	-	3.7	70.7	-	-	100.0
11-14	Хөвгүүд	-	15.9	-	9.2	57.2	14.6	-	3.0	100.0
	Охид	21.5	40.8	11.8	< 1.0	15.1	10.7	-	-	100.0
	<b>Нийт</b>	5.1	21.9	2.8	7.1	47.1	13.7	-	2.3	100.0
15-17	Хөвгүүд	3.5	30.5	2.2	-	46.3	17.1	< 1.0	-	100.0
	Охид	-	29.9	6.1	7.5	56.4	-	-	-	100.0
	<b>Нийт</b>	1.7	30.2%	4.3	4.0	51.7	8.0	< 1.0	-	100.0
Бүгд	Хөвгүүд	2.7	20.1	0.8	5.5	50.0	19.0	< 1.0	1.8	100.0
	Охид	6.9	33.3	7.9	5.1	43.3	3.5	-	-	100.0
	<b>Нийт</b>	4.2	25.0	3.4	5.4	47.5	13.3	< 1.0	1.1	100.0

Хүүхдийн эх өөрийн хүүхдэд өрхийн эрхлэж буй эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохыг санал болгосон байдал нэлээд өргөнөөр дэлгэрсэн (хүүхдүүдийн 20 гаруй хувьд) нь анхаарлыг татаж байгаа юм. Эхчүүд гол төлөв (эх нь хөдөлмөр эрхлэхийг санал болгосон хүүхдүүдийн 80 хувьд) жижиглэн худалдаа эрхлэхийг (өрхийн ажиллуулдаг дэлгүүр, ТҮЦ-д ажиллах, гудамж талбайд гар дээрээс бараа зарах) охиндоо (нийт эх нь хөдөлмөр эрхлэхийг санал болгосон хүүхдүүдийн 49 хувийг охидууд эзэлж байна) санал болгодог байна.

Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 24 гаруй хувь нь өөрийнхөө эрхлэж байгаа ажлаа хамтарч эрхлэхийг ах, эгч, найздаа санал болгосон байна.

#### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДИЙН АЖЛЫН ТӨРӨЛ

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн 27.5 хувь нь эцэг, эхтэйгээ/асран хамгаалагчтайгаа цуг тэдний хяналт дор ажилладаг, 26.9 хувь нь ажил олгогчийн удирдлаган дор, 44.3 хувь нь бие дааж, 1.3 хувь нь хамаатан садныхаа удирдлагын дор хөдөлмөр эрхлэдэг байна.

Хүүхдүүд үндсэн ажлаа хийгээд зогсохгүй нөхцөл боломж нь бүрдсэн (үнэлгээ арай өндөртэй ажил олдсон), үндсэн ажил хийх боломжгүй болсон зэрэг тохиолдолд сонин зарах, цэвэрлэгээ хийх, хоёрдогч түүхий эд цуглуулах ажлыг хийдэг байна. Энэхүү байдал нь хүүхдийн хөдөлмөр тогтворгүй (нөхцөл байдалд өөрчлөлт орсон тохиолдолд хувирамтгай), хүүхдүүд нэг ажлын байранд тэр болгон уягдаад байдаггүйг харуулж байна.

Хөдөлмөр эрхлэж буй хүүхэд эрхлэх ажлаа сонгохдоо юуны өмнө эдийн засгийн ашиг, үнэлгээ, олж болох орлогын түвшинг анхаарч сонголт хийдэг байна. Тэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байрны нөхцөл зэргийг нэг их анхаардаггүй хирнээ харьцангуй өндөр ашиг олох боломжтой, ажлын үнэлгээ өндөр бол ямар ч хамаагүй ажил хийдэг байна.

<sup>29</sup> Ялангуяа тус өрхөд сургуулийн насны хүүхдийн тоо олон байгаа тохиолдолд өрхөд нөлөөлөх нь илүүтэй

<sup>30</sup> Судалгааны мэдээлэл цуглуулах үед эрхлэж буй хөдөлмөр

**Хүснэгт 22 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн үндсэн ажлын төрөл**

Ажлын төрөл	Үндсэн ажил # 1		Үндсэн ажил # 2		Үндсэн ажил # 3	
	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь
Жижиглэн худалдаа эрхлэх	1940	39.6	23	2.6	-	-
Мах эвдэх	23	0.5	-	-	-	-
Ачаа зөөх	567	11.6	49	5.7	-	-
Хоёрдогч түүхий эд цуглуулах	45	0.9	170	19.7	-	-
Банз зөөх, өрөх	395	8.1	-	-	-	-
Мод хөрөөдөх, хагалах	170	3.5	10	1.1	-	-
Вагоноос ачаа буулгах/вагон түрэх	91	1.9	-	-	-	-
Утсаар яриулах "Цагаан утас"	6	0.1	-	-	-	-
Барилгын ажил эрхлэх	45	0.9	-	-	-	-
Авто засвар, дугуй засварын газар ажиллах	14	0.3	-	-	-	-
Цэвэрлэгээ хийх, автомашин угаах	505	10.3	196	22.7	170	96.0
Ногоо, жимс ялгах	19	0.4	28	3.3	7	4.0
Нийтийн хоолны газар ажиллах	79	1.6	-	-	-	-
Сонин, сэтгүүл зарах <sup>31</sup>	722	14.8	387	44.9	-	-
Нийтийн тээвэрт (микро автобус) мөнгө хураагч хийх	208	4.3	-	-	-	-
Оёдол хийх	61	1.2	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>4890</b>	<b>100.0</b>	<b>861</b>	<b>100.0</b>	<b>177</b>	<b>100.0</b>

Судалгааны мэдээлэл цуглуулах үед албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байсан нийт хүүхдүүдийн 20 орчим хувь нь үндсэн ажлаасаа гадна нэмэлт (давхар) ажил хийж байлаа.

Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн үндсэн ажлаа эрхлээд олж буй орлогын түвшин бага, орлого нь тогтвортой бус байдаг нь тэднийг нэмэлт (давхар) ажил хийхэд нөлөөлдөг байна.

**Хүснэгт 23 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нэмэлт ажлын төрөл**

Ажлын төрөл	Нэмэлт ажил	
	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь
Жижиглэн худалдаа эрхлэх	606	50.9
Мах эвдэх	-	-
Ачаа зөөх	45	3.8
Хоёрдогч түүхий эд цуглуулах	-	-
Банз зөөх, өрөх	28	2.4
Мод хөрөөдөх, хагалах	10	1.3
Вагоноос ачаа буулгах/вагон түрэх	-	-
Утсаар яриулах "Цагаан утас"	-	-
Барилгын ажил эрхлэх	4	0.3
Авто засвар, дугуй засварын газар ажиллах	-	-
Цэвэрлэгээ хийх, автомашин угаах	435	35.5
Ногоо, жимс ялгах	69	5.8
Нийтийн хоолны газар ажиллах	-	-
Сонин, сэтгүүл зарах <sup>32</sup>	-	-
Нийтийн тээвэрт (микро автобус) мөнгө хураагч хийх	-	-
Оёдол хийх	-	-
<b>Нийт</b>	<b>1197</b>	<b>100.0</b>

**Хүснэгт 24 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн үндсэн ажлын төрөл (хувиар)**

Насны бүлэг	Хүйс	Жижиглэн худалдаа	Мах эвдэх	Ачаа зөөх	Хоёрдогч түүхий эд цуглуулах	Банз зөөх, өрөх	Мод хөрөөдөх, хагалах	Вагон буулгах, түрэх	"Цагаан утас" ажиллуулах	Барилга дээр ажиллах	Авто, дугуй засварын газар ажиллах	Цэвэрлэгээ хийх	Ногоо ялгах, цэвэрлэх	Нийтийн хоолны газар ажиллах	Сонин, сэтгүүл зарах	Нийтийн тээвэрт мөнгө хураагч хийх	Оёдол хийх	Нийт	
7-10	Хөвгүүд	-	-	-	24.6	75.4	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	100.0
	Охид	-	-	-	-	100.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	100.0
	<b>Нийт</b>	-	-	-	23.7	76.3	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	100.0
11-14	Хөвгүүд	20.9	-	13.0	-	6.7	9.2	-	-	-	<1.0	21.9	-	-	27.4	-	-	-	100.0
	Охид	79.2	-	-	-	-	-	-	-	-	-	-	<1.0	-	10.7	-	-	9.9	100.0
	<b>Нийт</b>	34.8	-	9.9	-	5.1	7.0	-	-	-	<1.0	16.7	-	-	23.4	-	-	2.4	100.0
15-17	Хөвгүүд	30.0	2.1	30.5	-	11.7	-	-	-	4.2	-	-	1.7	-	-	19.4	<1.0	-	100.0
	Охид	64.2	-	-	-	-	7.5	<1.0	-	-	-	8.4	-	6.5	12.8	-	-	-	100.0
	<b>Нийт</b>	48.1	1.0	14.3	-	5.5	4.0	<1.0	2.0	-	4.5	<1.0	3.5	6.8	9.1	<1.0	-	100.0	
Бүгд	Хөвгүүд	22.8	<1.0	18.3	1.5	12.5	5.5	-	1.5	<1.0	13.0	<1.0	-	16.3	6.7	<1.0	-	100.0	
	Охид	68.8	-	-	-	<1.0	-	5.1	<1.0	-	5.7	<1.0	4.4	12.1	-	3.2	-	100.0	
	<b>Нийт</b>	39.7	<1.0	11.6	<1.0	8.1	3.5	1.9	<1.0	<1.0	10.3	<1.0	1.6	14.8	4.3	1.2	-	100.0	

<sup>31</sup> Сурталчилгааны хэвлэмэл материал түгээх

<sup>32</sup> Сурталчилгааны хэвлэмэл материал түгээх

Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн үндсэн ажлын төрлийг хүүхдийн хүйстэй харьцуулан дүгнэхэд жижиглэн худалдааг охидууд илүүтэй эрхлэдэг байна. Охидын 69 орчим хувь нь жижиглэн худалдаа эрхлэдэг, 12 гаруй хувь нь сонин сэтгүүл зардаг байна.

Ачаа зөөх, банз зөөх, өрөх, цэвэрлэгээ хийх зэргийн ажлуудыг гол төлөв хөвгүүд эрхлэдэг байна.

Судалгааны мэдээлэл цуглуулах үед албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байсан 4890 хүүхдийн 690 хүүхэд буюу 14 хувь нь одоогоор эрхлэж буй ажлаасаа өөр төрлийн ажил<sup>33</sup> сүүлийн нэг жилд эрхлэж байжээ. Тэд гол төлөв орлого, хөлсөө нэмэгдүүлэх зорилгоор ажлын төрлөө өөрчилсөн боловч хөдөлмөр эрхлэж буй салбараа өөрчлөөгүй байна.

Хүүхдүүдийн ажлын төрлийг хүүхдийн насны бүлэгтэй харьцуулахад: 7-10 насны хүүхдүүдийн олонх буюу 76 гаруй хувь нь модны зах дээр зөөх, өрөх ажил эрхлэдэг, 24 орчим хувь нь гудамж талбай, хогийн цэг дээр хоёрдогч түүхий эд цуглуулдаг байна; 11-14 насны хүүхдүүдийн 35 орчим хувь нь жижиглэн худалдаа эрхлэдэг, 23 гаруй хувь нь гудамж талбай, зах, нийтийн хөсгийн буудлууд дээр сонин сэтгүүл борлуулдаг байна; 15-17 насны хүүхдүүдийн 48 гаруй хувь нь жижиглэн худалдаа эрхлэдэг байхад 14 гаруй хувь нь ачаа зөөдөг байна.

**Хүснэгт 25 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн нэмэлт (давхар) ажлын төрөл (хувиар)**

Насын бүлэг	Хүйс	Ачаа зөөх	Хоёрдогч түүхий эд цуглуулах	Мод хөрөөдөх, хаглах	Цэвэрлэгээ хийх	Ногоо, жимс ялгах, цэвэрлэх	Сонин, сэтгүүл зарах	Тамхи зарах	Нийт
11-14	Хөвгүүд	3.2	28.5	-	8.5	-	59.8	-	100.0
	Охид	-	-	-	-	-	100.0	-	100.0
	<b>Нийт</b>	<b>3.0</b>	<b>27.1</b>	<b>-</b>	<b>8.1</b>	<b>-</b>	<b>61.7</b>	<b>-</b>	<b>100.0</b>
15-17	Хөвгүүд	10.3	-	14.7	-	41.2	-	33.8	100.0
	Охид	13.7	-	-	86.3	-	-	-	100.0
	<b>Нийт</b>	<b>12.7</b>	<b>-</b>	<b>4.2</b>	<b>61.4</b>	<b>11.9</b>	<b>-</b>	<b>9.7</b>	<b>100.0</b>

**Хүснэгт 26 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын төрөл (насны бүлэг, үндсэн ажлын төрлөөр)**

Ажлын төрөл	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь	Насын бүлэг					
			7-10		11-14		15-17	
			Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Жижиглэн худалдаа эрхлэх	1940	100.0	-	-	843	43.4	1098	56.6
Мах эвдэх	23	100.0	-	-	-	-	23	100.0
Ачаа зөөх	567	100.0	-	-	240	42.3	327	57.7
Хоёрдогч түүхий эд цуглуулах	45	100.0	45	100.0	-	-	-	-
Банз зөөх, өрөх	395	100.0	145	36.7	124	31.4	126	31.9
Мод хөрөөдөх, хагалах	170	100.0	-	-	170	100.0	-	-
Вагоноос ачаа буулгах/вагон түрэх	91	100.0	-	-	-	-	91	100.0
Утсаар яриулах "Цагаан утас"	6	100.0	-	-	-	-	6	100.0
Барилгын ажил эрхлэх	45	100.0	-	-	-	-	45	100.0
Авто засвар, дугуй засварын газар ажиллах	14	100.0	-	-	14	100.0	-	-
Цэвэрлэгээ хийх, автомашин угаах	505	100.0	-	-	404	79.8	101	20.2
Ногоо, жимс ялгах	19	100.0	-	-	1	5.3	18	94.7
Нийтийн хоолны газар ажиллах	79	100.0	-	-	-	-	79	100.0
Сонин, сэтгүүл зарах <sup>34</sup>	722	100.0	-	-	567	78.5	155	21.5
Нийтийн тээвэрт (микро автобус) мөнгө хураагч хийх	208	100.0	-	-	-	-	207	100.0
Оёдол хийх	61	100.0	-	-	57	93.4	4	6.6
<b>Нийт</b>	<b>4890</b>	<b>100.0</b>	<b>190</b>	<b>100.0</b>	<b>2420</b>	<b>100.0</b>	<b>2280</b>	<b>100.0</b>

**Жижиглэн худалдаа эрхлэх:**

Албан бус хэвшилд жижиглэн худалдаа эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөр нь хөдөлмөр эрхлэж буй ажлын байраараа үндсэн хоёр хэлбэрт хуваагдаж байгаа юм:

- Өрхийн ажиллуулдаг дэлгүүр, ТҮЦ-д ажиллах;
- Хүнсний болон барааны зах, гудамж, талбай, нийтийн тээврийн хэрэгслийн буудал гэх мэтийн хүн амын төвлөрөл ихтэй газруудад гар дээрээс хүнсний болон бусад овор багатай бараа зарж борлуулах.

<sup>33</sup> Үндсэн ажлын хувьд

<sup>34</sup> Сурталчилгааны хэвлэмэл материал түгээх

**Ачаа зөөх:**

Хөвгүүд хүнсний болон барааны зах, модны зах, бөөний худалдааны төв зэрэг газруудад гараар болон тэргэнцрээр тус зах дээр үйлчилгээ эрхлэдэг болон үйлчлүүлж буй иргэдийн ачаа барааг лангуу, агуулах газраас автомашины болон нийтийн тээврийн зогсоол хүртэл зөөдөг байна<sup>35</sup>.

**Мах эвдэх:**

“Хүчит шонхор”, “Хархорин” захуудын мах борлуулдаг лангуун дээр мах эвдэх, шулах ажлыг гол төлөв хөвгүүд хийдэг байна<sup>36</sup>.

**Хоёрдогч түүхий эд түүх цуглуулах:**

“Улаан чулуут”-ын хогийн цэг, орон сууцны болон гэр хорооллын хогийн цэгүүд, гудамжны хогийн сав, нийтийн хоолны болон бусад үйлчилгээний газруудын хаягдлаас шил, хөнгөн цагаан лааз, хуванцар эдлэлийг хүүхдүүд түүн цуглуулж хоёрдогч түүхий эд авах цэгт тушаадаг байна<sup>37</sup>.

**Банз зөөх, өрөх:**

“Хангай” болон бусад мод, барилгын материал борлуулдаг зах, цэгүүдэд банз ачиж буулгах, өрөх, зөөх зэрэг ажлыг гол төлөв хөвгүүд тус захууд, цэгүүдэд арилжаа, наймаа эрхлэдэг иргэдийн захиалгаар хийдэг байна<sup>38</sup>.

**Мод хөрөөдөх, хагалах:**

Гэр хороолол, зуслангийн айлуудын түлшний модыг хөрөөдөх, ихэвчлэн хагалах ажлыг гол төлөв хөвгүүд өөрсдийн хөрөө, сүх ашиглан эрхлэдэг байна. Тус ажлын үнэлгээ ихэвчлэн тогтвортой бүс байдаг учраас захиалагчтай тохирч хөлсөө авдаг байна.

**Вагон түрэх:**

Төмөр замтай бөөний цэг, захуудад вагоноос ачаа буулгах ажил эрхлэдэг хөвгүүд ачааг нь буулгасан вагоныг түрж ачаа ачих/буулгах тавцангаас холдуулдаг байна.

**“Цагаан” утсаар яриулах:**

“Цагаан” утсаар яриулдаг өрхийн насанд хүрсэн гишүүнд туслах ажлыг эцэг эх/асран хамгаалагчийн шууд хяналтын доор хүүхдүүд эрхлэдэг байна.

**Барилгын ажил эрхлэх:**

Эцэг эх/асран хамгаалагч нь барилгын засвар, чимэглэлийн ажлыг албан бусаар эрхлэдэг өрхийн хүүхдүүд тэдэнд туслах замаар барилгын ажил эрхлэдэг байна.

**Авто засвар, дугуй засварын газар ажиллах:**

Авто засвар, дугуй засварын газруудад туслах ажлыг гол төлөв хөвгүүд харьцангуй тогтвортойгоор эрхлэдэг байна.

**Цэвэрлэгээ хийх, автомашин угаах:**

Хүүхдүүдийн цэвэрлэгээ хийх, автомашин угаах ажил үндсэн хоёр хэлбэртэй байна:

- Хүнсний захын лангуу, цайны газрын цэвэрлэгээг ихэвчлэн охидууд эрхлэдэг байна;
- Автомашины зогсоол, гудамж, талбайд автомашин угаах ажлыг (дулааны улиралд илүүтэй) охид хөвгүүдийн аль аль нь хийдэг байна<sup>39</sup>.

<sup>35</sup> Нэг хүний ачааг зөөх нь ачааны овор, хэмжээ, жингээс хамааран 500-1500 төгрөг байдаг

<sup>36</sup> Бог малын гулуузыг эвдэх, шулах нь 800-1000 төгрөгийн үнэлгээтэй байдаг байна

<sup>37</sup> Хүүхдүүд өдөрт 1000-2500 төгрөгийн түүхий эд тушаадаг байна.

<sup>38</sup> Захуудад банз зөөж, өрж буй хөвгүүд гол төлөв тогтмол ажил олгогчгүй байдаг

<sup>39</sup> Автомашин угаах төлбөр 500-1000 төгрөг

**Ногоо, жимс ялгах:**

Хүнсний зах, бөөний худалдааны төвүүдэд төмс, хүнсний ногоо, жимс ялгах ажлыг ихэвчлэн охидууд хийдэг байна. Тэд төмс, хүнсний ногоо, жимсийг үнэ төлбөргүй ялгаж, харьцангуй бага гэмтэж мүүдсаныг нь өөрийн өрхийн хэрэгцээнд болон цаашид борлуулах зорилгоор авдаг байна.

**Нийтийн хоол, цайны газарт ажиллах:**

Охидууд гол төлөв хүнсний болон барааны зах, түүний зэрэгцээ байрладаг гуанз, цайны газарт бэлтгэгч, угаагч, цэвэрлэгч, зөөгч зэрэг мэдлэг, чадвар төдийлөн шаарддаггүй ажлыг ажил олгогчийн хяналтан доор хөлстэйгээр эрхлэдэг байна. Мөн өрхийн ажиллуулдаг гуанз, цайны газарт хөлсгүйгээр төрөл бүрийн ажлыг гол төлөв охидууд хийх явдал нэлээд өргөн дэлгэрсэн байна.

**Сонин, сэтгүүл зарах:**

Гудамж, талбай, нийтийн тээврийн буудал, дэлгүүр, нийтийн хоолны газар зэрэг хүн олноор төвлөрсөн цэгүүдэд охид, хөвгүүд сонин, телевизийн хөтөлбөр, сурталчилгааны материалыг гар дээрээс борлуулдаг байна. Хүүхдүүдэд тухайн хэвлэмэл материалыг борлуулагч/түгээгчээс худалдан авахад нь тэдний эцэг эх (асран хамгаалагч), ах эгч нь тодорхой хэмжээнд туслалцаа үзүүлдэг байна.

**Нийтийн тээвэрт (микро автобус) мөнгө хураагч хийх:**

Ямар нэгэн лиценз, тусгай зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй нийтийн тээврийн үйл ажиллагаа явуулж буй микроавтобусанд хүүхдүүд мөнгө хураагч болон мөнгө хураагчийн туслахыг ихэвчлэн хөвгүүд эрхлэдэг байна. Мөн төвлөрөл ихтэй нийтийн тээврийн буудлуудад зорчигчдыг уриалан дуудах ажлыг эдгээр хүүхдүүд давхар эрхлэх явдал дэлгэрчээ.

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН АЖЛЫН БАЙР****Ажлын байрны байршил**

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн ажлын байрны байршлыг хүснэгтээс харахад 48 хувь нь зах дээр, 29 хувь нь тогтвортой бус газар (гудамж, талбайд), 14 хувь нь дэлгүүрт ажиллаж байна. Гар үйлдвэрийн газар болон нийтийн хоолны газарт 190 орчим хүүхэд, хогийн цэг дээр хоёрдогч түүхий эд түүн цуглуулж амьжиргаагаа залгуулдаг 140 хүүхэд байгаа нь нийт хүүхдийн 3 хувийг тус тус эзэлж байна.

**Хүснэгт 27 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны байршил (хувиар)**

Насын бүлэг	Хүйс	Ажил олгогчийн гэр	Дэлгүүр, ТҮЦ	Зах	Нийтийн хоолны газар	Барилга	Үйлдвэр	Хогийн цэг	Тогтвортой бус	Нийт
7-10	Хөвгүүд	-	-	-	-	-	-	75.4	24.6	100.0
	Охид	-	-	100.0	-	-	-	-	-	100.0
	<b>Нийт</b>	-	-	3.7	-	-	-	72.6	23.7	100.0
11-14	Хөвгүүд	<1.0	2.8	73.9	-	-	-	-	22.6	100.0
	Охид	9.9	43.1	14.9	-	-	-	-	32.2	100.0
	<b>Нийт</b>	2.9	12.4	59.8	-	-	-	-	24.9	100.0
15-17	Хөвгүүд	<1.0	<1.0	42.6	-	2.1	10.3	<1.0	43.2	100.0
	Охид	<1.0	32.8	35.2	4.6	-	1.9	-	24.6	100.0
	<b>Нийт</b>	<1.0	17.5	38.7	2.5	1.0	5.9	<1.0	33.4	100.0
Бүгд	Хөвгүүд	<1.0	1.8	58.7	-	<1.0	3.6	4.6	29.9	100.0
	Охид	3.7	36.0	28.9	3.1	-	1.3	-	27.0	100.0
	<b>Нийт</b>	1.8	14.3	47.8	1.1	<1.0	2.7	2.9	28.8	100.0



Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 50 орчим хувь нь Улаанбаатар хотын худалдааны захууд дээр хөдөлмөр эрхлэж байна. Тэднээс 500 орчим нь “Нарантуул” зах болон тус захын ойр тойронд дараах төрлийн ажил эрхлэж байна:

- Жижиглэн худалдаа эрхлэх (эцэг эх/асран хамгаалагчийнхаа эрхлэдэг лангуун дээр ажиллах, бие даан гар дээрээс жимс, чихэр, тамхи, тор зэрэг жижиглэнгийн бараа, сонин сэтгүүл борлуулах);
- Ачаа зөөх (“Нарантуул” захын удирдлага хүүхдүүдэд тэргэнцэр түрээслэхгүй гэсэн бодлогыг баримталдаг боловч насанд хүрсэн иргэд захын удирдлагаас тэргэнцрийг түрээслэн хүүхдүүдэд давхар түрээслэх явдал ихээр дэлгэрсэн байна);
- Лангуу цэвэрлэх;
- Нийтийн тээврийн (микроавтобус) тийз түгээгчийн туслах хийх;
- Автомашин угаах, манах;
- Нийтийн хоолны газар туслах ажил эрхлэх.

Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 30 орчим хувь нь гудамж талбайд (хүн ам олноор төвлөрсөн газар) дараах төрлийн хөдөлмөр голчлон эрхлэдэг байна:

- Жижиглэн худалдаа эрхлэх (гар дээрээс хүнсний болон бусад жижиглэнгийн бараа зарах);
- Автомашин угаах, манах<sup>40</sup>;
- Гутал тослох, өнгөлөх;
- Гуйлга гуйх<sup>41</sup> (хандив хүсэх);
- Шил, лааз, хуванцар зэрэг хоёрдогч түүхий эд цуглуулах.

Гудамж, талбайд хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүд гол төлөв ажил олгогчгүй, бие даан хөдөлмөр эрхлэдэг.

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 16 орчим хувь нь өөрийн өрхийн бизнес болох жижиг дэлгүүр (мухлаг), ТҮЦ гэх мэтийн хүнсний болон өргөн хэрэглээний бараа борлуулдаг цэгүүдэд голдуу өрхийн насанд хүрсэн гишүүдэд туслах байдлаар хөдөлмөр эрхлэж байна.

### **Хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн ажлын байрны нөхцөл**

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн 53 хувь жилийн дөрвөн улиралд гадаа (гудамж, талбай, худалдааны зах) хөдөлмөр эрхлэдэг байна.

**Хүснэгт 28 Хүйтний улиралд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны байршил (хувиар)**

Насын бүлэг	Хүйс	Дотор	Гадаа	Дотор ба гадаа	Нийт
7-10	Хөвгүүд	-	100.0	-	100.0
	Охид	-	100.0	-	100.0
	<b>Нийт</b>	-	100.0	-	100.0
11-14	Хөвгүүд	22.3	67.5	10.2	100.0
	Охид	52.9	42.1	5.0	100.0
	<b>Нийт</b>	30.2	60.9	8.9	100.0
15-17	Хөвгүүд	24.3	44.5	31.1	100.0
	Охид	43.4	26.8	29.8	100.0
	<b>Нийт</b>	33.6	35.9	30.5	100.0
Бүгд	Хөвгүүд	21.6	61.1	17.2	100.0
	Охид	46.7	32.7	20.6	100.0
	<b>Нийт</b>	30.5	51.1	18.4	100.0

<sup>40</sup> Ялангуяа дулааны улиралд

<sup>41</sup> Дуу дуулах хэлбэрээр гуйлга гуйх

Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны нөхцөлд дүн шинжилгээ хийхэд нийт хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн:

- 80 хувь нь хэт их тоосжилт, чийгтэй ажлын байранд (модны зах, хогийн цэг);
- 67 хувь нь хэт их халуун, хүйтэн, дуу чимээ ихтэй, доргилттой ажлын байранд;
- 49 хувь нь ажлын байрандаа хүнд ачаа өргөж, зөөдөг;
- 13 хувь нь түлэгдэх, огтлогдох зэрэг эрсдэлтэй ажлын байранд (гуанз, цайны газар);
- 12 хувь нь хүнд эсвэл хурц үзүүртэй багаж хэрэглэдэг (гутал, автомашин, дугуй засварын газар) ажлын байранд;
- 9 хувь нь ариун цэврийн шаардлага хангахгүй, өмхий үнэртэй газарт (хогийн цэг, гуанз, цайны газар);
- 6 хувь нь хортой болон бохирдсон орчинд (хогийн цэг);
- 3 хувь<sup>42</sup> нь өндрөөс унах, шархдах, хоёр зүйлийн хооронд хавчуулагдах, дарагдах эрсдэлтэй ажлын байранд (барилга, бөөний цэг)

хөдөлмөр эрхлэдэг байна.

**Хүснэгт 29 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны нөхцөл<sup>43</sup>**

Ажлын байрны нөхцөл	Хүүхдийн тоо	Нийт хүүхдийн дүнд эзлэх хувь	Хүйс			
			Хөвгүүд		Охид	
			Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Газар доор, усан доор, аюултай өндөр газарт болон давчуу зайтай газар	141	2.9	135	4.4	6	0.3
Өндрөөс унах, шархдах, хоёр зүйлийн хооронд хавчуулагдах, юманд дарагдах эрсдэлтэй ажлын байранд	151	3.0	151	4.9	-	-
Хүнд ачаа өргөх, зөөх ажил	2392	49.0	2095	67.6	297	16.5
Хүнд эсвэл хурц үзүүртэй багаж хэрэглэх ажил	584	12.0	523	16.9	60	3.3
Түлэгдэх, шарагдах, огтлогдох зэрэг эрсдэлтэй тулгардаг ажил	647	13.0	257	8.3	390	21.8
Аюултай амьтан болон шавьж хорхой ихтэй ажлын байранд	84	1.7	77	2.5	7	0.4
Ариун цэврийн шаардлага хангахгүй, өмхий эвгүй үнэртэй ажлын байранд	462	9.4	266	8.6	197	11.0
Хортой болон бохирдсон ажлын байранд	276	5.6	276	8.9	-	-
Хортой хий, химийн тэсрэх бодис, болон шингэн, шатдаг аюултай материалтай харьцдаг ажил	23	0.5	-	-	23	1.3
Хэт их халуун, хүйтэн, их дуу чимээтэй, доргилт, эсвэл цацраг туяатай ажлын байранд <sup>44</sup>	3292	67.3	2358	76.1	934	52.1
Хэт их тоосжилт, чийгтэй ажлын байранд <sup>45</sup>	3890	79.5	2874	92.8	1016	56.7
Шөнө оройн цагаар	330	6.7	240	7.7	90	5.0
Эргэлдэх машин механизмтай, хөрөө рамтай харьцдаг ажлын байранд	23	0.5	23	0.7	-	-
Энгийн нөхцөл	0	0.0	0	0.0	0	0.0

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд өөрийн ажлын байрны нөхцөл хүнд, эрхлэж буй ажил нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг ихэнх тохиолдолд мэддэг байна. Хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдэд ажлын байрны онцлогоос хамааран хамгаалалтын малгай, нүдний шил, бээлий, усны гутал, амны хаалт зэрэг хөдөлмөр хамгааллын хэрэгслийн шаардлага гардаг байна. Хүйтний улиралд гадаа хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдэд юуны өмнө дулаан хувцас илүү шаардлагатай байдгийг албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдийн ихэнх онцгойлон тэмдэглэсэн.

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд хөдөлмөр эрхлэж байх явцдаа ажил олгогч, хамтран ажиллагч, үйлчлүүлэгчдийн зүгээс бие махбодийн болон сэтгэл санааны дарамтанд өртөх магадлал өндөр байдаг байна. Судалгааны мэдээллийн дүнгээс үзэхэд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдийн 27 хувь нь ажлын байрандаа бие махбодийн болон сэтгэл санааны дарамтанд тогтмол ба тогтмол бусаар өртөж байна.

<sup>42</sup> Бүгд давхардсан тоогоор

<sup>43</sup> Давхардсан тоогоор

<sup>44</sup> Хүүхдүүд гол төлөв хүйтний улиралд даарч, хөрдөг

<sup>45</sup> Худалдааны зах хэт их тоосжилттой байх явдал өргөнөөр дэлгэрсэн

**Хүснэгт 30 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өртдөг дарамтын хэлбэр (хүйсээр)**

Дарамтын хэлбэр	Дарамтад өртөж буй хүүхдийн тоо	Нийт хүүхдийн дүнд эзлэх хувь	Хүйс			
			Хөвгүүд		Охид	
			Тоо	Нийт хөвгүүдийн дүнд эзлэх хувь	Тоо	Нийт охидын дүнд эзлэх хувь
Загнуулдаг, хэл амаар доромжлуулдаг	904	18.5	651	21.0	253	14.0
Хөндий хүйтэн харьцдаг	2	0.1	-	-	2	0.2
Зодуулдаг	277	5.6	125	4.0	152	8.5
Дээрэмдүүлдэг	51	1.0	51	1.7	-	-
Хөлсөө хугацаандаа өгдөггүй	32	0.7	-	-	32	1.8
<b>Нийт</b>	<b>1266</b>	<b>25.9</b>	<b>827</b>	<b>26.7</b>	<b>439</b>	<b>24.5</b>

**Хүснэгт 31 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өртдөг дарамтын хэлбэр (насны бүлгээр)**

Дарамтын хэлбэр	Дарамтад өртөж буй хүүхдийн тоо	Нийт хүүхдийн дүнд эзлэх хувь	Насны бүлэг					
			7-10		11-14		15-17	
			Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Загнуулдаг, хэл амаар доромжлуулдаг	904	18.5	7	3.7	402	16.6	495	21.7
Хөндий хүйтэн харьцдаг	2	0.05	-	-	2	0.1	-	-
Зодуулдаг	277	5.6	49	25.8	152	6.3	76	3.4
Дээрэмдүүлдэг	51	1.05	-	-	23	1.0	28	1.2
Хөлсөө хугацаандаа өгдөггүй	32	0.7	-	-	-	-	32	1.4
<b>Нийт</b>	<b>1266</b>	<b>25.9</b>	<b>56</b>	<b>29.5</b>	<b>579</b>	<b>24.0</b>	<b>631</b>	<b>27.7</b>

**Хүснэгт 32 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн дарамт (ажлын удирдлагаар)**

Дарамтын хэлбэр	Дарамтад өртөж буй хүүхдийн тоо	Өрхийн аж ахуйд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд		Бие даан хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүд		Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн аж ахуйд хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүд	
		Тоо	Нийт өрхийн аж ахуйд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн дүнд эзлэх хувь	Тоо	Бие даан хөдөлмөр эрхлэдэг хүүхдийн дүнд эзлэх хувь	Тоо	Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн аж ахуйд хөдөлмөр эрхлэдэг хүүхдийн дүнд эзлэх хувь
		Загнуулдаг, хэл амаар доромжлуулдаг	904	200	14.2	568	26.2
Хөндий хүйтэн харьцдаг	2	2	<0.1	-	-	-	-
Зодуулдаг	277	150	10.6	127	5.9	-	-
Дээрэмдүүлдэг	51	23	1.6	-	-	28	2.1
Хөлсөө хугацаандаа өгдөггүй	32	-	-	-	-	32	2.4
<b>Нийт</b>	<b>1266</b>	<b>375</b>	<b>26.5</b>	<b>695</b>	<b>32.1</b>	<b>196</b>	<b>14.9</b>

Бие даан, өрхийн аж ахуйд хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийг үйлчлүүлэгчид нь загнах, хэл амаар доромжлох явдал нэлээд түгээмэл байдаг байна. Хөлстэйгээр хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийг үйлчлүүлэгчдээс гадна мөн ажил олгогчид нь загнах, хэл амаар доромжлох явдал гардаг байна.

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүд хэний удирдлаганд хөдөлмөр эрхлэж байгааг Хүснэгт 33-т үзүүлэв.

**Хүснэгт 33 Хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн ажлын удирдлага, хяналт (хувиар)**

Насын бүлэг	Хүйс	Ажил олгогч	Эцэг эх/хамаатан садан	Өөрөө бие даан	Нийт
7-10	Хөвгүүд	-	2.2	97.8	100.0
	Охид	-	100.0	-	100.0
	<b>Нийт</b>	-	5.8	94.2	100.0
11-14	Хөвгүүд	32.7	15.0	52.4	100.0
	Охид	11.9	62.6	25.4	100.0
	<b>Нийт</b>	27.7	26.4	45.9	100.0
15-17	Хөвгүүд	28.7	6.9	64.4	100.0
	Охид	27.8	57.1	15.1	100.0
	<b>Нийт</b>	28.2	33.5	38.3	100.0
Бүгд	Хөвгүүд	29.4	11.4	59.2	100.0
	Охид	22.5	59.1	18.4	100.0
	<b>Нийт</b>	26.9	28.9	44.3	100.0

### Хүснэгт 34 Хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн ажлын төрөл (ажлын удирдлагаар)

Ажлын төрөл	Нийт	Ажлын удирдлага					
		Өөрөө биеэ дааж		Эцэг эх/хамаатан садны хяналтан доор		Ажил олгогчийн хяналтан доор	
		Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Жижиглэн худалдаа эрхлэх	1941	763	37.2	861	61.0	317	24.0
Мах эвдэх	23	-	-	-	-	23	1.7
Ачаа зөөх	567	464	22.4	7	0.5	96	7.3
Хоёрдогч түүхий эд цуглуулах	45	45	2.0	-	-	-	-
Банз зөөх, өрөх	395	-	-	146	10.3	249	19.0
Мод хөрөөдөх, хагалах	170	170	7.8	-	-	-	-
Вагоноос ачаа буулгах/вагон түрэх	91	-	-	91	6.5	-	-
Утсаар яриулах "Цагаан утас"	6	-	-	6	0.4	-	-
Барилгын ажил эрхлэх	45	-	-	22	1.5	23	1.7
Авто засвар, дугуй засварын газар ажиллах	14	-	-	14	1.0	-	-
Цэвэрлэгээ хийх, автомашин угаах	505	-	-	38	2.7	467	30.0
Ногоо, жимс ялгах	19	-	-	18	1.3	1	0.1
Нийтийн хоолны газар ажиллах	79	-	-	29	2.0	50	3.8
Сонин, сэтгүүл зарах <sup>46</sup>	722	598	28.6	124	8.8	-	-
Нийтийн тээвэрт (микро автобус) мөнгө хураагч хийх	208	45	2.0	-	-	163	12.1
Өөдөл хийх	61	-	-	57	4.0	4	0.3

### Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэдэг хугацаа

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хоногт ажилладаг цагийг Хүснэгт 35-д үзүүлэв.

### Хүснэгт 35 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хоногт ажилладаг хугацаа (хүйсээр)

Хүүхдийн хоногт хөдөлмөр эрхлэдэг хугацаа (цагаар)	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь	Хүйс			
			Хөвгүүд		Охид	
			Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
1-3	387	7.9	56	1.8	331	18.5
4-6	1652	33.8	955	30.8	697	38.9
7-9	1804	36.9	1292	41.7	512	28.6
10-12	586	12.0	477	15.4	109	6.0
13-15	461	9.4	317	10.3	144	8.0
Хоногт ажилладаг дундаж хугацаа		7.4		6.3		8.0
<b>Нийт</b>	<b>4890</b>	<b>100.0</b>	<b>3097</b>	<b>100.0</b>	<b>1793</b>	<b>100.0</b>

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хөвгүүдийн 42 орчим хувь нь хоногт 7-9 цаг хөдөлмөр эрхлэдэг, охидын 39 орчим хувь нь хоногт 4-6 цаг хөдөлмөр эрхлэдэг байна.

Хөдөлмөр эрхлэж буй 7-10 насны хүүхдүүдийн дийлэнх олон нь хоногт 4-6 цаг; 11-14 насны хүүхдүүдийн 44 орчим хувь нь хоногт 7-9 цаг; 15-17 насны хүүхдүүдийн 32 орчим хувь нь 7-9 цаг тус тус хөдөлмөр эрхлэдэг байна.

### Хүснэгт 36 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хоногт ажилладаг хугацаа (насны бүлгээр)

Хүүхдийн хоногт хөдөлмөр эрхлэдэг хугацаа (цагаар)	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь	Насын бүлэг					
			7-10		11-14		15-17	
			Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
1-3	387	7.9	-	-	236	9.8	151	6.6
4-6	1652	33.8	180	94.7	746	30.8	726	31.8
7-9	1804	36.9	-	-	1057	43.7	747	32.8
10-12	586	12.0	6	3.2	234	9.7	346	15.2
13-15	461	9.4	4	2.1	147	6.0	310	13.6
Хоногт ажилладаг дундаж хугацаа		7.4		5.3		7.0		7.8
<b>Нийт</b>	<b>4890</b>	<b>100.0</b>	<b>190</b>	<b>100.0</b>	<b>2420</b>	<b>100.0</b>	<b>2280</b>	<b>100.0</b>

Сургуульд суралцдаг хүүхдүүдийн хоногт хөдөлмөр эрхлэдэг хугацаа сургууль завсардсан болон сургуульд огт суралцаагүй хүүхдүүдийн хоногт хөдөлмөр эрхлэдэг хугацаанаас богино байна. Сургуульд суралцаж буй хүүхэд өдөрт дунджаар 4.5 цагийг хөдөлмөрт зориулдаг байхад сургуульд суралцаагүй хүүхэд өдөрт дунджаар 6.1 цаг хөдөлмөр эрхлэдэг байна.

Бие даан хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын цаг төдийлөн тогтвортой бус байдаг бөгөөд тэд тодорхой хэмжээний орлого тухайн өдөрт олсон бол гол төлөв тэр өдрөө үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлэдэггүй байна. Тогтвортой ажлын байранд хөлстэйгээр хөдөлмөр эрхлэдэг

<sup>46</sup> Сурталчилгааны хэвлэмэл материал түгээх

хүүхдүүдийн ажлын цаг харьцангуй урт байгаа бөгөөд тэд өдөрт дунджаар 6-8 цаг ажилладаг байна.

**Хүснэгт 37 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн долоо хоногт ажилладаг өдөр (боловсролын үйлчилгээнд хамрагдсан байдлаар)**

Долоо хоногт ажилладаг өдөр	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь	Боловсролын үйлчилгээнд хамрагдсан байдал			
			Суралцдаг		Сургууль завсардсан/ Сургуульд огт сураагүй	
			Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Нэг өдөр	170	3.5	170	5.2	-	-
Хоёр өдөр	1206	24.7	1174	36.2	32	1.9
Гурван өдөр	698	14.3	473	14.6	225	13.6
Дөрвөн өдөр	491	10.0	180	5.6	311	18.8
Таван өдөр	657	13.4	19	0.6	638	38.7
Зургаан өдөр	279	5.7	51	1.6	228	13.8
Долоон өдөр	1389	28.4	1173	36.2	216	13.2
7 хоногт ажилладаг дундаж өдөр				4.1		4.9
<b>Нийт</b>	<b>4890</b>	<b>100.0</b>	<b>3240</b>	<b>100.0</b>	<b>1650</b>	<b>100.0</b>

Сургууль завсардсан хүүхдүүдийн долоо хоногт ажилладаг өдрийн тоо, өдөрт ажилладаг хугацаа боловсролын үйлчилгээнд хамрагдан сурч буй хүүхдүүдийн ажлын үргэлжлэх хугацаатай харьцуулахад харьцангуй их байна. Тэд өөрийн цагаа хөдөлмөр эрхлэхэд бүрэн зориулдаг байна. Өдөр бүр ажилладаг хүүхдүүдийн 34 хувь нь сургуульд огт сураагүй эсвэл сургууль завсардсан байна.

**Хүснэгт 38 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн долоо хоногт ажилладаг өдөр (насны бүлгээр)**

Долоо хоногт ажилладаг өдөр	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь	Насын бүлэг					
			7-10		11-14		15-17	
			Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Нэг өдөр	170	3.5	-	-	-	-	170	7.5
Хоёр өдөр	1206	24.7	-	-	550	22.7	656	28.8
Гурван өдөр	698	14.3	45	23.6	-	-	653	28.6
Дөрвөн өдөр	490	10.0	141	74.3	349	14.4	-	-
Таван өдөр	658	13.4	-	-	481	19.8	177	7.8
Зургаан өдөр	279	5.7	-	-	155	6.4	124	5.4
Долоон өдөр	1389	28.4	4	2.1	885	36.7	500	21.9
7 хоногт ажилладаг дундаж өдөр				3.8		5.0		3.8
<b>Нийт</b>	<b>4890</b>	<b>100.0</b>	<b>190</b>	<b>100.0</b>	<b>2420</b>	<b>100.0</b>	<b>2280</b>	<b>100.0</b>

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 51 хувь нь ажилдаа явган явдаг байна. Ажилдаа явган явдаг хүүхдүүдийн 43.9 хувь нь 10 минут хүртэл хугацаа, 35.8 хувь нь 11-30 минут, 2.4 хувь нь 31-60 минут, 10.3 хувь нь 1 цагаас дээш хугацаа тус тус зарцуулж ажлын байрандаа ирж очдог байна. Ажилдаа явган явдаг хүүхдүүдийн 7.6 хувь нь ажилдаа ирж/очихдоо цаг зарцуулдаггүй байна.

Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 49 хувь нь ажилдаа нийтийн тээврээр явдаг байна. Нийтийн тээврээр ажилдаа явдаг хүүхдүүдийн 13.4 хувь нь 10 минут хүртэл хугацаа, 46.7 хувь нь 11-30 минут, 6.5 хувь нь 31-60 минут, 33.4 хувь нь 1 цагаас дээш хугацаа тус тус зарцуулж ажлын байрандаа ирж очдог байна.

**Хүснэгт 39 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажилдаа хамт явдаг хүн**

Хамт явдаг хүн	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь	Насын бүлэг					
			7-10		11-14		15-17	
			Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Ганцаараа	3326	69.1	135	70.7	1719	73.2	1472	64.7
Аавтайгаа	70	1.4	-	-	9	0.4	61	2.7
Ээжтэйгээ	586	12.2	4	2.1	254	10.8	328	14.4
Ах, эгч, дүүтэйгээ	275	5.7	7	3.7	62	2.6	206	9.0
Хамт ажилладаг хүнтэйгээ	45	0.9	-	-	45	1.9	-	-
Хамаатан садантайгаа	10	0.2	-	-	-	-	10	0.4
Найз нартайгаа	506	10.5	45	23.5	261	11.1	200	8.8
<b>Нийт</b>	<b>4818<sup>47</sup></b>	<b>100.0</b>	<b>191</b>	<b>100.0</b>	<b>2350</b>	<b>100.0</b>	<b>2277</b>	<b>100.0</b>

<sup>47</sup> 71 хүүхэд хариулаагүй

### **Хөдөлмөр эрхлэж эхэлсэн үе**

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдүүдийн 40 гаруй хувь нь хөдөлмөр эрхлэж эхлээд нэг жил болоогүй байна. Тэдгээр хүүхдүүд ихэвчлэн өрхийн орлогод нэмэр болох зорилгоор хөдөлмөр эрхлэж эхэлсэн бөгөөд тэдний 63 хувь нь сургуульд сурдаг байна. Үүнээс үзэхэд хүүхэд хөдөлмөр эрхлэж эхлэх ба хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамрагдсан байдал шууд уялдаа холбоотой байгаа нь судалгаанаас харагдаж байна. Хүүхэд сургууль завсардах нь тухайн хүүхдийн хөдөлмөр эрхлэж эхлэхэд шууд нөлөөлөхийн зэрэгцээ хөдөлмөр эрхлэж эхлэх нь хүүхдийн сургууль завсардахад нөлөөлдөг хүчин зүйлийн нэг болж байна.

#### **Хүснэгт 40 Нэг жилээс богино хугацаагаар хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн тоо (насны бүлгээр)**

Хөдөлмөрлөсөн хугацаа	Нийт	Насын бүлэг		
		7-10	11-14	15-17
1 сараас доош	161	-	68	93
1 сар	122	-	-	122
2 сар	563	-	425	138
3 сар	148	-	97	51
4 сар	10	-	-	10
5 сар	551	-	270	281
6 сар	228	-	7	221
10 сар	200	-	-	200
<b>Нийт</b>	<b>1983</b>	<b>-</b>	<b>867</b>	<b>1116</b>

Судалгааны мэдээлэл цуглуулах үед албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй 160 орчим хүүхэд судалгаанд хамрагдах үед эрхлэж байсан ажлаа хийж эхлээд нэг сар хүрээгүй байв. Тэдгээр хүүхдүүд шаардлага гарсан тохиолдолд л хөдөлмөр эрхлэдэг бөгөөд тогтвортойгоор хөдөлмөр эрхлэдэггүй байна. Тэдний хувьд өөрийн хэрэгцээнд мөнгө олох нь хөдөлмөр эрхлэх гол шалтгаан болдог байна.

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдүүдийн 56 гаруй хувь нь нэг жилээс дээш хугацаагаар хөдөлмөр эрхлэж байна.

Нэг жилээс дээш хугацаагаар хөдөлмөр эрхлэж байгаа 2740 хүүхдийн 27 хувь нь 1-2 жил; 60 хувь нь 2-3 жил; 10 хувь нь 4-6 жил; 2 хувь нь 8 жил; нэг хүрэхгүй хувь нь 10 жил ажилласан байна.

Удаан хугацаагаар хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд гол төлөв өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилготой хөдөлмөр эрхлэдэг бөгөөд өөрийн өрхийн орлогод тухайн хүүхдүүдийн оруулж буй хувь нэмэр өндөр байдаг байна.

Удаан хугацаагаар тогтвортой хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд гол төлөв дараах төрлийн хөдөлмөр эрхлэдэг байна. Үүнд:

- Жижиглэн худалдаа;
- Сонин, сэтгүүл зарах;
- Цэвэрлэгээ хийх.

### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС, ОРЛОГО, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ**

Албан бус хэвшилд бие даан хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн сарын дундаж цэвэр ашиг 25000-30000 төгрөг байдаг байна. Бие даан хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн орлого тус хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагааны идэвхээс шууд хамааралтай байдаг бөгөөд тэд хөдөлмөр эрхлэж буй нөхцөлд өдөр болгон тодорхой хэмжээний орлоготой байдаг байна.

Албан бус хэвшилд бие даан хөдөлмөр эрхлэхийн давуу болон сул талуудыг хүүхдүүд дараах байдлаар тодорхойлж байлаа:

Давуу талууд:

- Хэзээ, хаана, ямар хөдөлмөр эрхлэхээ өөрөө сонгодог;
- Хүнд загнуулж, доромжлуулдаггүй;
- Өөрийн дураар ажилладаг, ямар нэгэн цаг хугацаанд баригддаггүй;

Сул талууд:

- Орлогын түвшин тогтвортой бус;
- Ажлын байр тогтворгүй.

Албан бус хэвшилд хөлстэйгээр хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн сарын дундаж хөлсийг Хүснэгт 41-д үзүүлэв. Хөлстэйгээр хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд хөдөлмөрийн хөлсөө бэлэн мөнгөөр дараах давтамжтайгаар авдаг байна: 87.3 хувь нь өдөр тутам; 1 хүртэл хувь нь долоо хоногт нэг удаа; 8.3 хувь нь сард хоёр удаа; 4.1 хувь нь сард нэг удаа.

**Хүснэгт 41 Хөлстэйгээр хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн сарын хөлс<sup>48</sup>**

Хөлс (Төгрөгөөр)	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь	Насны бүлэг					
			7-10		11-14		15-17	
			Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
5001-10 000	6	0.4	-	-	-	-	6	0.9
10 001-15 000	547	36.2	-	-	404	47.3	143	21.8
15 001-20 000	60	4.0	-	-	-	-	60	9.1
20 001-25 000	135	8.9	-	-	-	-	135	20.6
25 001-30 000	363	24.0	-	-	214	25.0	149	22.7
30 001-40 000	107	7.1	-	-	-	-	107	16.3
40 001-50 000	75	5.0	-	-	46	5.4	29	4.4
50 001-60 000	46	3.0	-	-	19	2.2	27	4.2
80 001-100 000	172	11.4	-	-	172	20.1	-	-
<b>Нийт</b>	<b>1511</b>	<b>100.0</b>	-	-	<b>855</b>	<b>100.0</b>	<b>656</b>	<b>100.0</b>

Албан бус хэвшилд хөлстэйгээр хөдөлмөр эрхлэхийн давуу болон сул талуудыг хүүхдүүд дараах байдлаар тодорхойлж байлаа:

Давуу талууд:

- Ажлын байр тогтвортой;
- Орлого харьцангуй тогтвортой;

Сул талууд:

- Хүний удирдлаганд байдаг;
- Загнуулдаг.

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 29 хувь нь өрхийн эрхлэж буй бизнест хөлсгүйгээр хөдөлмөр эрхлэдэг байна. Тэдэнд эцэг эх/асран хамгаалагч эсвэл тухайн бизнесийг удирдан эрхлэдэг хамаатан садан нь ихэнх тохиолдолд хөлс өгдөггүй бөгөөд тогтмол бусаар тодорхой хэмжээний мөнгөн болон мөнгөн бус хэлбэрийн урамшуулал өгдөг байна.

**Хүснэгт 42 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн орлого, хөлсөө авдаг байдал (хувиар)**

Ажлын удирдлага	Хүйс	Өөрөө	Эцэг	Эх	Нийт
Ажил олгогчтой, хөлсөөр хөдөлмөр эрхэлдэг	Хөвгүүд	46.6	-	53.4	100.0
	Охид	56.0	16.4	27.6	100.0
	<b>Нийт</b>	47.6	1.9	50.5	100.0
Өрхийн бизнест хөлсгүй оролцдог	Охид	-	100.0	-	100.0
	<b>Нийт</b>	-	100.0	-	100.0
Өөрөө бие даан	Хөвгүүд	62.8	-	37.2	100.0
	Охид	20.5	-	79.5	100.0
	<b>Нийт</b>	48.2	-	51.8	100.0

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүд өөрсдийн олсон орлого хэрхэн зарцуулдаг талаар Хүснэгт 43-т харуулав.

<sup>48</sup> Судалгааны мэдээлэл цуглуулах үеийн байдлаар сүүлийн сард авсан хөлс

**Хүснэгт 43 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн орлогын зарцуулалт (дундаж, хувиар)<sup>49</sup>**

Насын бүлэг	Хүйс	Түрээс төлдөг	Сургуулийн төлбөр, сурах бичиг авхад зарцуулдаг	Эзэг эхдээ өгдөг	Зөвхөн өөрөө хэрэглэдэг	Хүнсэнд зарцуулдаг	Хувцас авдаг	Нийт
7-10	Хөвгүүд	-	-	73.4	-	26.6	-	100.0
	Охид	-	-	-	-	100.0	-	100.0
	<b>Нийт</b>	-	-	70.7	-	29.3	-	100.0
11-14	Хөвгүүд	-	22.6	56.8	-	20.7	-	100.0
	Охид	<1.0	<1.0	65.4	14.6	19.4	-	100.0
	<b>Нийт</b>	<1.0	18.0	58.5	3.0	20.4	-	100.0
15-17	Хөвгүүд	4.1	17.3	37.2	6.1	35.2	-	100.0
	Охид	2.5	-	53.3	13.6	26.0	4.5	100.0
	<b>Нийт</b>	3.4	9.3	44.7	9.6	31.0	2.1	100.0
<b>Бүгд</b>	Хөвгүүд	1.4	19.3	50.9	2.2	26.1	-	100.0
	Охид	1.7	<1.0	57.1	13.8	24.1	3.0	100.0
	<b>Нийт</b>	1.5	13.3	52.9	5.9	25.5	<1.0	100.0

Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 50 хувь нь өөрийн олсон орлогынхоо дийлэнх хувийг эцэг эхдээ (асран хамгаалагчдаа) өгдөг бөгөөд үлдсэн хувийг нь өөрсдөө захиран зарцуулдаг байна.

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН БОЛОВСРОЛ**

Судалгааны мэдээллийн дүнгээс үзэхэд Улаанбаатар хотод албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа нийт хүүхдүүдийн 87 хувь нь уншиж, бичиж чаддаг байлаа. Хөвгүүд хөдөлмөр илүүтэй эрхлэхийн зэрэгцээ тэдний дунд уншиж, бичиж чаддаггүй хүүхдүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байна.

**Хүснэгт 44 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн уншиж, бичиж чадвар (хувиар)**

Насын бүлэг	Хүйс	Уншиж бичиж чаддаг	Уншиж бичиж чаддаггүй	Нийт
7-10	Хөвгүүд	-	100.0	100.0
	Охид	-	-	100.0
	<b>Нийт</b>	-	100.0	100.0
11-14	Хөвгүүд	83.7	16.3	100.0
	Охид	100.0	-	100.0
	<b>Нийт</b>	87.6	12.4	100.0
15-17	Хөвгүүд	87.4	12.6	100.0
	Охид	100.0	-	100.0
	<b>Нийт</b>	94.1	5.9	100.0
<b>Бүгд</b>	Хөвгүүд	80.0	20.0	100.0
	Охид	99.6	<1.0	100.0
	<b>Нийт</b>	87.2	12.8	100.0

Улаанбаатар хотод албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийг бүрэн төгссөн анги, эзэмшсэн боловсролын түвшингөөр авч үзэхэд нийт хүүхдийн 3 хувь нь бүрэн дунд; 22 хувь нь бүрэн бус дунд; 54 хувь бага боловсролтой; 21 хувь нь боловсролгүй байна.

**Хүснэгт 45 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн боловсролын түвшин<sup>50</sup> (насаар)**

Боловсролын түвшин	Хүүхдийн тоо	Дунд эзлэх хувь	Нас										
			9	10	11	12	13	14	15	16	17		
Бүрэн дунд	49	1.0	-	-	-	-	-	-	-	-	-	19	30
Суурь боловсрол	981	20.1	-	-	-	-	-	-	-	-	230	642	108
Бага	2679	54.8	-	-	113	103	250	966	794	261	-	-	193
Боловсролгүй	1005	20.5	-	142	113	-	305	445	-	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>4713</b>	<b>96.4</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хариулаагүй хүүхэд	176	3.6	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>4890</b>	<b>100.0</b>	-	<b>142</b>	<b>226</b>	<b>103</b>	<b>555</b>	<b>1411</b>	<b>1024</b>	<b>922</b>	<b>331</b>		


Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдүүдийн 66 хувь нь 2005 оны 10-р сарын байдлаар сургуульд сурч; 30 хувь нь сургуульд завсардсан; 4 хувь нь сургуульд огт сурч байгаагүй байна.

<sup>49</sup> Давхардсан тоогоор

<sup>50</sup> Судалгааны мэдээлэл цуглуулах үед бүрэн эзэмшсэн боловсролын түвшингээр



**Зураг 6 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн сургуульд хамрагдсан байдал**



**Хүснэгт 46 Хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн сургуульд хамрагдсан байдал (хувиар)**

Насны бүлэг	Хүйс	Суралцаж байгаа	Сургууль завсардсан	Огт суралцаж байгаагүй	Нийт
7-10	Хөвгүүд	-	73.4	26.6	100.0
	Охид	-	100.0	-	100.0
	<b>Нийт</b>	-	74.3	25.7	100.0
11-14	Хөвгүүд	62.0	31.3	6.7	100.0
	Охид	78.3	21.7	-	100.0
	<b>Нийт</b>	65.9	29.0	5.1	100.0
15-17	Хөвгүүд	55.2	44.5	0.4	100.0
	Охид	87.4	12.6	-	100.0
	<b>Нийт</b>	72.2	27.6	0.2	100.0
Бүгд	Хөвгүүд	56.0	38.4	5.7	100.0
	Охид	84.2	15.8	-	100.0
	<b>Нийт</b>	66.3	30.1	3.6	100.0

7-10 насны хүүхдүүд бүгд сургууль завсардсан эсвэл сургуульд огт суралцаагүй байна. Энэхүү бага насны хүүхдүүд боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй байгаад тухайн хүүхдийн өрх хүүхдийн хичээлийн хэрэгсэл болон сургуульд суралцахтай холбоотой бусад зардлыг санхүүжүүлэх боломжгүй байдал голчлон нөлөөлсөн байна.

242 хүүхэд буюу нийт сургууль завсардсан хүүхдүүдийн 16 гаруй хувь нь хөдөлмөр эрхлэж эхэлснээсээ хойш сургууль завсардсан байна. Тэд гол төлөв "Сургуулиас шаардах мөнгөн болон мөнгөн бус хандивыг өгөх боломжгүй" тул сургуулиас завсарджээ.

"Амьдарч байгаа хороондоо бүртгэлгүй учраас сургууль авдаггүй", "сургуулиас шаардсан мөнгөн болон мөнгөн бус хандивийг өгөх боломж байхгүй", "өрхийн орлогод нэмэр болох" зэрэг шалтгаан давхардсан тоогоор нийт сургууль завсардсан хүүхдүүдийн 75 хувийн сургууль завсардахад (сургуулиас гарахад) нөлөөлсөн гол хүчин зүйлс болсон байна.

**Хүснэгт 47 Сургууль завсардсан хүүхдүүдийн сургууль завсардахад нөлөөлсөн нэгдүгээр хүчин зүйл (хувиар)**

Насны бүлэг	Хүйс	Суралцах сонирхолгүй	Өрх хороондоо бүртгэлгүй учраас сургуульд аваагүй	Хичээлийн хэрэгсэл, хувцас байхгүй учраас	Сургууль хол байрладаг	Сургуулиас шаардах мөнгөн болон мөнгөн бус хандив өгөх боломжгүй учраас	Орлого олох шаардлагатай тул	Эцэг эх сургуульд явуулдаггүй	Одоогийн боловсрол, мэдлэг хангалттай	Нийт
7-10	Охид	-	-	100.0	-	-	-	-	-	100.0
	<b>Нийт</b>	-	-	100.0	-	-	-	-	-	100.0
11-14	Хөвгүүд	1.2	30.2	12.1	3.4	43.0	-	10.1	-	100.0
	Охид	-	<1.0	99.2	-	-	-	-	-	100.0
	<b>Нийт</b>	1.0	24.9	27.9	2.8	35.2	-	8.3	-	100.0
15-17	Хөвгүүд	18.2	1.1	36.7	-	-	7.8	-	36.2	100.0
	Охид	-	21.8	36.7	12.9	-	28.6	-	-	100.0
	<b>Нийт</b>	13.1	6.9	36.7	3.7	-	13.7	-	26.0	100.0
Бүгд	Хөвгүүд	8.0	18.6	21.8	2.0	25.9	3.1	6.1	14.4	100.0
	Охид	-	11.8	66.3	6.8	-	15.1	-	-	100.0
	<b>Нийт</b>	6.2	17.1	32.0	3.1	19.9	5.8	4.7	11.1	100.0

**Хүснэгт 48 Сургууль завсардсан хүүхдүүдийн сургууль завсардахад нөлөөлсөн хоёрдугаар хүчин зүйл (хувиар)**

Насны бүлэг	Хүйс	Өрх хороондоо бүртгэлгүй учраас сургуульд аваагүй	Хичээлийн хэрэгсэл, хувцас байхгүй учраас	Сургууль хол байрладаг	Сургуулиас шаардах мөнгөн болон мөнгөн бус хандив өгөх боломжгүй учраас	Орлого олох шаардлагатай тул	Нийт
7-10	Охид	-	-	-	-	100.0	100.0
	Нийт	-	-	-	-	100.0	100.0
11-14	Хөвгүүд	-	63.2	-	8.6	28.3	100.0
	Охид	-	-	-	100.0	-	100.0
	Нийт	-	43.3	-	37.4	19.3	100.0
15-17	Хөвгүүд	24.7	-	-	75.3	-	100.0
	Охид	-	38.6	38.6	-	22.9	100.0
	Нийт	17.0	12.1	12.1	51.7	7.2	100.0
Бүгд	Хөвгүүд	10.0	37.8	-	35.3	16.9	100.0
	Охид	-	15.0	15.0	57.9	12.1	100.0
	Нийт	6.8	30.4	4.8	42.6	15.4	100.0

Хүүхдийн өрхийн орлого өрхийн гишүүн хөдөлмөр эрхлэхээ болих, өрхийн бизнес уналтанд орох гэх мэт шалтгааны улмаас буурах нь тухайн өрхийн хүүхдэд суралцахад шаардагдах хичээлийн хэрэгсэл, хувцасны зардлыг өрх санхүүжүүлэх чадваргүй болох нөхцлийг бүрдүүлэх эрсдлийг агуулдаг байна.

Хэдийгээр төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамжийн тогтолцооны хүрээнд ядуу ба нэн ядуу өрхийн хүүхдүүдэд сургуульд суралцахад дэмжлэг (хичээлийн хэрэгсэл, хувцас, гутал гэх мэт) үзүүлж байгаа боловч тэрхүү тусламж, дэмжлэг нь зөвхөн оршин сууж буй хороондоо бүртгэлтэй өрхийн хүүхдүүдэд тусламж, дэмжлэгийг үзүүлж байгаа тул бүртгэлгүй өрхийн хүүхдийн сургуульд суралцах нөхцлийг бүрдүүлж чаддаггүй байна.

“Одоогийнхоос илүү (уншиж, бичих чадвараас) боловсрол шаардлагагүй” гэсэн ойлголт нь хүүхдийг сургууль завсардахад нөлөөлж буй дараах хүчин зүйл болж байна. Боловсролын салбарын нэр хүнд унаж байгаа нь хүүхдүүдийн сургуульд суралцах сонирхолд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа нь гарцаагүй юм.

Сургуулийн (ангийн багш, сургуулийн удирдлага) хүүхдээс шаардах мөнгөн болон мөнгөн бус хандивыг (анги засварлах зардал, ном худалдан авах, төрөл бүрийн бэлэг авах, гэх мэт) өгөх боломжгүй байдал хүүхдийн сургууль завсардахад нөлөөлдөг байна.

Хүүхдүүд сургуульд огт суралцаагүйн гол шалтгаан нь мөн л хичээлийн хэрэглэл, хувцасны зардлыг хүүхдийн эцэг эх (хүүхэд өөрөө) санхүүжүүлэх боломжгүйтэй холбоотой байна.

**Хүснэгт 49 Сургуульд огт суралцаагүй хүүхдүүдийн суралцаагүй шалтгаан (давхардсан тоогоор)**

Нөлөөлж буй хүчин зүйл	Сургуульд огт суралцаагүй хүүхдийн дүнд эзлэх хувь
Хичээлийн хэрэгсэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадахгүй	70.8
Суралцах сонирхолгүй	38.6
Мэдэхгүй	25.5
Өрхийн аж ахуйн ажилд тусалдаг, ажилладаг	6.3

Сургуульд огт сураагүй, сургуулиас завсардсан хүүхдүүд доорх нөхцөл байдал бүрдсэн үед цааш суралцах сонирхолтой байдаг байна. Үүнд:

- Хүүхэд өрхийн орлогод хувь нэмэр оруулах шаардлага нь бага зэрэг ч гэсэн буурсан (хүүхэд сургуульд суралцах цаг завтай болсон);
- Хүүхдийн боловсролын түвшин, хоцрогдлыг арилгах сургалтын хөтөлбөрт хамрагдах боломжтой үед;
- Сургуулийн удирдлага, багш нар мөнгөн болон мөнгөн бус хураамж шаардахгүй нөхцөлд;

- Хүүхдүүд сургуульд суралцахад шаардагдах хувцас, хичээлийн хэрэгслийг авах бололцоотой үед.

## **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНД**

Улаанбаатар хотод албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 22 орчим хувь нь хөдөлмөр эрхлэлттэй холбоотой шалтгааны улмаас өвдсөн байна. Хүүхдүүдийн 10 хувь<sup>51</sup> нь хөдөлмөр эрхэлсэнээс хойш эрүүл мэндэд нь сөрөг өөрчлөлт (илүүтэй өвддөг, амархан ядардаг гэх мэт) орсон гэж үзэж байлаа.

Нийслэлд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдүүдийн 85.5 хувь нь эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй байна. Эрүүл мэндийн даатгалын дэвтэр шинээр авахын тулд хэнд, ямар журмын дагуу хандах талаар мэдэхгүй, эцэг эх нь иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн зэрэг шалтгаануудын улмаас хүүхдүүдийн 14.5 хувь нь эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй байна.

Хөдөлмөр эрхлэж байхдаа өвдсөн хүүхдүүдийн 16 хувь нь л эмнэлэгт (гол төлөв оршин сууж буй хорооныхоо өрхийн эмнэлэгт) хандаж мэргэжлийн эмчийн зөвлөгөө, зааварчилгаа авдаг байхад бусад нь эрүүл мэндийн байгууллагад хандахгүй гэрээрээ эмчилгээ хийлгэдэг байна. Мөн эмийн сангийн эм зүйчээс эмчилгээний зааварчилгаа авч эмчилгээ хийх байдал нэлээд газар авсан нь судалгааны явцад ажиглагдаж байлаа.

Хүүхдүүд голдуу амьсгалын замын өвчин<sup>52</sup>, шээс ялгаруулах тогтолцооны өвчин, мэдрэлийн тогтолцооны өвчин, арьсны өвчин, харшил, гэдэсний халдварт өвчнөөр өвчилдөг байна. Хүүхдүүд өвчин эмгэгт өртөмтгий байгаад дараах хүчин зүйлс шууд болон шууд бус байдлаар нөлөөлдөг байна:

- Хүүхдүүдийн хөдөлмөрийн орчин эрүүл ахуйн шаардлагыг тэр болгон хангадаггүй;
- Хүүхдүүд бие махбодьдоо шаардагдах хангалттай хэмжээний илчлэг, амин дэмийг хэрэглэж буй хоол хүнснээсээ тэр болгон авч чаддаггүй;
- Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд хүйтний улиралд даарч хөрдөг байдал.

Хөдөлмөр эрхлэх явцдаа өвдөж байсан хүүхдүүдийн 42 хувь нь өвчтэй байх хугацаандаа ажлаа үргэлжлүүлэн хийж байсан. Эдгээр хүүхдүүдийн ажлаа үргэлжлүүлэн хийх болсон гол шалтгаан нь өвчин хөнгөн байсан (50 хувь нь), өдрийн орлого тасалдах (50 хувь нь) байв.

## **Гэмтэл**

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 16 хувь нь хөдөлмөр эрхлэх явцдаа эрхлэж буй ажилтайгаа холбоотойгоор гэмтэж бэртэж байсан байна. Хүүхдүүд ажлын байрандаа голдуу шарх, зөөлөн эдийн няцралт, хугаралт зэрэг гэмтэлд өртдөг байна.

Би 8-р ангиа төгсөөд цааш суралцаагүй. Аавтайгаа хамт айлын дүнзэн байшин барьж, засахад нь тусалдаг. Ихэвчлэн дулааны улиралд ажил их байдаг. Өвөл хааяа гадна ажиллах тохиолдол гардаг. Тэр үед ажиллахад надад маш хэцүү байдаг. Учир нь өвлийн хүйтэнд гадаа ажиллаж байхад гар хөл бээрч даардаг. Өнгөрсөн өвөл би байшингийн дээвэр засч байгаад зүүн гарынхаа гурван хурууг бага зэрэг хөлдөөж байсан. Ер нь барилгын ажлыг ямар ч улиралд хийсэн бай заавал хамгаалалтын хувцас хэрэгслийг хэрэглэх хэрэгтэй юм билээ. Би цаашдаа энэ чиглэлээр суралцаж ажил хөдөлмөр эрхлэж сайхан амьдрах хүсэлтэй байдаг.  
Э....., 16 настай, Чингэлтэй дүүрэг

Хүнд гэмтсэн тохиолдолд хүүхдүүд/тэдний эцэг эх Гэмтэл согогийн сэргээн засварлах клиникийн эмнэлэгт хандаж эмнэлгийн анхан шатны тусламж авдаг боловч үргэлжлүүлэн эмчлүүлэх, нөхөн сэргээх эмчилгээнд төдийлөн анхаарал тавьдаггүй байна.

<sup>51</sup> Хүүхдүүдийн өөрийн үнэлгээгээр

<sup>52</sup> Хүйтний улиралд, томууны халдварын тархалтын үед

**Хүснэгт 50 Хүүхдүүдийн эрхлэж буй хөдөлмөртэйгээ холбоотой авсан гэмтлийн төрөл (насны бүлгээр)**

Гэмтлийн төрөл	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь	Насны бүлэг		
			7-10	11-14	15-17
Шарх	675	88.1	135	102	438
Зөөлөн эдийн няцралт	38	5.0	-	-	38
Хугаралт	32	4.1	-	-	32
Үений гэмтэл (бяцралт, суналт, мултралт гэх мэт)	8	1.0	4	-	4
Түлэгдэлт	7	0.9	-	7	-
Тархины гэмтэл	7	0.9	-	-	7
<b>Нийт</b>	<b>767</b>	<b>100.0</b>	<b>139</b>	<b>109</b>	<b>519</b>

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЧӨЛӨӨТ ЦАГ**

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 68 орчим хувьд нь долоо хоногт зав, чөлөөтэй өдөр гардаг байна. Тэдгээр хүүхдүүдийн 77 хувь нь чөлөөт цагаа гэртээ; 14 хувь нь сүмд; 4 хувь нь төлбөртэй болон төлбөргүй тоглоомын газарт; 4 хувь нь найзуудынхаа гэрт; нэг хүрэхгүй хувь нь гудамжинд тус тус өнгөрүүлдэг байна.

**Хүснэгт 51 Хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрүүлдэг газар<sup>53</sup> (насны бүлгээр)**

Чөлөөт цагаа өнгөрүүлдэг газар	Хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь	Насын бүлэг					
			7-10		11-14		15-17	
			Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Гэртээ	2438	77.1	7	3.7	1686	89.8	745	67.7
Сүмд очдог	405	12.6	135	72.2	135	7.2	135	12.3
Найзуудынхаа гэрт	128	4.1	45	24.1	-	-	83	7.5
Төлбөргүй тоглоомын газар <sup>54</sup>	91	2.9	-	-	-	-	91	8.3
Төлбөртэй тоглоомын газар <sup>55</sup>	41	1.3	-	-	-	-	41	3.7
Гудамжинд	63	2.0	-	-	57	3.0	6	0.5
<b>Нийт</b>	<b>3166</b>	<b>100.0</b>	<b>187</b>	<b>100.0</b>	<b>1878</b>	<b>100.0</b>	<b>1101</b>	<b>100.0</b>

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн дунд чөлөөт цагаа сүмд<sup>56</sup> өнгөрүүлдэг хүүхдүүдийн тоо (нийт хүүхдүүдийн 8.3 %; чөлөөт цагтай хүүхдүүдийн 12.8 %) харьцангуй олон байгаа нь анхаарал татаж байгаа юм. Үнэ төлбөргүй хооллох, харьцангуй тайван орчинд байх боломж, өөрсдийг нь сонсох хүн сүмд байдаг зэрэг шашны байгууллагын хандлага, үзүүлж буй үйлчилгээнүүд хүүхдүүдийн сүмд очиж чөлөөт цагаа өнгөрүүлэхэд нөлөөлдөг байна.

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 8 орчим хувь нь тогтмол болон тогтмол бусаар тамхи татдаг байна. Эцэг эхийн хараа хяналт сул (хүүхдүүд эцэг эхийн шууд хяналтгүйгээр удаан хугацааг өнгөрөөдөг), хүүхдийн хөдөлмөр эрхлэж буй орчны нөлөөлөл, хүүхдүүдийн сэтгэл зүй (тамхи татах нь биеэ даасан байдлын илэрхийлэл гэх мэт) зэрэг шалтгаанууд хүүхдүүдийн дунд тамхи татах явдал газар авч байгаад нөлөөлдөг байна.

Энэхүү судалгаагаар албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 5 орчим хувь нь согтууруулах ундаа хэрэглэж үзсэн, хэрэглэдэг гэж гарсан боловч согтууруулах ундаа хэрэглэж үзсэн гэнэ.

Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн дунд мансууруулах бодис (цавуу, тайвшруулах үйлчилгээтэй эм болон эмийн бэлдмэл, олс өвс) хэрэглэж үзсэн хүүхдүүд (20 гаруй хүүхэд) судалгааны явцад илэрсэн нь урьд өмнө нь Монголд төдийлөн дэлгэрээгүй байсан мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдэх эрсдэл ихсэж байгааг харуулж байна.

<sup>53</sup> 1724 буюу нийт хүүхдийн 35.3 хувьд нь зав, чөлөөтэй цаг гардаггүй

<sup>54</sup> Тоглоомын талбай

<sup>55</sup> РС тоглоомын газар

<sup>56</sup> Гол төлөв загалмайтны шашны сүм

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГОСОН АЙМГИЙН ТӨВ, СУМДЫН АЛБАН БУС ХЭВШИЛ ДЭХ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР**

### **СОНГОСОН АЙМГИЙН ТӨВ, СУМДЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД<sup>57</sup>**

Энэхүү судалгаанд Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хархорин Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Алтанбулаг, Мандал, Дархан-Уул аймгийн Дархан, Дорнод аймгийн Хэрлэн, Чойбалсан, Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд сумд тус тус хамрагдсан.

#### **Өвөрхангай аймгийн Арвайхээр сум**

2005 оны байдлаар Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд 23.8 мянган хүн оршин сууж байна. Тус суманд хөдөлмөрийн насны (16-64 насны) 3.0 мянган хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа бөгөөд тэдний 730 нь Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүд байна. Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй 1086 хүн байна. Тус сумын иргэд Уянга, Бат-Өлзий сумдад байрлах алтны уурхайд очиж гар аргаар алт олборлох явдал өргөнөөр дэлгэрсэн.

#### **Өвөрхангай аймгийн Хархорин сум**

Өвөрхангай аймгийн Хархорин сумын суурин хүн амын тоо 2005 оны байдлаар 13.0 мянгад хүрч өмнөх онтой харьцуулахад 3.2 хувиар өсчээ. Сумын төв нь "Вангийн овоо", "Ганган орхон", "Эрдэнэ толгой" гэсэн гурван багтай бөгөөд сумын төвд 2.2 мянган өрхөд 8.6 мянган хүн оршин сууж байна. 2005 оны эцсийн байдлаар тус сумын хэмжээнд төрийн, төсөвт байгууллага 13, улсын үйлдвэрийн газар дөрөв, бусад аж ахуйн нэгж, байгууллага 53 нийт 70 гаруй аж ахуйн нэгж, байгууллагад 3.7 мянган хүн хөдөлмөр эрхлэж байна. Ажлын байр идэвхтэй эрж, хайж байгаа бүртгэлтэй ажилгүйчүүд 0.5 мянга байна.

#### **Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум**

2005 оны байдлаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд 19.2 мянган хүн оршин суудаг байна. Тус суманд хөдөлмөрийн насны 2.1 мянган хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа бөгөөд тэдний 293 нь Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүд байна. Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй 799 хүн байна.

#### **Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум**

2005 оны байдлаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 1051 өрхийн 3783 хүн оршин суудаг бөгөөд, нэг өрхөд 3.4 хүн ногдож байна. Нийт хүн амын 29.1 хувь нь 7-18 насныхан байна.

Тус суманд 2005 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай 172 хүн хөдөлмөр эрхлэдэггүйгээс 99 нь Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн байна. Алтанбулаг сумын төв нь ОХУ-тай хил залгадаг бөгөөд Алтанбулагийн боомтоор тус сумын иргэд хил орчим арилжаа наймаа өргөнөөр эрхлэдэг байна.

Сумын нутаг дэвсгэрт мод бэлтгэх, мод боловсруулах үйл ажиллагаа өргөн дэлгэрч байсан боловч эрх зүйн орчинд өөрчлөлт орсоны улмаас иргэдийн эрхлэдэг тус бизнес нь тодорхой хэмжээнд хязгаарлагдах болсон. Тус сумын иргэд төмс, хүнсний ногоо тарьж өрхийн хэрэгцээгээ хангахын зэрэгцээ борлуулах явдал мөн дэлгэрсэн байна.

---

<sup>57</sup> УСГ-ын мэдээнээс, 2006

### **Сэлэнгэ аймгийн Мандал сум**

2005 оны байдлаар Сэлэнгэ аймгийн Мандал суманд 5424 өрхийн 22.8 мянган хүн оршин суудаг бөгөөд, нэг өрхөд 4.2 хүн ногдож байна. Нийт хүн амын 27.2 хувь нь 7-18 насныхан байна. Тус суманд хөдөлмөрийн насны 4.5 мянган хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа бөгөөд тэдний 83 нь Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй байна.

Тус суманд газар тариалан (улаан буудай, төмс, хүнсний ногоо), эрчимжсэн мал аж ахуй хөгжсөний зэрэгцээ мод боловсруулах салбар сүүлийн жилүүдэд сэргэх болсон.

### **Дархан-Уул аймгийн Дархан хот**

Дархан-Уул аймаг нь засаг захиргааны хувьд 4 сум, 24 багт хуваагддаг бөгөөд 2005 оны жилийн эцсийн байдлаар тус аймагт 19.6 мянган өрхийн 87.8 хүн ам амьдарч байна.

Дархан-Уул аймаг нь 3.3 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй Монгол Улсын нийт газар нутгийн 0.2 хувийг эзэлдэг хирнээ хүн амын нягтралаараа Улаанбаатар хот, Орхон аймгийн дараа ордог томоохон аймгуудын нэг юм. 2004 оны байдлаар Дархан-Уул аймагт нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 26.60 хүн ногдож байна. Нэг өрхөд ногдох хүний тоо улсын дунджаар 4.2 байхад Дархан-Уул аймагт 4.5 хүн ноогдож байна. Хүн амын насны бүлгийг 2004 байдлаар оны авч үзэхэд 27.5 хувийг 15 хүртэл насны хүүхэд, 69.3 хувийг 15-64 насныхан, 3.3 хувийг 65 ба түүнээс дээш насныхан эзэлж байна. Хүн амын хүйсийн харьцаа нь 100 эмэгтэйд 90.5 эрэгтэй ногдож, хүн ам зүйн ачаалал 44.3 байна. 2004 оны байдлаар Дархан-Уул аймагт ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин 2003 оныхоос 3.5 хувиар буурсан байна. 2004 оны байдлаар 15 мянган хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа бөгөөд тэдний 0.9 мянга нь Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй байсан.

2004 оны эцсийн байдлаар 1396 хуулийн этгээд аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэний 664 буюу 47.6 хувь нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Дархан-Уул аймгийн төв болох Дархан суманд 15.7 мянган өрхийн 77.3 мянган хүн оршин суудаг бөгөөд сүүлийн жилүүдэд Дархан хот руу бусад аймгаас шилжин ирэгсэдийн тоо эрс нэмэгдэж байна. Тус сумын нийт хүн амын 27.1 хувийг 7-18 насныхан эзэлж байна.

### **Дорнод аймгийн Хэрлэн сум**

2005 оны байдлаар Дорнод аймгийн төв Хэрлэн суманд 40.7 мянган хүн оршин суудаг. Тус суманд хөдөлмөрийн насны 11.3 мянган хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа бөгөөд тэдний 550 нь Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүд байна. Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй 1920 хүн байна. Чойбалсан хотод үйл ажиллагаа явуулж байсан олон тооны үйлдвэр, аж ахуйн газрууд зах зээлийн өрсөлдөөний улмаас дампуурч, үйл ажиллагаа нь зогссон нь тус сумын амьжиргааны түвшин доогуур байгаад шууд нөлөөлсөн байна.

### **Дорнод аймгийн Чойбалсан сум**

2005 оны байдлаар Дорнод аймгийн Чойбалсан суманд 2.8 мянган хүн оршин суудаг байна. Мөн хугацаанд тус суманд хөдөлмөрийн насны 926 хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа бөгөөд тэдний 11 нь Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүд байна. Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй 142 хүн байна.

Тус сумын нутаг дэвсгэрт байрлах Хавиргын боомтоор БНХАУ-тай арилжаа наймаа өргөнөөр хийгддэг байна. Төмөр экспортлоход хориг тавихаас өмнө тус боомтоор өдөрт 200-300 автомашин

өнгөрдөг байсан бөгөөд үүнтэй уялдаад Хавиргын боомтын зэргэлдээ хотхон үүссэн байсан боловч төмрийн экспортонд хориг тавьсанаас хойш тус боомтоор өдөрт 20-30 автомашин өнгөрдөг болж Хавирга боомтын орчинд эдийн засгийн идэвх эрс буурсан.

#### **Дорноговь аймгийн Сайншанд сум**

Дорноговь аймгийн Сайншанд сумын суурин хүн амын тоо сүүлийн жилүүдэд байнга өсч ирсэн боловч 2005 онд 18.3 мянгад хүрч 2004 онтой харьцуулахад 2.2 хувиар буурсан байна. Суурин хүн амын тоо буурсантай холбогдон ажил эрхлэгчдийн тоо буурч аймгийн төвийн эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо цөөрчээ. Аймгийн төвийн хэмжээнд хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүний дөнгөж 7 орчим хувь нь л аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст ирж ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байна гэж бүртгүүлсэн байна. Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдээр тооцсон ажилгүйдлийн түвшин 2005 онд 5.6 хувьтай байна.

#### **Дорноговь аймгийн Замын-Үүд сум**

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын суурин хүн амын тоо сүүлийн жилүүдэд байнга өсч ирсэн бөгөөд 2005 оны байдлаар 8.4 мянгад хүрч 2001 оныхоос 33.3 хувь, харин 2004 оноос 7.7 хувиар тус тус өссөн байна. Сумын эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 2005 оны байдлаар 3.5 болж, өмнөх онтой харьцуулахад 16.7 хувиар өсчээ. Сумын хэмжээгээр хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй 1000 гаруй хүн байдаг боловч тэднээс ажил идэвхтэй хайж сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтанд бүртгүүлсэн ажилгүй хүний тоо сумын хэмжээнд ойролцоогоор 20 хүн л байдаг юм байна.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ТОО

Судалгаанд хамрагдсан аймгийн төв, сумдаас судалгааны багийнхан урьдчилан бэлтгэсэн аргачлалын дагуу ("Хоёрдугаар бүлэг. Судалгааны арга зүй"-д танилцуулсан) судалгааны тархаалтанд шаардагдах мэдээллийг цуглуулан тус мэдээллийг үндэслэн тархаалтын аргачлалыг ашиглан сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй 7-17 насны хүүхдийн тоог (2005 оны дөрөвдүгээр улирлын байдлаар) тооцоолсон.

Урьдчилан бэлтгэсэн аргачлалын дагуу сонгож энэхүү судалгаанд хамруулсан хүүхдийн тоо харьцангуй цөөн байсан нь судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн өөрийн оршин сууж буй аймгийн төв, сумдад албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдүүдийг төлөөлөх чадварыг тодорхой хэмжээгээр буруулж байгааг дурьдах нь зүйтэй болно.

### Хүснэгт 52 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн тоо (сумаар)

Аймаг	Сум	7-17 насны хүүхдийн тоо <sup>58</sup>	Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй 7-17 насны хүүхдийн тоо	Албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн эзлэх хувийн жин
Өвөрхангай	Арвайхээр	6291	210	3.3
	Хархорин	3264	60	1.9
Сэлэнгэ	Сүхбаатар	4634	0 <sup>59</sup>	-
	Алтанбулаг	945	30	3.2
	Мандал	5582	50	0.9
Дархан-Уул	Дархан	18380	440	2.4
Дорнод	Хэрлэн	10268	720	7.0
	Чойбалсан	758	0 <sup>60</sup>	-
Дорноговь	Сайншанд	4540	110	2.4
	Замын-Үүд	2069	15	0.7

Энэхүү судалгааны тархаалтаар сонгосон аймаг, сумын төвд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн тоо, тэдний эрхлэж буй хөдөлмөрийн талаар ямар нэгэн дүн шинжилгээ, дүгнэлт хийхэд дараах нөхцөл байдал, онцлогуудыг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд:

- Энэхүү судалгаанд зөвхөн албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хувьд тархаалт хийгдсэн;
- Хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд энэхүү судалгаанд хамрагдаагүй;
- Уул уурхайн салбарт хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд хамрагдаагүй;
- Хурдны морь унадаг хүүхдүүд энэхүү судалгаанд хамрагдаагүй;
- Биеэ үнэлдэг хүүхдүүд энэхүү судалгаанд хамрагдаагүй;
- Тогтмол бус (улирлын чанартай) хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд энэхүү судалгаанд хамрагдаагүй болно.

<sup>58</sup> ҮСГ-ын мэдээгээр, 2005

<sup>59</sup> Судалгааны мэдээллийг цуглуулах явцад Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар суманд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй 7-17 насны хүүхдүүд илрээгүй. Тус сумын албан бус хэвшилд тогтмол хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүд илрээгүй хэдийч тус суманд оршин суудаг хүүхдүүд зун, намар байгалийн түүхий эд (самар, жимс) бие даан мөн өөрийн эцэг эхийн хамт цаашид борлуулах зорилгоор түүдэг явдал өргөнөөр дэлгэрсэн. Мөн хүүхдүүд хавар, намар хөлстэйгөөр төмс, хүнсний ногоо тарих, хураах үйл ажилд өргөнөөр оролцдог байна.

<sup>60</sup> Чойбалсан сумын Хавиргын боомт байрладаг баг судалгаанд хамрагдахаар судалгааны ажлын даалгаварт заасан байсан боловч 2005 оны 9-р сарын байдлаар Хавиргын боомтын орчимд ямар нэгэн эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явагдаагүй байсан бөгөөд Хавиргын боомтын орчин тойронд хүүхэд хөдөлмөр эрхлэж буй явдал илрээгүй.



## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДИЙН НАС, ХҮЙС

Сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хүйсийн харьцааг харахад охидын эзлэх хувь Улаанбаатар хотод хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хүйсийн харьцаатай харьцуулахад харьцангуй өндөр байна.

### Хүснэгт 53 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн хүйс (сумаар)

Сум	Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн тоо	Хүйс			
		Хөвгүүд		Охид	
		Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Арвайхээр	210	63	30.0	147	70.0
Хархорин	60	40	73.3	20	26.7
Сүхбаатар	-	-	-	-	-
Алтанбулаг	30	6	20.0	24	80.0
Мандал	50	39	76.0	11	24.0
Дархан	440	176	40.0	264	60.0
Хэрлэн	720	512	71.1	208	28.9
Сайншанд	110	-	-	110	100.0
Замын-Үүд	15	8	53.3	7	46.7

### Хүснэгт 54 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн хүйс, насны бүлгээр (сумаар)

Сум	Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн тоо	Насны бүлэг								
		7-10			11-14			15-17		
		Нийт	Хөвгүүд	Охид	Нийт	Хөвгүүд	Охид	Нийт	Хөвгүүд	Охид
Арвайхээр	210	-	-	-	54	38	16	156	25	131
Хархорин	60	-	-	-	20	10	10	40 <sup>61</sup>	32	8
Сүхбаатар	0	-	-	-	-	-	-	-	-	-
Алтанбулаг	30	10 <sup>62</sup>	-	10	10	2	8	10	4	6
Мандал	50	-	-	-	-	-	-	50 <sup>63</sup>	38	12
Дархан	440	-	-	-	44	-	44	396	176	220
Хэрлэн	720	45	23	22	240	155	85	435	335	100
Сайншанд	110	-	-	-	13	-	13	97	-	97
Замын-Үүд	15	-	-	-	3	-	3	12	8	5

Сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн дунд 15-аас дээш насны хүүхдүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байна. Хөдөө орон нутагт хүүхдүүдийн суурь боловсрол эзэмшсэнийхээ дараа үргэлжлүүлэн суралцах боломж хязгаарлагдмал байгаа нь 8-р анги<sup>64</sup> төгссөн хүүхдүүд хөдөлмөрийн харилцаанд орж байгаад нөлөөлөх хүчин зүйлийн нэг болж байна. Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 20 хувийг суурь боловсрол эзэмшсэн үргэлжлүүлэн суралцаагүй хүүхдүүд эзэлж байна.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДИЙН АМЬДРАЛЫН НӨХЦӨЛ

### Өрхийн сууц

Сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өрх тухайн орон нутгийн онцлогоос хамааран сууцны тусдаа байшин, гэрт оршин суудаг байна<sup>65</sup>. Аймгийн төв, сумдад гэрт амьдардаг өрхийн гэрийн дийлэнх олон нь давхар бүрээстэй, шалтай байгаа нь хөдөө орон нутагт оршин сууж буй өрхүүд харьцангуй тогтвор суурьшилтай байгаатай холбоотой юм.

<sup>61</sup> Хархорин суманд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа нийт хүүхдийн 50 нь буюу 62 орчим хувь нь 16-17 насны хүүхдүүд байна

<sup>62</sup> Өрхийн төмс, хүнсний ногооны талбайд хөлсгүйгээр хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүд

<sup>63</sup> Хөдөлмөр эрхлэж буй 7-15 насны хүүхэд судалгааны явцад илрээгүй

<sup>64</sup> 2005-2006 оны хичээлийн жилээс 9-р анги

<sup>65</sup> Аймаг, сумын төвд оршин сууж буй өрхүүдийн хувьд тэдний орон сууцны байдал нь өрхийн амьжиргааны түвшинг тодруулах үзүүлэлт болдоггүйг анхаарах шаардлагатай.

**Хүснэгт 55 Хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдийн өрхийн сууцны байдал (хувь, сумаар)**

Сум	Орон сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн байр	Гэр	Орц, хонгил	Урц, овоохой	Нийт
Арвайхээр	-	9	-	91	-	-	100
Хархорин	-	37	-	63	-	-	100
Сүхбаатар	-	-	-	-	-	-	-
Алтанбулаг	-	87	-	-	-	13 <sup>66</sup>	100
Мандал	-	58	36	6	-	-	100
Дархан	-	70 <sup>67</sup>	-	30	-	-	100
Хэрлэн	24	29	19	19	9 <sup>68</sup>	-	100
Сайншанд	13	83	4	-	-	-	100
Замын-Үүд	-	20	-	80	-	-	100

Сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн дийлэнх нь өөрийн гэрт, эцэг эх/асран хамгаалагчийн хамт амьдардаг байна. Цөөн тооны хүүхдүүд эцэг эхийнхээ эсвэл өрхийн гишүүнийхээ хамт гэр ахуйн модон эдлэл хийх, барилга дээр ажиллаж ажил олгогчийнхоо гэрт амьдарч байна байв.

**Хүснэгт 56 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн амьдардаг орчин (хувь, сумаар)**

Сум	Ажил олгогчийн гэрт	Өөрийн гэрт	Хамаатан садныдаа	Бие даан (ганцаараа)	Нийт
Арвайхээр	-	100	-	-	100
Хархорин	19 <sup>69</sup>	75	6	-	100
Сүхбаатар	-	-	-	-	-
Алтанбулаг	-	100	-	-	100
Мандал	18 <sup>70</sup>	76	6	-	100
Дархан	-	100	-	-	100
Хэрлэн	-	94	-	6	100
Сайншанд	-	100	-	-	100
Замын-Үүд	-	100	-	-	100

Сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн дунд эцэг эхийнхээ аль нэгтэй нь (бүрэн бус өрхөд) амьдарч байгаа хүүхдүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байна. Нийт хүүхдүүдийн 35 орчим хувь нь бүрэн бус өрхөд амьдардаг байв.

Хөдөө орон нутагт оршин сууж буй иргэд өрхийн хүнсний хэрэгцээнд өрхийн туслах аж ахуйн үр шимийг<sup>71</sup> (мах, төмс, хүнсний ногоо<sup>72</sup>, цагаан идээ) хэрэглэх явдал өргөн дэлгэрсэн боловч сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өрхийн зарлагын бүтцийг харахад тус өрхүүд хүнсний хэрэгцээндээ зарцуулж буй зарлагын мөнгөн дүн нь нийт зарцуулалтын талаас илүүг эзэлж байгаа юм.

Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өрхийн амьжиргааны түвшинг шууд бусаар тодруулж болох бас нэгэн үзүүлэлт бол хүүхэд өдөр болгон халуун хоолтой байдаг эсэх юм.

**Хүснэгт 57 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн халуун хоол өдөр болгон иддэг байдал<sup>73</sup>(хувь, сумаар)**

Сум	Халуун хоол өдөр бүр иддэг	Халуун хоол өдөр бүр иддэггүй	Нийт
Арвайхээр	100	-	100
Хархорин	100	-	100
Сүхбаатар	-	-	-
Алтанбулаг	88	12	100
Мандал	94	6	100
Дархан	90	10	100
Хэрлэн	100	-	100
Сайншанд	97	3	100
Замын-Үүд	100	-	100

<sup>66</sup> Мод борлуулах эрх зүйн орчинд өөрчлөлт орсны дараа тус өрхүүд өөрийн өмчийн модон байшинг борлуулж урц овоохойд амьдрах болсон

<sup>67</sup> Модны үнэ харьцангуй хямд тул иргэд сууцны тусдаа байшин олноор барьсан

<sup>68</sup> Орон сууцанд ашиглах боломжгүй барилгын балгасанд амьдардаг

<sup>69</sup> Барилга барьж буй хүүхдүүд ажлын байрандаа байрлан амьдардаг

<sup>70</sup> Барилга (балка, дүнзэн байшин) барьж буй хүүхдүүд ажлын байрандаа байрлан амьдардаг

<sup>71</sup> Туслах аж ахуйн үр шимийг иргэд өрхийн орлого гэж тооцдоггүй

<sup>72</sup> Сэлэнгэ аймгийн сумууд, Дархан хотод оршин суудаг өрхүүдийн олонх нь өрхийн туслах аж ахуй эрхлэдэг бөгөөд тэд төмс, хүнсний ногоо өргөнөөр тарьдаг

<sup>73</sup> Сүүлийн долоо хоногийн байдлаар

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өрх хүйтний улиралд түлшиндээ тухайн орон нутгийн онцлогоос хамааран нүүрс, мод, аргал зэргийг ашигладаг байна.

Сонгогдсон аймгийн төв, сумдын<sup>74</sup> албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өрхийн 89 хувь нь төвийн цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон, 11 хувь нь цахилгаан эрчим хүч ашигладаггүй байна. Тухайн өрхүүд цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдсон/холбогдох боломжтой боловч цахилгааны төлбөрөө цаг хугацаанд нь барагдуулдаггүй тул цахилгаанаа таслуулсан байлаа.

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өрхийн ундны усны эх үүсвэрийг Хүснэгт 58-д үзүүлэв.

**Хүснэгт 58 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өрхийн ундны усны эх үүсвэр (хувь, сумаар)**

Сум	Төвлөрсөн халуун, хүйтэн усны шугам	Төвлөрсөн хүйтэн усны шугам	Зөөврийн ус	Гүний худаг	Энгийн худаг	Гол, булаг	Нийт
Арвайхээр	-	-	-	97	3	-	100
Хархорин	-	-	-	87	13	-	100
Сүхбаатар	-	-	-	-	-	-	-
Алтанбулаг	-	-	-	25	75	-	100
Мандал	-	-	-	41	59	-	100
Дархан	-	-	20	-	80	-	100
Хэрлэн	27	10	9	-	54	-	100
Сайншанд	13	-	87	-	-	-	100
Замын-Үүд	-	-	80	-	20	-	100

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭЦЭГ ЭХ

Сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өрхийн сарын дундаж орлогын ихэнх нь тогтвортой бус (тогтмол бус бизнесийн үйл ажиллагааны орлого, бусад мөнгөн эх үүсвэр гэх мэт) эх үүсвэрээс бүрддэг байна. Тухайн өрхүүдийн хувьд өрхийн аль нэгэн гишүүний авч буй өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмж, "хүүхдийн мөнгө" зэрэг төрийн нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд авч буй тэтгэвэр, тэтгэмж өрхийн орлогын тогтвортой эх үүсвэр болдог байна.

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг эхийн боловсролын түвшинг Хүснэгт 59,60-д үзүүлэв.

**Хүснэгт 59 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцгийн боловсролын түвшин (хувь, сумаар)**

Сум	Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд	Бүрэн бус дунд	Бага	Боловсролгүй	Нийт
Арвайхээр	-	-	57	43	-	-	-	100
Хархорин	17	-	33	33	17	-	-	100
Сүхбаатар	-	-	-	-	-	-	-	-
Алтанбулаг	-	-	50	-	-	-	50	100
Мандал	-	-	-	-	67	33	-	100
Дархан	-	-	-	75	-	25	-	100
Хэрлэн	-	-	-	13	63	12	12	100
Сайншанд	-	-	-	50	-	50	-	100
Замын-Үүд	-	17	-	51	15	17	-	100

**Хүснэгт 60 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эхийн боловсролын түвшин (хувь, сумаар)**

Сум	Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд	Бүрэн бус дунд	Бага	Боловсролгүй	Нийт
Арвайхээр	-	20	20	40	20	-	-	100
Хархорин	14	-	43	14	29	-	-	100
Сүхбаатар	-	-	-	-	-	-	-	-
Алтанбулаг	-	16	-	17	50	-	17	100
Мандал	-	-	-	-	75	-	25	100
Дархан	-	14	-	43	29	14	-	100
Хэрлэн	-	8	-	39	39	14	-	100
Сайншанд	34	-	-	33	-	33	-	100
Замын-Үүд	-	-	34	33	33	-	-	100

<sup>74</sup> Бүх сумууд төвийн эрчим хүч түгээх сүлжээнд холбогдсон

Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг эхийн боловсролын түвшин харьцангуй доогуур байгаа нь тэдний хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг хязгаарладаг гол хүчин зүйл болдог бөгөөд энэхүү хязгаарлагдмал өрсөлдөх чадвар нь тухайн өрхийн орлогын түвшин доогуур, санхүүгийн тогтворгүй байдлыг үүсгэдэг байна. Энэ нь эцсийн дүндээ хүүхдийн хөдөлмөрөөс олж буй орлого өрхийн санхүүгийн байдалд нөлөөлөх нөхцөл эрсдэлтэй юм.

Сонгосон аймгийн төв, сумдын хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг эх/асран хамгаалагчийн дунд Хөдөлмөрийн хуулийн дагуу хөдөлмөрийн гэрээгээр хөдөлмөр эрхлэж буй хүний эзлэх хувь харьцангуй бага байгаа нь албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн өрхийн санхүүгийн байдал тогтвортой бус байгаагийн бас нэгэн баталгаа болж байгаа юм.

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй эцэгтэй хүүхдүүдийн хөдөлмөрийн насны эцгүүдийн 34 орчим хувь, эхчүүдийн 37 гаруй хувь нь хөдөлмөр эрхлээгүй байна. Энэхүү байдал нь өрхийн орлогын түвшинд нөлөөж байгаа бөгөөд цаашилбал тухайн нөхцөл байдал нь хүүхэд хөдөлмөр эрхлэхэд хүргэх нэг шалтгаан болдог байна. Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 49 орчим хувь нь “өрхийн орлого нэмэгдүүлэх” зорилгоор хөдөлмөр эрхлэж байна.

**Хүснэгт 61 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн чадвартай эцгийн хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувь, сумаар)**

Сум	Хөдөлмөрийн гэрээгээр	Иргэний гэрээгээр	Ажил олгогч	Хувиараа хөдөлмөр эрхлэдэг	Хөдөлмөр эрхлэдэггүй	Нийт
Арвайхээр	38	-	-	13	49	100
Хархорин	17	-	-	83	-	100
Сүхбаатар	-	-	-	-	-	-
Алтанбулаг	-	-	-	20	80	100
Мандал	-	-	-	30	70	100
Дархан	-	-	-	75	25	100
Хэрлэн	-	-	-	13	87	100
Сайншанд	-	-	-	50	50	100
Замын-Үүд	-	-	-	50	50	100

**Хүснэгт 62 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн чадвартай эхийн хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувь, сумаар)**

Сум	Хөдөлмөрийн гэрээгээр	Иргэний гэрээгээр	Ажил олгогч	Хувиараа хөдөлмөр эрхлэдэг	Хөдөлмөр эрхлэдэггүй	Нийт
Арвайхээр	25	-	-	25	50	100
Хархорин	20	20	-	60	-	100
Сүхбаатар	-	-	-	-	-	-
Алтанбулаг	-	-	-	70	30	100
Мандал	-	-	-	50	50	100
Дархан	-	-	-	71	29	100
Хэрлэн	6	-	-	19	75	100
Сайншанд	-	-	-	67	33	100
Замын-Үүд	-	-	-	66	34	100

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн олонх нь хувиараа хөдөлмөр эрхлэдэг байна. Хүүхдүүдийн эцэг эх гол төлөв жижиглэн худалдаа хийхийн зэрэгцээ тухайн орон нутгийн онцлогоос хамаарч мод бэлтгэх, боловсруулах, гар аргаар алт олборлох ажил эрхлэдэг байна.

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эцэг эх/асран хамгаалагчдын 64 хувь нь хүүхдийнхээ хөдөлмөр эрхлэж байгаад “хүүхэд хөдөлмөрлөж байгаа нь өрхийн орлогод нэмэр болдог”, “хүүхэд хөдөлмөрлөж өөрийн сургалтын зардлаа (хувцас, хичээлийн хэрэгсэл худалдан авах зардал, сургуулиас албан болон албан бус хэлбэрээр цуглуулах мөнгөн болон мөнгөн бус хураамж, хуримтлал гэх мэт) өөрөө санхүүжүүлдэг” зэрэг тайлбартайгаар сэтгэл ханамжтай байдаг байна.

Хүүхдүүдийн эцэг эхийн 70 орчим хувь нь “өрхийн амьжиргаа дээшилбэл хүүхэд хөдөлмөр эрхлэхээ болино” гэж хариулсан боловч тэд өрхийн орлогыг дээшлүүлэх талаар идэвх гаргаагүй/ойрын хугацаанд идэвх гаргах талаар шийдээгүй байна.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ХӨДӨЛМӨРЛӨЖ ЭХЭЛСЭН/ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ШАЛТААН

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэхэд нөлөөлсөн хүчин зүйлсийг Хүснэгт 63-д үзүүлэв.

**Хүснэгт 63 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэхэд нөлөөлсөн гол хүчин зүйлс (хувь, сумаар)**

Сум	Эцэг, эх өртэй байсан	Эцэг, эх өвчтэй, ажил хийх чадваргүй байсан тул	Өрхийн орлогод нэмэр болох	Өрхөд орлого олох өөр хүн байхгүй	Өрхөд өөр орлогын эх үүсвэр байхгүй	Ажлын дарлага, туррлагатай болох	Өөрийгөө авч явах, эдийн засгийн хувианд олох	Сургуульд сурах зардалаа олох	Өөрийн сонирхлоор (санхүүгийн бус шалтгаанаар)	Нийт
Арвайхээр	-	3	87	-	10	-	-	-	-	100
Хархорин	-	-	100	-	-	-	-	-	-	100
Сүхбаатар	-	-	-	-	-	-	-	-	-	-
Алтанбулаг	-	-	50	12	-	-	-	-	38	100
Мандал	-	6	22	-	18	36	-	-	18	100
Дархан	-	11	22	11	-	-	-	45	11	100
Хэрлэн	-	5	55	10	-	5	5	-	20	100
Сайншанд	-	-	25	-	25	-	-	-	50	100
Замын-Үүд	-	25	25	-	-	-	-	50	-	100

Хүүхдүүдийн олонх нь өөрийн өрхийн орлогод нэмэр болох зорилгоор хөдөлмөр эрхлэдэг байна. Өрхийн орлогын түвшин харьцангуй доогуур (өрхийн үндсэн хэрэгцээг бүрэн хангах боломжгүй) нь тухайн өрхийн хүүхэд “өрхийн орлогоо нэмэгдүүлэх” зорилгоор хөдөлмөр эрхлэж эхлэхэд нөлөөлж буй үндсэн шалтгаан болдог байна. Нийт өрхийн 13 орчим хувьд хүүхдийн хөдөлмөрийн хөлс нь тухайн өрхийн хувьд бэлэн мөнгөний цорын ганц эх үүсвэр болж байгаа нь анхаарал татаж байна.

Сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэж байгаад “өөрийн сонирхлоор (санхүүгийн бус шалтгаанаар)” хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байна<sup>75</sup>. Үүнд тус сумдад хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн дунд 8-р анги дүүргэсэн боловч цаашид үргэлжлүүлэн суралцаагүй хүүхдүүдийн эзлэх хувь өндөр байгаа байдал нөлөөлж байна.

Суурь боловсрол эзэмших нь үнэ төлбөргүй байдаг боловч бодит байдал дээр ядуу болон нэн ядуу өрхийн хувьд хүүхдээ ЕБС-д суралцуулах нь шууд (унааны зардал, хувцас, хичээлийн хэрэгсэл, сурах бичиг гэх мэт) болон шууд бус (албан болон албан бус байдлаар сургуулийн удирдлага, багш нарын “ангийн тохижилт”, “бэлэг авах”, “ангийн сан бүрдүүлэх” гэх мэтийн зорилгоор цуглуулж буй хуримтлал) зардлууд гардаг тул бэрхшээлтэй байдаг байдал харагдаж байна. Нийт хүүхдүүдийн 11 орчим хувь нь “сургуульд сурах зардал” олохын тулд хөдөлмөр эрхлэж эхэлсэн/үргэлжлүүлэн эрхлэж байна.

<sup>75</sup> Тус мэдээллийг хүүхдүүдээс авсанд анхаарах шаардлагатай. Хүүхдүүд “өөрийн сонирхлоор” гэж хариулсан боловч тухайн сонирхол үүсэхэд нөлөөлсөн хүчин зүйлийг (өрхийн амьжиргааны түвшин, өрхийн орлого гэх мэт) бодит байдлаар тодорхойлж чадаагүй байх эрсдэлтэй

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн дийлэнх нь өөрийн өрхийн эрхлэж буй эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа тул тэдэнд хэн нэгэн тодорхой байдлаар хөдөлмөр эрхлэхийг санал болгоогүй байна. Тухайн хүүхдүүдийн өрхийн гишүүдийн харьцаа, өрхийн дотоод нөхцөл байдал нь хүүхдийг хөдөлмөрт аажмаар татан оролцуулах нөхцлийг бүрдүүлсэн байна.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДИЙН АЖЛЫН ТӨРӨЛ

Орон нутгийн онцлогоос хамааран сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн төрөл ялгаатай байгаа боловч аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа нийт хүүхдийн 48 гаруй хувь нь жижиглэн худалдаа эрхлэдэг байна. Тус аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн тухайн ажлын төрлийг Хүснэгт 64-д харуулав.

**Хүснэгт 64 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн үндсэн ажлын төрөл (хувь, сумаар)**

Сум	Жижиглэн худалдаа эрхлэх	Мах эвдэх	Ачаа зөөх	Хоёрдогч түүхий эд дуулуулах	Банз зөөх, өрөх	Ногоо, жимс ялгах	Барилга буулгах	Мал аж ахуйн түүхий эд боловсруулах	Барилгын ажил эрхлэх	Тоглоом тоглуулах	Цэвэрлэгээ хийх, автомашин угаах	Аргал, жимс, самар эрэл, байгалийн түүхий эд, түүх	Нийтийн хоолны газар ажиллах	Ойдог жиж	Мод хөрөөдөх, жиглэх	Нийт
Арвайхээр	58.5	-	-	8.5	3.2	9.6	-	-	3.2	-	-	-	-	-	8.5	100.0
Хархорин	25.0	-	12.5	12.5	-	12.5	-	-	12.5	-	-	-	-	-	25.0	100.0
Сүхбаатар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	100.0
Алтанбулаг	9.4	-	-	-	9.4	40.6	-	-	-	-	40.6	-	-	-	-	100.0
Мандал	17.9	17.9	-	-	-	-	-	23.1	-	-	-	5.1	-	-	35.9	100.0
Дархан	55.7	-	-	-	10.5	-	-	-	11.3	-	-	-	11.3	11.3	-	100.0
Хэрлэн	39.1	9.0	-	-	21.5	-	5.1	3.2	9.2	2.1	6.3	-	-	-	-	100.0
Сайншанд	50.0	-	27.3	-	-	-	-	-	-	-	-	-	22.7	-	-	100.0
Замын-Үүд	50.0	-	50.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	100.0

Хархорин, Сүхбаатар, Алтанбулаг, Дархан, Мандал сумдад оршин суудаг хүүхдүүд зун, намар байгалийн түүхий эд (самар, жимс) бие даан болон өөрийн эцэг эхийн хамт цаашид борлуулах зорилгоор түүдэг боловч энэхүү ажил нь улирлын чанартай, тогтмол бус байдаг байна. Мөн хүүхдүүд хавар, намар төмс, хүнсний ногоо тарих, хураах ажилд оролцох явдал өргөнөөр дэлгэрсэн байна.

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд өөрийн эрхлэж буй үндсэн ажлаасаа гадна нэмэлт (давхар) ажил тэр болгон хийдэггүй байна. Энэ нь хүүхдүүд гол төлөв өрхийн эрхлэж буй бизнест оролцдогтой холбоотой юм. Хүүхдүүд бие даан хөдөлмөр эрхлэж буй тохиолдолд ажлын байр, хөдөлмөрийн төрлөө сонгох боломж харьцангуй их байдаг бөгөөд тэд нэг ажлын байрандаа тогтвортой ажиллах магадлал буурдаг байна.

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд бие даан хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд гол төлөв дараах төрлийн хөдөлмөр эрхлэдэг байна: жижиглэн худалдаа (гар дээрээс хүнсний болон бусад жижиг оврын бараа зах, гудамж, төмөр замын өртөө зэрэг хүн олноор төвлөрсөн газар борлуулах). Бие даан хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн орлого тус хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагааны идэвхээс шууд хамааралтай байдаг бөгөөд тэд хөдөлмөр эрхлэж буй нөхцөлд өдөр болгон тодорхой хэмжээний орлоготой байдаг байна. Мөн тэдний ажлын цаг төдийлөн

Дорнод аймгийн Сүмбэр суманд 14 настай хүү дэлбэрэлтэнд өртөн амиа алджээ. Талийгаач хүү энэ сарын 8 нд хээрээс олдсон их бууны сум олж хаягдал төмөр авдаг хүмүүст хошууг нь салгаж, тушаах гэж байгаад ийнхүү амиа алдахад хүрсэн байна. Ж..... гэдэг 14 настай энэ хүү ээж дүүгийнхээ хамт амьдардаг байжээ. Дорнод аймагт Халх голын дайнаас үлдэж хоцорсон их бууны сум, бөмбөг одоо ч олон олддог. Харийн дайснаас эх орноо эрэлхэгээр хамгаалж байх үедээ хэрэглэж байсан дайны хүйтэн зэвсгийн үлдэгдэл өнөөдөр эгэл жирийн хүүгийн алтан аминд харамсалтайгаар хүрчээ.

**“Өнөөдөр” сонин, 2005 оны 10 сарын 11 өдрийн дугаараас**

тогтвортой бус байдаг бөгөөд тэд тодорхой хэмжээний орлого тухайн өдөрт олсон бол гол төлөв тухайн өдөр үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлэдэггүй байна..

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөлстэй хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд өөрийн оршин сууж буй орон нутгийн онцлогоос шалтгаалан дараах төрлийн хөдөлмөр гол төлөв эрхлэдэг байна: модоор барилга барих, нийтийн хоолны газар туслах ажил хийх, мах эвдэх гэх мэт. Хөлстэйгээр хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд хөдөлмөрийн хөлсөө бэлэн мөнгөөр авдаг бөгөөд ажил олгогчид хүүхдүүдэд тохирсон хөдөлмөрийн хөлсөө хугацаанд нь өгөхгүй "унжих", удаах явдал төдийлөн өргөнөөр дэлгэрээгүй байв. Хөлстэйгээр хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүд өдөрт дунджаар 6-8 цаг ажилладаг байна.

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдүүдийн 51 хувь нь өрхийн эрхлэж буй бизнест хөлсгүйгээр хөдөлмөр эрхлэдэг байна. Тэдэнд эцэг эх (асран хамгаалагч) эсвэл тухайн бизнесийг удирдан эрхлэдэг хамаатан садан тогтмол бусаар тодорхой хэмжээний мөнгөн болон мөнгөн бус хэлбэрийн урамшуулал өгдөг боловч тухайн урамшууллыг хүүхдийн хөдөлмөрийн хөлс гэж үзэж болохгүй юм.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН АЖЛЫН БАЙР

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн ажлын байрны байршлыг Хүснэгт 65-д харуулав.

**Хүснэгт 65 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны байршил (хувь, сумаар)**

Сум	Хүнсний болон барааны зах	Төмөр замын өртөө	Тогтвортой бус (гудамж талбайд)	Дэлгүүр, ТҮЦ, агуулах	Хогийн цэг	Үйлдвэрийн газар	Ажил олгогчийн гэрт	Нийтийн хоолны газар	Барилга	ШТС	Нийт
Арвайхээр	12	-	3	6	3	8	26 <sup>76</sup>	-	-	42 <sup>77</sup>	100
Хархорин	38	-	7	-	-	-	37 <sup>78</sup>	-	18	-	100
Сүхбаатар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Алтанбулаг	-	-	46 <sup>79</sup>	12	-	-	42 <sup>80</sup>	-	-	-	100
Мандал	36	6	-	-	-	6 <sup>81</sup>	52	-	-	-	100
Дархан	100	-	-	-	-	-	-	-	-	-	100
Хэрлэн	55	-	14	6	10 <sup>82</sup>	5	10	-	-	-	100
Сайншанд	82	-	-	13	5 <sup>83</sup>	-	-	-	-	-	100
Замын-Үүд	-	100	-	-	-	-	-	-	-	-	100

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн олонхийнх нь ажлын байр тухайн аймаг, сумын төвийн хүнсний болон барааны зах, захын ойролцоо эдийн засгийн үйл ажиллагаа төвлөрсөн газар байрладаг байна. Хүнсний болон барааны захууд дээр хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд гол төлөв дараах төрлийн ажлыг хийдэг байна:

- Жижиглэн худалдаа эрхлэх (эцэг эх/асран хамгаалагчийнхаа эрхлэдэг лангуун дээр ажиллах, бие даан гар дээрээс хүнсний болон бусад жижиглэнгийн бараа зарах);
- Цэвэрлэгээ хийх;
- Нийтийн хоолны газар туслах ажил эрхлэх.

<sup>76</sup> Ажил олгогчийн гэр болон эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй газар нь нэг дор байрладаг (гэр хороололд байрлах мужааны цех гэх мэт)

<sup>77</sup> ШТС-ын ойр орчимд шатахуун авч буй жолооч, зорчигч нарт халуун хоол, гар дээрээс худалдаалах боломжтой хүнсний болон бусад бараа зардаг

<sup>78</sup> Ажил олгогчийн гэр болон эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй газар нь нэг дор байрладаг (гэр хороололд байрлах мужааны цех гэх мэт)

<sup>79</sup> Гар дээрээс хүнсний болон бусад бараа борлуулдаг

<sup>80</sup> Ажил олгогчийн гэр болон эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй газар нь нэг дор байрладаг (гэр хороололд байрлах мод боловсруулах бага оврын үйлдвэр гэх мэт)

<sup>81</sup> Мод боловсруулах үйлдвэр

<sup>82</sup> Хогийн цэг ба барилгын балгас

<sup>83</sup> Орон сууцны хорооллын хогийн цэг, гудамж талбайгаас хоёрдогч түүхий эд цуглуулдаг

Төмөр замтай аймгийн төв, сумдын (Мандал, Дархан, Замын-Үүд, Сайншанд) хүүхдүүд төмөр замын өртөөн дээр жижиглэн худалдаа эрхлэх, ачаа зөөх зэргийн хөдөлмөр эрхлэх явдал өргөнөөр дэлгэрсэн байна.

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БҮЙ ХҮҮХДҮҮДИЙН АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ

Сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны нөхцөлд дүн шинжилгээ хийхэд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн дийлэнх нь "хэт их халуун, хүйтэн, дуу чимээ ихтэй, доргилттой газар", "хэт их тоосжилт, чийгтэй" ажлын байранд хөдөлмөр эрхлэдэг байна.

**Хүснэгт 66 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны нөхцөл (тухайн суманд хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдийн дүнд эзлэх хувиар, давхардсан тоогоор)**

Сум	Газар доор, усан доор, аюултай өндөр газарт болон давчуу зайтай газар	Өндрөөс унах, шархдах, хоёр зүйлийн хооронд хавчуулагдах, юманд дарагдах эрсдэлтэй ажлын байранд	Хүнд ачаа өргөх, зөөх ажил	Хүнд эсвэл хурц үзүүртэй багаж хэрэглэх ажил	Түүлд шархдах, огтлогдох зэрэг эрсдэлтэй тулгардаг ажил	Аюултай амьтан болон шавьж хорхой ихтэй ажлын байранд	Ариун цэврийн шаардлага хангахгүй, өмхий эвгүй үнэртэй ажлын байранд	Хоргой болон бохирдсон ажлын байранд	Хоргой хий, химийн тэсрэх бодис, болон шатааг шигэн, аюултай материалтай харьцдаг ажил	Хэт их халуун, хүйтэн, их дуу чимээтэй, доргилт, эсвэл цацраг туяатай ажлын байранд	Хэт их тоосжилт, чийгтэй ажлын байранд <sup>84</sup>	Шене оройн цагаар	Эргэлдэх машин механизмтай, хөрөө ралтай харьцдаг ажлын байранд
Арвайхээр	3.2	11.7	34.0	28.7	8.5	8.5	68.1	20.2	63.8	77.7	92.6	8.5	-
Хархорин	-	12.5	87.5	62.5	25.0	12.5	62.5	37.5	12.5	87.5	87.5	12.5	-
Сүхбаатар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Алтанбулаг	9.4	9.4	62.5	-	-	18.8	-	-	9.4	40.6	50.0	28.1	-
Мандал	-	17.9	76.9	76.9	59.0	-	5.1	35.9	-	82.1	82.1	59.0	35.9
Дархан	-	-	33.3	-	11.3	-	33.8	-	-	88.8	66.7	10.8	-
Хэрлэн	12.2	9.0	38.2	9.0	30.2	3.1	15.3	12.2	-	76.7	72.2	9.0	-
Сайншанд	-	-	55.5	-	-	-	27.3	27.3	-	50.0	27.3	27.3	-
Замын-Үүд	-	-	75.0	-	25.0	-	-	75.0	-	-	-	-	-

Сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд өөрийн ажлын байрны нөхцөл хүнд, эрхлэж буй ажил нь эрүүл мэндэд нь эрсдэлтэйг ихэнх тохиолдолд мэддэг боловч ажлын байрандаа хөдөлмөр хамгааллын хэрэгсэлийг тэр болгон хэрэглэдэггүй байна.

Хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдэд эрхлэж буй ажлынх нь онцлогоос шалтгаалан хамгаалалтын малгай, нүдний шил, бээлий, усны гутал, амны хаалт зэрэг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл шаардлагатай байдаг боловч гол төлөв хамгаалалтын хэрэгсэл худалдан авахад зориулах мөнгө байдаггүйгээс худалдан авдаггүй байна<sup>85</sup>. Хүйтний улиралд гадаа хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдэд, даарч хөрөх бээрэх, хайрагдах, биеийнх нь аль нэгэн хэсэг хөлдөх зэрэг эрсдэлтэй тогтмол тулгарч байдаг тул тэдэнд дулаан хувцас нэн шаардлагатай байдгийг бүх сумдад хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд онцгойлон тэмдэглэсэн нь анхаарал татаж байгаа юм.

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БҮЙ ХҮҮХДҮҮДИЙН БОЛОВСРОЛ

Судалгаанд хамрагдсан аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн дийлэнх олон буюу 90-ээд хувь нь уншиж, бичиж чаддаг байна (Уншиж бичиж чаддаггүй хүүхдүүдийн 66 гаруй хувь нь хөвгүүд байна). Тус хот суурин газруудад бичиг үсэг тайлагдсан хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн эзлэх хувь Улаанбаатар хотод албан бус хэвшилд

<sup>84</sup> Худалдааны зах хэт их тоосжилттой байх явдал өргөнөөр дэлгэрсэн

<sup>85</sup> Хэрлэн суманд барилгын балгас нуураах (тоосго салгаж авах), балгаснаас хоёрдогч түүхий эд цуглуулж буй хүүхдүүдийн амь нас, эрүүл мэндэд онцгой эрсдэл гарч байгааг онцгойлон тэмдэглэх хэрэгтэй.



хөдөлмөр эрхлэж буй бичиг үсэг тайлагдсан хүүхдүүдийн эзлэх хувьтай харьцуулахад харьцангуй өндөр байгаад аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд харьцангуй ахлах насны, хүүхдүүдийн дунд сургуульд огт сурч байгаагүй хүүхдүүдийн эзлэх хувь бага зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна.

**Хүснэгт 67 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн боловсролын түвшин (хүүхдийн тоо, сумаар)**

Сум	Бүрэн дунд		Суурь боловсрол			Бага			Боловсролгүй				
	Нийт	Насын бүлэг	Нийт	Насын бүлэг		Нийт	Насын бүлэг		Нийт	Насын бүлэг			
		15-17		11-14	15-17		7-10	11-14		15-17	7-10	11-14	15-17
Арвайхээр	-	-	122	-	122	50	-	16	34	20	-	20	-
Хархорин	-	-	44	4	40	16	-	16	-	-	-	-	-
Сүхбаатар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Алтанбулаг	-	-	-	-	-	24	10	6	8	4	-	4	-
Мандал	10	10	3	-	3	29	-	-	29	-	-	-	-
Дархан	-	-	308	-	308	132	-	44	88	-	-	-	-
Хэрлэн	-	-	88	-	88	343	45	108	190	198	-	133	65
Сайншанд	-	-	91	-	91	19	-	13	6	-	-	-	-
Замын-Үүд	5	5	3	3	-	8	-	-	8	-	-	-	-

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн дунд суурь боловсрол эзэмшсэн хүүхдүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байгаа нь юуны өмнө хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн дунд 15-аас дээш настай хүүхдүүдийн эзлэх хувь өндөр, 15-аас дээш насны хүүхдүүдийн дунд 8-р анги төгсөөд үргэлжлүүлэн суралцаагүй<sup>86</sup> хүүхдийн тоо өндөр байгаатай холбоотой юм.

Сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй байдлыг Хүснэгт 68-т харуулав.

**Хүснэгт 68 Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн боловсрол эзэмшиж буй байдал (сумаар)**

Сум	Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн тоо	Боловсрол эзэмшиж буй байдал											
		ЕБС, албан бус боловсролын төвд сурч байгаа				Сургууль завсардсан				Огт суралцаж байгаагүй			
		Хөвгүүд		Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд		Охид	
		Тоо	Дүнд эзлэх хувь <sup>87</sup>	Тоо	Дүнд эзлэх хувь <sup>88</sup>	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Арвайхээр	210	43	25.0	129	75.0	20	52.6	18	47.4	-	-	-	-
Хархорин	60	36	66.7	18	33.3	6	100.0	-	-	-	-	-	-
Сүхбаатар	0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Алтанбулаг	30	6	27.3	16	72.7	-	-	8	100.0	-	-	-	-
Мандал	50	-	-	12	100.0	29	100.0	-	-	9	100.0	-	-
Дархан	440	176	44.4	220	55.6	-	-	44	100.0	-	-	-	-
Хэрлэн	720	125	49.0	130	51.0	332	85.8	55	14.2	55	70.5	23	29.5
Сайншанд	110	-	-	106	100.0	-	-	4	100.0	-	-	-	-
Замын-Үүд	15	5	38.5	7	61.5	3	100.0	-	-	-	-	-	-

Дорнод амйгийн Хэрлэн суманд албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй нийт хүүхдийн 54 орчим хувь нь сургууль завсардсан, 11 орчим хувь нь сургуульд огт суралцаагүй байна.

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэдэг сургууль завсардсан хүүхдүүдийн сургууль завсардахад, хүүхдүүд

Би 11 настай. Сургуульд огт сурч байгаагүй. Ээж эмээ хоёр намайг сургуульд сургана гэж ярьдаггүй ш дээ. Манайхыг Хөлөнбуйрт байхад аав маань нас барсан. Аавыг өнгөрсөнөөс хойш манайд мөнгө олох хүнгүй болсон. Манайх айлын мал малладаг байж байгаад аймгийн төв рүү нүүж ирсэн. Би ихэвчилэн зах дээрээс цэвэр ус, ундааны сав, пивоны лааз, шил цуглуулж тушаадаг. Ээж маань хуучин барилга дээрээс тоосго буулгаж зардаг. Би өглөө 10 гэж гэрээсээ гараад зах хаатал орой 19 цаг хүртэл түүдэг. Өвөл шил лааз түүхэд их даардаг. Зуны халуунд ам их цангадаг. Хааяа тушаасан мөнгөөрөө өлсөөд байхаар нь 100-ийн боов, 100-ийн ундаа авч уудаг. Би сургуульд сураад багш болно гэж боддог.

**Чойбалсан хот**

<sup>86</sup> Хөдөө орон нутагт суурь боловсрол эзэмшсэн хүүхэд үргэлжлүүлэн ЕБС-д эсвэл МСҮТ-д суралцах боломж Улаанбаатар хотод амьдарч буй хүүхдийнхтэй харьцуулахад хязгаарлагдмал.

<sup>87</sup> Тухайн суманд хөдөлмөр эрхлэж буй нийт хөвгүүдийн дүнд эзлэх хувь

<sup>88</sup> Тухайн суманд хөдөлмөр эрхлэж буй нийт охидын дүнд эзлэх хувь

сургуульд огт суралцаагүйд дараах хүчин зүйлс<sup>89</sup> нөлөөлдөг байна. Үүнд:

- Хүүхдэд сургуульдаа явахад шаардагдах хичээлийн хэрэгсэл, хувцас зэрэг зардлыг тухайн өрхийн санхүүгийн байдалд<sup>90</sup> хүндрэл бэрхшээл (өрхийн гишүүний нэг нь хөдөлмөр эрхлэхээ ямар нэгэн шалтгааны улмаас болих, өрхийн эрхлэж буй аж ахуйн ашиг багасах гэх мэт) тулгарсан тохиолдолд санхүүжүүлэх боломжгүй болдог;
- Хүүхдийн хөдөлмөрөөр олж буй орлого өрхөд зайлшгүй шаардлагатай<sup>91</sup> болдог тул хүүхэд сургуульд суралцах цаг завгүй болдог;
- “Одоогийнхоос илүү (уншиж, бичих чадвараас) боловсрол шаардлагагүй” гэсэн ойлголт нь хүүхдийн дунд өргөн дэлгэрсэн;
- “Хүүхэд боловсрол эзэмших шаардлагатай” гэдэг ойлголт эцэг эхчүүдийн дунд тэр болгон байдаггүй<sup>92</sup>.

## **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНД**

### **Өвчлөл**

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 15 хувь, тэдний эцэг эхийн 68 орчим хувь нь тус тус “эрхлэж буй хөдөлмөрийн үр дагаварт эрүүл мэнд нь ямар нэгэн байдлаар муудсан” гэж тодорхойлж байв.

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 76 хувь нь Эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй байв.

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд хөдөлмөр эрхлэхтэй холбоотойгоор гол төлөв амьсгалын замын өвчин<sup>93</sup>, шээс ялгаруулах тогтолцооны өвчин, төрөл бүрийн харшлаар өвчилдөг байна. Хүүхдүүдийн дээрх өвчинд өртөмтгий байдалд дараах хүчин зүйлс шууд болон шууд бус байдлаар нөлөөлдөг байна:

- Хүүхдүүдийн хөдөлмөрийн орчин эрүүл ахуйн шаардлагыг тэр болгон хангадаггүй;
- Хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүд хүйтний улиралд даарч хөрдөг байдал.

### **Осол гэмтэл**

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 17 орчим хувь нь хөдөлмөр эрхлэх явцдаа эрхлэж буй ажилтайгаа холбоотойгоор гэмтэж (шарх, зөөлөн эдийн няцралт, хугаралт) бэртэж байсан байна. Мөн хүүхдүүдийн гурав гаруй хувь нь хүйтний улиралд гадаа хөдөлмөр эрхлэсний үр дагаварт ямар нэгэн эрхтнээ (гол төлөв хацар, чих, хуруу) хөлдөөж байжээ.

## **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ЧӨЛӨӨТ ЦАГ**

Сонгогдсон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 74 гаруй хувьд нь долоо хоногт зав, чөлөөтэй өдөр гардаг байна.

Аймаг, сумын төвд оршин суудаг хүүхдүүдийн хувьд чөлөөт цагаа аюулгүй тайван орчинд сонирхолтойгоор өнгөрүүлэх боломж хомс байдаг нь хүүхдүүдийн хөгжилд тодорхой хэмжээгээр хязгаарлалт болдог байна.

<sup>89</sup> Нөлөөллөөр эрэмбэлэв

<sup>90</sup> Өрхийн орлого багатай өрхийн санхүү тогтворгүй байдаг

<sup>91</sup> Хүүхдийн орлого, хөлс нь өрхийн санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөхүйц хэмжээтэй байдаг

<sup>92</sup> Энэхүү ойлголтонд ийм хандлагатай байгаад нь тэдний өөрсдийн боловсролын түвшин тодорхой хэмжээнд нөлөөлдөг байна

<sup>93</sup> Хүйтний улиралд, томууны халдварын тархалтын үед

## **ТАВДУГААР БҮЛЭГ. ЗӨВЛӨМЖ**

**Судалгааны багийнхан судалгааны явцад цуглуулсан мэдээлэл дээр дүн шинжилгээ хийсний эцэст Улаанбаатар хот болон аймгийн төв, сумдын албан бус хэвшил дэх хүүхдийн хөдөлмөрийг бууруулах, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн дараах зөвлөмж, саналуудыг дэвшүүлж байна:**

**Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль сахиулах:**

- Татварын тогтолцоонд өөрчлөлт оруулан албан бус хэвшилд үйл ажиллагаа явуулж буй иргэд албан хэвшилд шилжин орох боломжийг нэмэгдүүлэх;
- Төрийн бүх түвшний байгууллага, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудын хөдөлмөрийн хяналтын тогтолцоог бэхжүүлж хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлүүлэхээс сэргийлэхэд чиглэсэн хуулийн хэрэгжилтийн хяналтанд түлхүү оролцуулах;
- Хөдөө орон нутгаас шилжин ирэгсэдийг нийгмийн халамж, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжийг дээшлүүлэхийн тулд тэднийг оршин сууж буй хороонд нь албан ёсоор бүртгэх тогтолцоог хялбаршуулах;
- Суурь боловсрол заавал эзэмшүүлэх талаарх хууль эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэнд төрийн зүгээс тавих хяналтыг сайжруулах;

**Өрхийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, орлогыг тогтворжуулах:**

- Хүүхдийн хөдөлмөрийн чадвартай эцэг эх/асран хамгаалагчийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ (ажилд зуучлах, хувиараа бизнес эрхлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, мэргэжлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх, мэргэжил олгох) авах;
- Өрхийн амьжиргааны түвшин, орлогыг нэмэгдүүлэх, тогтворжуулахад чиглэсэн өргөн хүрээний арга хэмжээ авах (иргэнийг хөдөлмөрлөх, бизнес эрхлэхийг дэмжсэн арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд гэвч тус арга хэмжээнүүд нь зарим талаар бэлэнчлэх сэтгэлгээ үүсэх нөхцлийг бүрдүүлэх эрсдэлтэйг анхаарах шаардлагатай);

**Иргэдийн хандлагыг өөрчлөх, ойлголтыг нэмэгдүүлэх:**

- Эцэг эх/асран хамгаалагчдын хүүхдийн хөдөлмөр, боловсролд хандах хандлагыг өөрчлөхөд чиглэсэн цогц үйл ажиллагаа явуулах;
- Ажил олгогчдын хүүхдийн хөдөлмөрт хандах хандлагад өөрчлөлт оруулахад чиглэгдсэн цогц үйл ажиллагаа явуулах;

**Боловсролын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх:**

- Сургууль завсардсан, сургуульд огт суралцаагүй хүүхдүүдийг албан бус боловсролд хамруулан тэдний ЕБС-д дэвшин суралцах боломжийг нэмэгдүүлэх;
- ЕБС-д сурч буй хүүхдээс албан болон албан бус хэлбэрээр төрөл бүрийн хураамж, хуримтлал цуглуулдаг тогтолцоог эрх зүйн зохицуулалт хийн арилгах;
- Хөдөө орон нутгаас шилжин ирсэн өрхийн хүүхэд ЕБС-д суралцахад тулгарч буй хүндрэл, бэрхшээлүүдийг арилгах;
- Хөдөө орон нутагт суурь боловсрол эзэмшсэн хүүхдүүд үргэлжлүүлэн суралцаж бүрэн дунд болон мэргэжлийн анхан шатны боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэх.

## ХАВСРАЛТУУД

### ХАВСРАЛТ # 1

Эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа эрхлэж буй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн бүртгэлийн маягт

Огноо:

Судлаач:

#	Байршил	Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн нэр	Үйл ажиллагааны төрөл	7-17 насны хүүхэд ажилладаг Тийм: 1 Үгүй: 2	Сонгогдох эрх Q1=1 бол КОД: 1 Q1=2 бол КОД: 2	Түүврийн дугаар Q6=1	Түүвэрлэгдсэн дугаар
1	2	3	4	5	6	7	8

## ХАВСРАЛТ # 2

Өрхийн бүртгэлийн маяг

Огноо:

Судлаач:

Хот/аймаг:

Дүүрэг/сум:

Хороо/Баг:

Хэсгийн нэр/дугаар:

#	Хаяг	Өрхийн тэргүүлэгчийн нэр	7-17 насны хүүхэдтэй эсэх: Тийм:1 Үгүй: 2 2-дуусах	Хүүхдийн нэр	Хөдөлмөр эрхэлдэг эсэх: Тийм:1 Үгүй: 2 2-дуусах	Тогтмол ажлын байртай эсэх: Тийм:1>9 Үгүй: 2	ААН, хувиараа хөдөлмөр эрхлэгчид тогтмол ажилладаг эсэх: Тийм:1 Үгүй:2	ААН, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн үйл ажиллагааны чиглэл (код ашиглана уу)	Сонгох эрх: КОД=1 хэрэв Q7=2Q8=1; Эсвэл Q8=1 Үгүй бол КОД=2	Сонгогдсон хүүхдийн ажилладаг байгууллагын үйл ажиллагааны чиглэл Q9 КОД=1	Хүүхтүүврийн дугаар
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

### ХАВСРАЛТ # 3

### Хөдөлмөр эрхлэж буй хүүхдээс мэдээлэл цуглуулах санал асуулгын асуумжийн загвар

Хувийн нууцын тухай, Статистикийн тухай хуулиудын дагуу Таны өгсөн мэдээллийг судалгааны багийн гишүүд чандлан хадгална

Шивэлтийн дугаар:

#### ХҮҮХДИЙН АСУУЛГА

7-18 насны хөдөлмөр эрхлэдэг хүүхдээс асууна

НЭГ. ӨРӨНХИЙ АСУУЛГА		Код
№		
1.	ТАШН-ийн дугаар:	
2.	Аймаг/нийслэл:	
3.	Сум/дүүрэг:	
4.	Байршил <ol style="list-style-type: none"> <li>1. Нийслэл</li> <li>2. Аймагийн төв</li> <li>3. Сумын төв</li> </ol>	
5.	Баг/хороо:	
6.	Ажлын байрны түүврийн дугаар:	
7.	Хүүхдийн дугаар:	
8.	Өрхийн тэргүүлэгчийн нэр/ ажлын байрны нэр:	
9.	Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагааны салбар: <ol style="list-style-type: none"> <li>1. ХАА, ан агнуур, ойн аж ахуй</li> <li>2. Загас барилт</li> <li>3. Уул уурхай олборлох аж үйлдвэр</li> <li>4. Боловсруулах аж үйлдвэр</li> <li>5. Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж</li> <li>6. Барилга</li> <li>7. Бөөний, жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ</li> <li>8. Зочид буудал, зоогийн газар</li> <li>9. Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо</li> <li>10. Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа</li> <li>11. Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа</li> <li>12. Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал</li> <li>13. Боловсрол</li> <li>14. Эрүүл мэнд, нийгмийн халамж</li> <li>15. Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ</li> <li>16. Бусад(бусад тодруулна уу):</li> </ol>	
10.	Хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн овог: .....	
11.	Хүйс 1. эрэгтэй 2. эмэгтэй	
12.	Хүүхдийн нас: (бүтэн насаар).....	

ХОЁР. СУДАЛГААНЫ ХЯНАЛТЫН ХЭСЭГ				
	1	2	3	4
Огноо:				
Ярилцагчийн нэр:				
Ахлагчийн нэр:				
Ярилцлагын үр дүн*				
Дараагийн үүлээлт				
*Үр дүнгийн код:				
<ol style="list-style-type: none"> <li>1. Бүрэн дууссан</li> <li>2. Хариулт өгөх хүн байгаагүй</li> <li>3. Өрх эзгүй байсан</li> <li>4. Хойшуулсан</li> <li>5. Татгалзсан</li> <li>6. Бусад (тодруулна уу).....</li> </ol>				

ГУРАВ. ӨРХИЙН ГИШҮҮДИЙН БАЙДАЛ				
(Хүүхэд нь гэртээ амьдардаг, амьдардаггүй үл харгалзан өрхийн бүх гишүүдийн мэдээллийг авсан байна)				
Хүний нэр	Өрхийн гишүүдийн нэр	Ажил хийж буй хүүхэдтэй ямар хамааралтай вэ (Доорхи кодыг ашиглана уу)*	Хүйс 1. Эрэгтэй 2. Эмэгтэй	Гэртээ амьдардаг уу? 1. Тийм 2. Үгүй
А	Б	1	2	3
1.				
2.				
3.				
4.				
5.				
6.				
7.				
8.				
9.				
10.				

\* Код

Багана 1: Ажил хийж буй хүүхэдтэй хамаарах хамаарал:

1. Эцэг
2. Эх
3. Өөрөө
4. Хойд эцэг/эх
5. Хадан эцэг/эх
6. Ах/эгч/дүү
7. Өвөө/эмээ
8. Авга/нагац
9. Эхнэр/нөхөр
10. Хүү/охин
11. Бусад төрөл төрөгсөд
12. Хамааралгүй

<sup>94</sup> Өрхийн тэргүүлэгчээс эхэлж хариулна

**ДӨРӨВ. ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ОДООГИЙН АМЬДРАЛЫН НӨХЦӨЛ**

1. **Та эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй юу?**
  - 1.1. Тийм
  - 1.2. Үгүй
2. **Та уншиж бичиж чаддаг уу?** (Хэрэв эргэлзэж байвал, энгийн зурвас уншуулж бичүүлж шалгаж болно)
  - 2.1. Тийм
  - 2.2. Үгүй
3. **Та сургуульд суралцаж байсан уу?**
  - 3.1. Сурч байгаа
  - 3.2. Суралцаж байсан
  - 3.3. Огт суралцаж байгаагүй >7 руу
4. **Таны бүрэн төгссөн анги/эзэмшсэн боловсролын түвшин:**
  - 4.1. Дээд
  - 4.2. Тусгай дунд бүрэн бус дээд
  - 4.3. Техник мэргэжлийн анхан шатны
  - 4.4. Бүрэн дунд
  - 4.5. Бүрэн бус дунд
  - 4.6. Бага
  - 4.7. Боловсролгүй
5. **Одоо ямар нэгэн сургууль/курс/коллежид суралцдаг уу?**
  - 5.1. Тийм > 8 руу
  - 5.2. Үгүй
6. **Та яагаад сургуульд сурч чадаагүй вэ?** (3 хүртэлх хүчин зүйлсийг дугуйлна уу)
  - 6.1. Суралцах сонирхолгүй байсан
  - 6.2. Өрх баг, хороондоо бүртгэлгүй байсан тул сургуульд аваагүй байсан
  - 6.3. Хичээлийн хэрэгсэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадахгүй
  - 6.4. Сургууль хол
  - 6.5. Сургуулиас шаардах мөнгөн болон мөнгөн бус хандивийг өгөх боломжгүй
  - 6.6. Өрхийн орлогод нэмэр болох зорилгоор ажил хийдэг
  - 6.7. Гэрийн ажилд туслах
  - 6.8. Өвчтэй байсан
  - 6.9. Эцэг, эх сургуульд явуулдаггүй байсан
  - 6.10. Одоогийнхоос илүү боловсрол хэрэггүй
  - 6.11. Бусад (тодруулна уу).....
7. **Ямар шалтгааны улмаас сургуульд ОГТ суралцаагүй вэ?** (3 хүртэлх гол хүчин зүйлсийг дараалуулан тэмдэглэнэ үү)

Код	1	2	3
-----	---	---	---

  - 7.1. Эцэг, эх сургуульд явуулаагүй
  - 7.2. Өрх баг, хороондоо бүртгэлгүй байсан тул сургуульд аваагүй байсан
  - 7.3. Хичээлийн хэрэгсэл, хувцас зэрэг зардлыг гаргах чадваргүйгээс
  - 7.4. Өрхийн аж ахуйн ажилд тусалдаг/ ажилладаг
  - 7.5. Өрхийн орлогод нэмэр болох зорилгоор бусдад ажил хийдэг
  - 7.6. Өвчтэй байсан
  - 7.7. Сургууль хол учраас
  - 7.8. Бусад (тодруулна уу).....
8. **Одоо хэнтэйгээ цуг амьдарч байна вэ?**
  - 8.1. Ажил олгогчтойгоо
  - 8.2. Хамт ажиллагчтайгаа
  - 8.3. Эцэг эх, гэр бүлийн гишүүдтэйгээ >10 руу
  - 8.4. Хамаатан садантайгаа
  - 8.5. Ганцаараа
  - 8.6. Бусад (тодруулна уу).....
9. **Та ажил хийж эхэлснээс хойш гэрийнхэнтэйгээ ямар холбоотой байна вэ?**
  - 9.1. Ямар ч холбоогүй
  - 9.2. Гэртээ очдог
  - 9.3. Утсаар ярьдаг
  - 9.4. Захиа бичдэг
  - 9.5. Хамаатнаар хэл дуулгадаг
  - 9.6. Гэрийнхэн над дээр ирдэг
  - 9.7. Бусад (тодруулна уу).....
10. **Танай өрхийн амьдардаг сууцны төрөл:**
  - 10.1. Орон сууц
  - 10.2. Сууцны тусдаа байшин
  - 10.3. Нийтийн байр
  - 10.4. Гэр
  - 10.5. Орц (хоноглодог)
  - 10.6. Траншей
  - 10.7. Орцны жижүүрийн байр
  - 10.8. Урц, овоохой
  - 10.9. Бусад (тодруулна уу).....
11. **Танай өрхийн сууцны өмчийн хэлбэр:**
  - 11.1. Төрийн өмчийн
  - 11.2. Аж ахуйн нэгж байгууллагын
  - 11.3. Хувийн өмчийн
  - 11.4. Түрээсийн:.....сард төлдөг төлбөрийн хэмжээ
  - 11.5. Бусад (тодруулна уу).....
12. **Танай өрх гэр,байшинд амьдардаг бол газраа хувьчилж авсан уу?** (Хэрэв байшинд амьдардаг бол асуулт 14 руу шилжинэ үү)
  - 12.1. Тийм
  - 12.2. Үгүй
  - 12.3. Мэдэхгүй

13. **Гэрийн бүтэц:** (зөвхөн гэрт амьдардаг хүмүүс хариулна)
- 13.1. Бүрээс
- 13.1.1. Дан
- 13.1.2. Давхар
- 13.1.3. Мэдэхгүй
- 13.2. Шал
- 13.2.1. Шалтай
- 13.2.2. Шалгүй
14. **Халаалтын төрөл**
- 14.1. Төвлөрсөн
- 14.2. Төвлөрсөн бус
- 14.3. Ердийн
- 14.3.1. Мод
- 14.3.2. Нүүрс
- 14.3.3. Аргал, хомоол
- 14.3.4. Хог (шатаж болох зүйл хаймар гэх мэт)
15. **Танайд дараах зүйлс байдаг уу?** (нэгээс илүү хариулт байж болно)
- 15.1. Цахилгаан гэрэлтэй
- 15.2. Зурагт
- 15.3. Хөргөгч
- 15.4. Плитка
- 15.5. Бүгд байхгүй
16. **Та шөнө хэнтэй унтдаг вэ?**
- 16.1. Өвөө, эмээ
- 16.2. Аав
- 16.3. Ээж
- 16.4. Ах, эгч, дүү
- 16.5. Ганцаараа
- 16.6. Хамт ажиллагчтайгаа
- 16.7. Хэнтэй ч хамаагүй
- 16.8. Бусад (тодруулна уу).....цаг
17. **Та хоногт хэдэн цаг унтдаг вэ?:**.....цаг
18. **Танд өөрийн гэсэн дараах зүйлс байдаг уу?** (нэгээс илүү хариулт байж болно)
- 18.1. Ор
- 18.2. Хөнжил
- 18.3. Гудас
- 18.4. Дэр
- 18.5. Бүгд байхгүй
19. **Танайх үндныхаа усыг хаанаас авдаг вэ?**
- 19.1. Төвлөрсөн: -халуун, хүйтэн устай
- 19.2. Төвлөрсөн:-зөвхөн хүйтэн устай
- 19.3. Зөөврийн ус
- 19.4. Гүнийн худаг
- 19.5. Худаг
- 19.6. Гол,булаг
- 19.7. Бусад (тодруулна уу):.....
20. **Танд хэн нэгэнд төлөх өр, эзэл бий юу?**
- 20.1. **Тийм**
- 20.1.1. Гэрийнхэндээ
- 20.1.2. Ажил олгогчдоо
- 20.1.3. Хамт ажилладаг хүндээ
- 20.1.4. Найз нөхөддөө
- 20.1.5. Хамаатан садандаа
- 20.1.6. Бусад (тодруулна уу).....
- 20.2. **Үгүй** >22 руу
21. **Хэр зэрэг удаан ажиллаж байж өрөө төлж дуусгах вэ?**
- 21.1. Жил:.....
- 21.2. Сар:.....
- 21.3. Хоног:.....
22. **Ажил олгогч чинь танайг ажиллуулах сонирхолтой гэж бодож байна уу?**
- 22.1. Тийм
- 22.2. Үгүй
- 22.3. Мэдэхгүй

**ТАВ. ОДОО ХИЙЖ БҮЙ АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

23. **Та яагаад хөдөлмөр эрхлэх болсон бэ?** 3 гол хүчин зүйлээр эрэмблэн бичнэ үү
- 23.1. Эцэг эх өртэй байсан
- 23.2. Эцэг, эх өвчтэй, ажил хийж чадахгүй байсан тул
- 23.3. Өрхийн орлогод нэмэр болох
- 23.4. Өрхөд орлого олох өөр хүн байхгүй
- 23.5. Өрхөд өөр орлогын эх үүсвэр байхгүй тул
- 23.6. Ажлын дадлага туршлагатай болох
- 23.7. Өөрийгөө авч явах, эдийн засгийн хувьд бие даах
- 23.8. Сургуульд сурах зардлаа олох
- 23.9. Эцэг, эхийн шахалтаар
- 23.10. Өөрийн сонирхолоор (санхүүгийн бус шалтгаанаар)
- 23.11. Гэрээсээ зугтсан, хөөгдсөн
- 23.12. Бусад (тодруулна уу).....
24. **Та энэ ажлаа ямар хугацаагаар хийж байна вэ?**
- 24.1. Жил:.....
- 24.2. Сар:.....
- 24.3. Хоног:.....

Код

1	2	3



25. **Танд энэ ажилд орох саналыг хэн тавьсан вэ?**

- 25.1. Эцэг
- 25.2. Эх
- 25.3. Хамаатан, садан
- 25.4. Зуучлагч
- 25.5. Өөрөө
